

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 5 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 5 дугаар сарын 06-ны өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 7
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8 – 113
1.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/</i>	12 – 14
2.	<i>Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төсөл /Засгийн газар 2026.04.22-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/</i>	14 – 23
3.	<i>“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/</i>	23 – 75
4.	<i>Монголбанкны 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, Хяналтын зөвлөлийн тайлан</i>	75 – 113

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 05 дугаар сарын 06-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 68.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 26 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: М.Мандхай;

Чөлөөтэй: П.Батчимэг, Г.Уянгахишиг;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Цэнгүүн;

Тасалсан: Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд 14 цаг 45 минутаас хуралдааныг даргав.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Монголбанкны Ерөнхийлөгчид тавьсан асуулгын хариуг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Л.Соронзонболд: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 10

Бүгд: 23

56.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Монголбанкны 2025 оны санхүүгийн тайланг хэлэлцэх асуудлыг долоо хоногоор хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Л.Соронзонболд: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 15

Бүгд: 23

34.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж “Цаглавар батлах тухай” асуудлыг хэлэлцэх асуудлын нэгд оруулах гэсэн горимын санал гаргав.

Л.Соронзонболд: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Б.Ууганцэцэг, Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Л.Соронзонболд: “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төсөл /Засгийн газар 2026.04.22-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн шинжээч Х.Еркегүл, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Анх-Оргил, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга

М.Баяраа, мөн яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Ням-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Б.Ууганцэцэг, Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ж.Ганбаатар, А.Ундраа нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Ням-Очир нар хариулж, тайлбар хийв.

Л.Соронзонболд: Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг зөвшилцөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 10

Бүгд: 23

56.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. *“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга П.Сарангэрэл, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Гэр бүл,

хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баярмагнай, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга В.Жавзан, Ёс зүйн хорооны ажлын албаны дарга Н.Ганбаатар, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал Н.Ургамалсувд, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, мөн хорооны Эдийн засгийн статистикийн газрын дарга М.Оюунжаргал, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал Б.Баттуяа, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ш.Наранбаатар, Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны дарга С.Цогтгэрэл, мөн хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, мөн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, мөн газрын Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Туяа, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Э.Оюунсүрэн, Боловсролын яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, зохицуулалтын газрын Захиалагчийн хэлтсийн дарга Н.Амарбаяр, Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах шинжээч Ч.Батболд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал Б.Даваадалай, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Р.Рэнцэнбазар, Н.Ууганбаатар, А.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Б.Ууганцэцэг, Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Төслийн талаар Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд хийсэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан нар танилцуулав.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Б.Пунсалмаа, С.Эрдэнэбат, Ж.Ганбаатар, О.Батнайрамдал, М.Энхцэцэг нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баярмагнай, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга В.Жавзан, Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал Н.Ургамалсүвд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар үг хэлэв.

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Монголбанкны 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, Хяналтын зөвлөлийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, мөн банкны Санхүү, удирдлагын газрын захирал Б.Батбаяр, Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал Н.Ургамалсүвд, Санхүүгийн зах зээл, валютын газрын захирал П.Мөнхбаяр, Эрсдэлийн удирдлага, дотоод аудитын газрын захирал Д.Баянзул, Санхүүгийн тогтвортой байдлын газрын захирал Б.Амгалан, Санхүүгийн тогтвортой байдлын газрын Тогтвортой хөгжил,

ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн захирал Л.Эвшинхорлоо, Монголбанкны ерөнхий менежер С.Цэрэннадмид, Хуулийн газрын Эрх зүйн бодлого, судалгааны хэлтсийн захирал Б.Эрдэнэхуяг, Санхүү, удирдлагын газрын Бодлого, төсөв, тайлагналын хэлтсийн захирал Э.Жавхлан, Стратеги төлөвлөлтийн албаны ахлах референт Н.Батсайхан, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга Н.Ууганбаатар, мөн зөвлөлийн гишүүн Г.Эрдэнэбаяр, У.Хосжаргал, С.Лхагвадорж, Д.Энхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Б.Ууганцэцэг, Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Монголбанкны 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, Монголбанкны Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг Хяналтын зөвлөлийн дарга Н.Ууганбаатар нар танилцуулав.

Монголбанкны санхүүгийн тайлан болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, Б.Пунсалмаа, С.Эрдэнэбат, Д.Үүрийнтуяа, Ж.Ганбаатар, О.Батнайрамдал, Ж.Золжаргал, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, мөн банкны Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал Н.Ургамалсүвд, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга Н.Ууганбаатар нар хариулж, тайлбар хийв.

Монголбанкны 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон Хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэж дууслаа.

Уг асуудлыг 18 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 17 минут үргэлжилж, 32 гишүүнээс 25 гишүүн хүрэлцэн ирж, 78.1 хувийн ирцтэйгээр 18 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 5 дугаар сарын 06-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 26 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа Улсын Их Хурлын гишүүдийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар, Цэндийн Баатархүү, Ринчиндоржийн Батболд, Отгоншарын Батнайрамдал, Нацагдоржийн Батсүмбэрэл, Хүрэлбаатарын Булгантуяа, Жамбалын Ганбаатар, Болдын Жавхлан, Батбаярын Жаргалан, Батжаргалын Заяабал, Ганзоригийн Лувсанжамц, Баатаржавын Мөнхсоёл, Эрдэнэбилэгийн Одбаяр, Ганбатын Очирбат, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Сүхбаатарын Эрдэнэбат, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 68.8 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

— **Нэг.** Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг зөвшилцөх.

Засгийн газраас 2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр зөвшилцөхөөр ирүүлсэн санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

— **Хоёр.** “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн. Нэг дэх хэлэлцүүлэг.

— **Гурав.** Монголбанкны 2025 оны санхүүгийн тайлан.

Улсын Их Хуралд 2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр ирүүлсэн. Хэлэлцэх.

— **Дөрөв.** Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцаас Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Монголбанкны Ерөнхийлөгчид тавьсан асуулгын хариу.

— **Тав.** Байнгын хорооны тогтоолын төсөл. “Цаглавар батлах тухай”.

Эдгээр хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай Улсын Их Хурлын гишүүд байна уу? Г.Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. 2025 онд баталсан Улсын Их Хурлын 57 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар асуулгын хариуг хэлэлцье гэсэн саналыг оруулсан.

Тэгээд өнөөдөр 4 байгууллагын удирдлагууд хүрч ирж асуултад хариулах ёстой боловч Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажлын албаны дарга С.Даваасүрэн гадаад томилолттой байгаа учраас өнөөдөр энэ асуулгад хариулах боломжгүй байгаа.

Тэгэхээр энэ хэлэлцэх асуудлыг ирэх долоо хоногийн Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлэхээр хойшлуулж өгнө үү гэж горимын санал гаргаж байна.

Р.Сэддорж: Г.Лувсанжамц гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалтад орж ирье. Гишүүдийг хуралдааны танхимд ирэхийг урьж байна. Энэ хооронд дараагийн гишүүн горимын санал гаргасан Б.Заяабал гишүүн.

Б.Заяабал: Баярлалаа. Тэгэхээр би хэлэлцэх асуудлын гурав дээр байгаа Монголбанкны санхүүгийн тайлан, аудитын санал, дүгнэлт, Хяналтын хорооны санал, зөвлөмжүүдийг хэлэлцэх асуудлыг бас ирэх долоо хоног хүртэл хойшлуулах горимын санал гаргах гэж байгаа юм.

Тэгэхээр Монголбанкны тухай хуулийн 30.3 дээр яг энэ санхүүгийн тайлан, аудитын санал, дүгнэлт, Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжүүдийг Улсын Их Хуралд танилцуулдаг.

Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 115.2.4-өөр Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэнэ гээд заачихсан. Тодорхой хугацаа байхгүй. Ийм хэлэлцдэг хуулийн зохицуулалттай.

Өнөөдрийн яагаад хойшлуулж байгаа юм бэ гэхээр зэрэг нэгдүгээрт тараагдсан материалууд би бүрэн авч чадаагүй байна. Монголбанкны вебсайтаар олон нийтэд Монголбанк банкны санхүүгийн тайлан, аудитын санал, дүгнэлт өчигдөр албан ёсоор вебсайт нь цахим нээлттэй тавигдсан. Өчигдөр гишүүдэд ном нь тараагдсан байгаа.

Тэгэхээр үүнийг уншиж судлах зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа.

Өнөөдөр Монголбанкны бүтэц, бүрэлдэхүүн 2025 онд бид Хяналтын зөвлөлийг шинээр баталж томилсон.

Дээрээс нь оны сүүлээр Монголбанкны Ерөнхийлөгчийг шинээр томилсон.

Тэгэхээр шинээр ажил авч байгаа эдгээр хамт олны өмнө Монголбанкны яг ямархуу ажлыг хүлээж авч байгаа юм бэ гэдгийг бид нэлээд уншиж танилцсаны үр дүнд сайн ярилцах шаардлагатай гэж үзэж байгаа.

Тайлан дээр ерөнхийдөө товч байдлаар дурдсан товч танилцуулгыг нь зүгээр халти уншихад Монголбанкны хуримтлагдсан алдагдал 6.8 их наяд. Монголбанкны өөрийн хөрөнгө хасах 4.8 их наяд хүрчихсэн. Актив нь харьцуулж танилцуулсан 6 орны Төвбанкны санхүүгийн тайланг харьцуулсан товч танилцуулгыг нь харахад хамгийн их активын өсөлттэй ийм банкаар одоо жишээлбэл Монголбанк шалгарсан гэх мэтчилэн ийм нэлээдгүй анхаарал хандуулсан ийм зүйлүүд байгаа.

Өр авлага, өөрийн хөрөнгө гээд нэлээдгүй асуудлуудыг уншиж танилцах.

Ялангуяа шинэ удирдлагууд, Монголбанкны шинэ удирдлагууд, Хяналтын зөвлөлийн шинэ удирдлагуудыг ямархуу ажил авч байгаа юм бэ, ямархуу цэгээс ажлаа эхэлж байгаа юм бэ гэдгийг нэлээн дэлгэрэнгүй ярих шаардлагатай гэж үзэж байгаа.

Тийм учраас энэ долоо хоногийн хэлэлцэх асуудлаас долоо хоногоор хойшлуулж өгнө үү гэж горимын саналыг гаргаж байна. Санал хураалгаж өгнө үү. Баярлалаа.

Р.Сэддорж: Ингээд хэлэлцэхээр товлосон энэ долоо хоногийн тов дарааллыг Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс баталсан.

Үүнээс хэлэлцэх асуудлын тав дээр байгаа Эдийн засгийн байнгын хорооны 5 дугаар сард хэлэлцэх асуудлын “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлыг нэгдүгээрт оруулж хэлэлцье гэсэн саналтай байна.

Учир нь Байнгын хороо 5 сард хуралдаж байгаа эхний хурал. Тиймээс 5 сард хэлэлцэх асуудлаа хамгийн эхлээд хэлэлцэх нь зүйтэй.

Энэ дагуу “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлын эхэнд оруулах горимын санал гаргаж байна.

Ингээд нийт гишүүдийн гаргасан гурван саналаар санал хураалт тус тусад нь явуулна. Санал хураалтаар дэмжигдвэл энэ өөрчлөлтүүд орно.

Ингээд ирцэд орсон гишүүд танхимд орж ирэхийг урьж байна.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүд танхимд яаралтай орж ирэхийг урьж байна.

Байнгын хорооны хуралдааныг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд үргэлжлүүлэн удирдаж явуулна.

Л.Соронзонболд: Байнгын хорооны гишүүд эхлээд Г.Лувсанжамц гишүүний гаргасан асуулгыг хойшлуулах тухай горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтдаа бэлдье.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцаас Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Монголбанкны Ерөнхийлөгчид тавьсан асуулгын хариуг хойшлуулах горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

23 гишүүнээс 13 гишүүн буюу 56.5 хувийн саналаар энэхүү санал дэмжигдлээ. /алх цохив/

Дараагийн горимын санал. Б.Заяабал гишүүнээс Монголбанкны 2025 оны санхүүгийн тайлангийн хэлэлцэх асуудлыг нэг долоо хоногоор хойшлуулах горимын санал гаргасан. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Б.Заяабал гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Гишүүд бэлдээгүй байхад санал хураалтыг зарлачихлаа.

Тийм учраас саяын саналын хураалтыг хүчингүй болгоё.

Гишүүд санал хураалтдаа бэлдье. Гишүүд ээ, хэд хэдэн гишүүн санал хураалтдаа бэлдээгүй байгаад байна. Хэд хэдэн гишүүд санал хураалтдаа бэлдээгүй байна.

Тийм учраас гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан Монголбанкны 2025 оны санхүүгийн тайланг хэлэлцэх асуудлыг долоо хоногоор хойшлуулах горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

23 гишүүнээс 8 гишүүн буюу 34.8 хувийн саналаар Б.Заяабал гишүүний санал дэмжигдсэнгүй.

Дараагийн горимын саналыг хэлэлцье.

Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржоос Байнгын хорооны тогтоолын төслийг буюу Байнгын хорооны “Цаглавар батлах тухай” асуудлыг хэлэлцэх асуудлын нэгд оруулж шийдвэрлэе гэсэн ийм горимын санал гаргасан. Гишүүд санал хураалтаа бэлдье.

Хэлэлцэх асуудлын тавд байгаа Байнгын хорооны тогтоолын төсөл батлах тухай асуудлыг хэлэлцэх асуудлын нэгд оруулах тухай Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржоос гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

23 гишүүнээс 13 гишүүн буюу 56.5 хувийн саналаар энэхүү горимын санал дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Цаглавар батлах тухай/

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл батлах тухай. Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын “Цаглавар батлах тухай” асуудал байгаа.

“Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын “Цаглавар батлах тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 179 дүгээр захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай.

2.Хэлэлцэх хугацааг хуульд тусгайлан заасан болон бусад Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3.Энэ тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд хэлэлцэх асуудлын бэлтгэл хангах, мэргэжил арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т үүрэг болгосугай.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. /алх цохив/

Г.Лувсанжамц гишүүнээр тасаллаа. Г.Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Их Хурлын үйл ажиллагаатай холбоотойгоор төсөв болон төлөвлөгөөтэй хамааралтай санал хэлье.

Өнөөдөр 2027 оны Монгол Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөг ярилцана.

Гэхдээ 2025 оныхоо төсвийн гүйцэтгэлийг яриагүй байгаа. 2025 оны төсвөөр бид ямар үр дүнд хүрсэн бэ гэдгээ ярилцсаныхаа дараа алдаа байсан бол тэрийгээ засаад явъя гээд 2027 оныхоо хөгжлийн төлөвлөгөөгөө ярих ёстой байдаг.

Тэгэхээр энэ хуулийн зохицуулалтыг нь өөрчлөхөөр ажиллаж байгаа. Тэгээд манай Эдийн засгийн байнгын хороонд байгаа гишүүд маань бас олуулаа байгаа болов уу.

Тэгээд энэ дээр Та бүхэн маань санал нэгдэж байгаа болов уу гэж бодож байна.

Удахгүй ажлын хэсэг дээр Та бүхэндээ хөгжлийн төлөвлөгөөг батлах, хэлэлцэх, гүйцэтгэлийг хэлэлцэх, төсөвтэй нь уялдуулаад хэзээ, хэдэн сард ярилцдаг талаар саналаа бичгээр хүргүүлэх болохоор Та бүхэн маань ажил хэрэгч байдлаар саналаа өгөхийг хүсэж байна.

Л.Соронзонболд: Санал хэллээ. С.Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Үүнээс өөр цаглавар батлахад хэлэлцэх хууль байхгүй юм уу? Хоёрхон ийм хуулийг оруулж ирэнгүүтээ тавиад.

Энэ чинь бараг үндсэндээ 6 сарын эхэн хүртэл явах нь байна шүү дээ. Тийм ээ. Үүнийг тодруулж асуумаар байна. Цаглаварт нэмэлт, өөрчлөлт оруулж болох уу?

Тийм учраас энэ хоёр асуултыг л асууя.

Л.Соронзонболд: Тэгэхээр С.Эрдэнэбат гишүүн ээ, Их Хурлын даргын 4 сарын 30-ны өдрийн 179 дүгээр захирамж байгаа. Тийм ээ. Энд 5 дугаар сард хэлэлцэх асуудлын дарааллыг баталсан байгаа.

Тэгэхээр Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаврыг хавсралтаар баталсугай гээд Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй гээд хоёрдугаарт нь заасан байгаа.

5 сарын хувьд хуваарь дээр Улсын Их Хурлын даргын захирамжид яг эдгээр асуудал байгаа учраас энэ хуваариараа явна гэж ойлгох хэрэгтэй. Тийм. Дундуур нь өөрчлөлт ороход асуудал байхгүй гэж харж байна.

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

23 гишүүнээс 13 гишүүн буюу 56.5 хувийн саналаар цаглавар батлагдлаа. /алх цохив/

Байнгын хорооны тогтоол батлагдлаа. /алх цохив/

“Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

**Хоёр.Монгол Улсын Засгийн газар,
Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын
нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төсөл
/Засгийн газар 2026.04.22-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх,
санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын
байнгын хороонд хүргүүлнэ/**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцээрийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна.

3.Мэндсайхан гишүүний микрофоныг нээе.

3.Мэндсайхан: Эдийн засгийн байнгын хорооны дарга,

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хооронд 2017 оны 5 дугаар сарын 09-ний өдөр жилийн 0.15 хувийн хүүтэй, 28 жилийн хугацаатай, үндсэн төлбөрөөс 5 жил чөлөөлөгдөх нэн хөнгөлөлттэй 50 сая еврогийн нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийг байгуулсан.

Энэхүү нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар 2018 оны 25 дугаар тогтоол, 2024 оны 94 дүгээр тогтоол, 2025 оны 113 дугаар тогтоолоор 5 төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлэж холбогдох санхүүжилтийн хуваарилалтыг хийсэн байдаг.

Дээрх 5 төслөөс 3 төсөл амжилттай хэрэгжиж бүрэн дууссан бөгөөд аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинэчлэх, шинээр барих төсөл, Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс, Дорнод аймгуудад 3 мянган метр кубээс 5 мянган метр куб бохир ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг барих ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.

Үүнээс Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлын гүйцэтгэл 97-гоос 98 хувьтай байна.

Туршилт, тохируулгын ажил хийгдэж байгаа бол Эрдэнэт хотын хатуу хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл 90 хувийн гүйцэтгэлтэй байна.

Өнөөдрийн байдлаар нэн хөнгөлөлттэй зээлийн 71 хувь нь буюу 35.45 сая евро ашигласан бөгөөд 14.5 сая еврогийн зээл ашиглах үлдэгдэлтэй байна.

Хэлэлцээрт заасны дагуу тус хэлэлцээрийн хүрээнд санхүүжих Монгол Улсын импортлогч болон Бүгд Найрамдах Польш Улсын үйлдвэрлэгч, гүйцэтгэгч нарын гэрээ байгуулах хугацаа 2021 оны 7 сарын 24-ний өдөр дууссан.

Гүйцэтгэгчийн гэрээний санхүүжилтийн эцсийн хугацаа 2026 оны 7 сарын 24-нөөр дуусгавар болж байгаа тул хэрэгжиж буй төслийн хэрэгжилтийн нөхцөл байдлаас шалтгаалан гэрээ байгуулах хүчинтэй хугацааг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгах, хэлэлцээрийн 8 дугаар зүйлд Ерөнхий хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дотор санхүүжилт олгож дуусгахаар заасан хугацааг 3 жилээр сунгаж 8 жил болох нэмэлт, өөрчлөлтийг Польшийн талтай эцэслэн тохиролцсон.

Энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр Засгийн газрын 14 дүгээр тэмдэглэл гарсан.

Иймд нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний хүчинтэй хугацааг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгах, хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш санхүүжилтийг 8 жилийн дотор олгож дуусах нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Л.Соронзонболд: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Хурмитханы Еркегүл Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн шинжээч, Баярдалайн Анх-Оргил Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Мэдэхгүйн Ням-Очир Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Хэлэлцээрийн төслийн талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Ж.Ганбаатар гишүүнээр тасалъя.

Г.Лувсанжамц гишүүний микрофоныг нээе. А.Ундраа гишүүнийг нэмье.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Зээлийн хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаа.

Энэ 5 аймгийн бохирын цэвэршүүлэх байгууламжийг барих ажлыг эрчимжүүлэх ёстой. 4 нь дуусах гэж байгаа юм байна. Тийм ээ. Чойбалсан хотын хэмжээг нь хоногт 5 мянган метр кубтэй байсныг нь 10 мянга болгож байгаа юм байна.

Ер нь бүсчилсэн хөгжлийг бид эрчимжүүлэх хүрээнд бүсийн төвүүдийгээ тодорхойлоод, жишээлбэл Чойбалсан хотын хувьд 2030 он гэхэд хүн ам нь 100 мянга хүрдэг байхаар инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжуудыг бид төрөөс барих ёстой.

Тэгэхээр энэ ажлыг дэмжиж байна. Хоёр асуулт байна.

5 мянган метр кубтэй хоногт байснаасаа 10 мянга болж өсгөснөөрөө өнөөдрийн үнийн дүн нэмэгдэж байгаа буюу 10 орчим сая еврогоор нэмэгдэж байна гэж ойлгож байна. Тийм ээ.

Улсын төсвөөр хэрвээ цэвэршүүлэх байгууламжийг адил багтаамжтайгаар барьсан тохиолдолд төсөвт өртгийн үнийн зөрүү нь хэр байдаг бол? Одоо хэрэгжиж байгаа төслүүд дээр, эсвэл нөгөө 4 аймгийн төв дээр байгаа бохирын цэвэршүүлэх байгууламжийн хэмжээ, хүчин чадал дээр нь үнийн зөрүү нь ямар байгаа бол гэсэн тэр нэг асуулт байна.

Л.Соронзонболд: Ажлын хэсгээс 6 номерын микрофоныг нэе.

М.Ням-Очир: Гишүүний асуултад хариулья.

Барилга, хот байгуулалтын яам Нийтийн аж ахуйн газрын даргын үүрэг гүйцэтгэгч М.Ням-Очир байна.

Манайд ойрын үед 10 мянган метр кубтэй цэвэрлэх байгууламж баригдаагүй.

Сүүлийн үед төсвөөр баригдаж байгаа хамгийн ойролцоо нь Багануур дүүргийн цэвэрлэх байгууламж байна.

Багануур дүүргийн цэвэрлэх байгууламж бол хоногт 5 мянган метр куб бохир ус цэвэрлэх хүчин чадалтай. Батлагдсан төсөвт өртөг 25.8 сая төгрөгөөр ажил гүйцэтгэж байгаа. Тэрбум төгрөг.

Л.Соронзонболд: Ж.Ганбаатар гишүүний микрофоныг нэе.

Ж.Ганбаатар: Баярлалаа.

Би зөвхөн хугацааг сунгаж байна гэж ойлгосон. Үүнийгээ тодруулаарай. Мөнгө төгрөг нэмэгдэж байгаа, зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа гэж ойлгоогүй шүү дээ. Тийм ээ. Тэрийгээ микрофонд сонсьё.

Хоёрдугаарт, 2018 оны энэ юуг би маш сайн санаж байгаа юм.

Тэр үед нэлээн олон аймгууд хоорондоо булаацалдаад л, бие чи дээрээ тулаад л баахан юм болсон юм л даа. Тэгээд харахаар яг зүгээр нэг ийм техник, тоног төхөөрөмж нийлүүлэх хэсэг нь биелсэн. Яг хоёр гол ажил нь биелээгүй.

Тэгээд яг үнэхээр 90 хувьтай юм уу, 95 хувьтай явж байгаа юу? Хэн хариулах вэ? Тэрийг. Үнэхээр 97 хувьтай явж байгаа юу? Зураг гэж байна уу? Одоо 97 хувьтай, 90 хувьтай гэж явж байгаа үгүйг нь сайн харчихмаар. Харвал уг нь үнэхээр 2 жилийн дотор дуусчихмаар юм байна гэж.

Манай төрийнхөн чинь бичиг баримт бүрдүүлэлтдээ 30 хувь гэж тооцдог билүү? Ажил эхлээгүй байхад л 30 хувь, 40 хувьдаа хүрдэг шиг санагдаад байх юм.

Тэгээд ийм байдалтай юм яваад ажил нь эхлээгүй байгаа юм биш биз дээ арай. Тэгээд бүхэл бүтэн 5 жил. Энэ чинь хэдэн жил билээ? Бараг энэ чинь 8 жил болж байна уу. Тийм ээ.

Тэгэхээр ийм олон жилийн дотор 97, 98 хувьтай нэг л тийм хол сонсогдоод байх юм. Асуучхаад тодруулъя. Баярлалаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 6 номерын микрофоныг нээе.

М.Ням-Очир: Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Ажил гүйцэтгэх гэрээ 2021 онд байгуулагдсан байдаг. Өнөөдрийн байдлаар –

- 2025 оны 9 сард Баян-Өлгийн цэвэрлэх байгууламж ашиглалтад орж Улсын комисс ажилласан. 9 сард хүлээж авсан.
- 2025 оны 11 сард Завхан, Увсын цэвэрлэх байгууламжийг хүлээж авсан.
- 2025 оны 12 сард Говьсүмбэрийн цэвэрлэх байгууламжийг хүлээж авсан. Улсын комиссын акт баталгаажсан байгаа.

Дорнод дээр асуудал жоохон хүнд явж байгаа.

Эхний төлөвлөлтөөр 5 мянган метр куб хүчин чадалтай цэвэрлэх байгууламж баригдана гэж байсан. Гэвч 1969 онд баригдсан одоогийн цэвэрлэх байгууламж нь 5 мянган метр куб.

Энэ дээр өнөөдөр бодит байдалд хоногт 4 мянгаас 5 мянган метр куб бохир ус хүлээж авдаг. Ачаалал ихэссэн үед 6 мянган метр куб бохир усны хэмжээнд хүрдэг.

Ийм учраас хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай болсон. Үүнтэй холбоотой тодорхой хэмжээний хугацаа алдсан.

Мөн эхний ээлжид сонгосон технологийн зураг төсөл боловсруулагдаад, экспертизээр батлагдах үед нийтдээ 67 тэрбум төгрөг буюу 17 сая еврогийн төсөвт өртөгтэй зураг төсөл боловсруулагдсан. Энэ бол мэдээж зээлийн юунд багтахгүй байгаа учраас ахиж технологио өөрчлөөд, ахиж даалгавар боловсруулж, ахиж зураг төсөл боловсруулсан.

Зураг, төслийг хоёр дахь удаагийн боловсруулах дээр технологийн сонголттой холбоотой бас нэлээн шийдэлтэй, маргаантай асуудлууд гарсан.

Ингээд зураг, төсөл маань ахиж бэлэн болоод 2025 оны 9 сард улсын экспертизээр 43 тэрбум төгрөгийн төсөвт өртөгт багтааж гүйцэтгэхээр зураг төсөл баталгаажсан байгаа.

Л.Соронзонболд: Нөгөө санхүүжилтийн мөнгөн дүн, зээлийн дүн нэмэгдээгүй биз дээ. Хугацааны асуудал дээр.

3.Мэндсайхан гишүүний микрофоныг нээе.

3.Мэндсайхан: Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Та яг зөв хэлж байна. Ерөөсөө зөвхөн гэрээний зээлийн хугацааг л сунгаж байгаа юм. 7 сарын 24-нөөр дуусгавар болж байгаа учраас ажлын гүйцэтгэлтэй уялдаатайгаар 2026 оны 12 дугаар сарын 31 хүртэл сунгах, санхүүжилтийг нь 3 жилээр сунгах ийм л өөрчлөлт орж байгаа юм. Төсөвт өртөг нэмэгдэхгүй.

Л.Соронзонболд: А.Ундраа гишүүний микрофоныг нээе.

А.Ундраа: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Ер нь гадаад зээлийн үр өгөөжийг сайжруулах талаар Их Хурал дээр хэд хэдэн тогтоол, асуудлууд яригдаж байгаа. Гишүүдийн санаачилсан хуулиуд явж байгаа.

Түүнд гишүүдийн байр суурь хоёр тийшээгээ туйлширсан байдалтай байгаа.

Тэгэхээр мэдээж зээлийн хэмжээ, тэгээд зээлийн хүү, зээлийн нөхцөл талаас нь харах юм бол яг энэ Польшийн үүний хөнгөлөлттэй зээлийг аваад ашиглахад болохгүй зүйлгүй зээл. Тэгээд юунд зориулагдаж байгаа зориулалтыг нь харахад дэд бүтцийн, тэгээд тухайн хот байгуулалтын суурь асуудлуудыг шийдэхэд зарцуулагдаж байгаа гэдгээрээ зөв зүйтэй зарцуулагдаж байна гэж харж байгаа юм.

Тэгэхдээ бидэнд бас нэг сэтгэлгээний өөрчлөлт шаардлагатай байна уу гэж энэ зээлийг хэлэлцэх явцад бодогдож байна л даа.

Юу вэ гэхээр бид цэвэрлэх байгууламжийн хэмжээ, хүчин чадлыг ярихаас биш бид тэр бохирдуулагч эх үүсвэр талдаа аливаа юмыг бас нэг их авч үзэхгүй байна.

Өөрөөр хэлбэл XXI зуун гараад 26, 27 жил болж байхад ууж болдог усаар нолийнхоо бочкинд ашиглаж байна. Үүнийг өөрчлөх талаар ямар нэгэн юм дорвитой хийгдэхгүй байна гэдэг нь бид бас цэвэр усныхаа эх үүсвэрийг асар их хурдтай ашиглаад, тэгээд хаягдал ус болсон хойно нь цэвэршүүлэх тухай л ярьж байгаа нь бас нөгөө ниргэсэн хойно нь хашхирав гэдэг шиг ийм нөхцөл байдал үүсэх гээд байна гэж харж байна л даа.

Тэгэхээр зарчмын хувьд ажлын хэсгийн гишүүдээс энэ цэвэрлэх байгууламжуудын хүчин чадлыг тухайн хот суурины өсөлттэй, прогнозтой нь уялдуулаад нэмж байгаа нь зөв зүйтэй.

Гэхдээ эх үүсвэр дээр нь багасгах талаар, өөрөөр хэлбэл саарал усны хэрэглээг илүү хөхиүлэн дэмжих, түүн дээр тарифын болон тарифын бус янз бүрийн урамшууллын механизм бий болгох талаар салбарын байгууллагын зүгээс бодож байгаа, төлөвлөж байгаа ажлууд юу байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Сангийн яамнаас асуухад ер нь зардал талдаа хэмнэж байж бид мэдээж төсвийг үр ашигтай зарцуулах тухай ярина шүү дээ. Зээлийг ч гэсэн мөн адил.

Тэгэхээр тухайн барилга байгууламжийг барьж байгуулахдаа саарал усны хэрэглээг дэмжсэнээр, эсвэл эрчим хүчнийх нь хэрэглээг нь багасгаснаар гарах зардал нь буурах ийм төлөвлөлт ер нь бодож байгаа, санаж байгаа зүйл байна уу гэдгийг Сангийн яамнаас асуумаар байна.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 6 номерын микрофоныг нээе.

М.Ням-Очир: А.Ундраа гишүүний асуултад хариулъя.

Усны эх үүсвэртэй холбоотой асуудлууд хоцорсон явж байгаа.

Бид өнөөдрийн байдлаар төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаатай холбогдуулаад нийтдээ 17 аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг 10 жилийн хугацаанд шинэчлээд байна.

Одоо үлдэж байгаа аймаг бол Ховд аймаг, Баянхонгор аймаг, Сэлэнгэ аймаг гурав үлдээд байгаа.

Төв аймгийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэхгүйгээр Хөшигийн хөндийн Хүннү хотын шинэ цэвэрлэх байгууламж руу бохир усыг нь холбохоор төлөвлөлтөө ингэж явж байгаа.

Ус хангамжийн хувьд ерөөсөө дорвитой ажлууд хийгдээгүй. Ер нь орхигдсон. Жил болгон бид ус хангамжийн системийг өргөтгөөд, хэрэглэгчээ нэмээд, үйлчлэх хүрээнд нь ард иргэдийг аж ахуйн нэгж, байгууллага хангах ийм зорилттой байдаг. Системээ бүрэн автоматжуулах, хяналт, удирдлага, мэдээллийн автомат системтэй болгох шаардлагатай байдаг. Гэвч бид өнөөдөр насосын хүчээр л ерөнхийдөө хэрэглэгчдэд усыг хүргээд алдагдалтай явж байгаа.

Усыг хэмнэх үүднээс гадаргын ус ер нь дэлхий нийтэд унд ахуйд ашиглаж байна. Манайх ерөнхийдөө 100 хувь. Говь-Алтай аймгийн төвийг Гэгээн нуураас гадаргын ус авч аймгийн төвийг хангаж байгаа ийм л бидэнд туршлага байна.

Бусад суурин газруудынх бүгдээрээ гүний ус ашиглаж байгаа.

Энэ гадаргын ус ашиглалттай холбоотойгоор бид Дэлхийн банкныханд хүсэлт тавиад одоо энэ суурин газруудад гадаргын усыг унд ахуйд ашиглах боломжийн судалгаа хийлгээ гэдэг яриа хэлэлцээрийн түвшинд явж байгаа.

Хэрвээ цаашдаа энэ асуудлууд шийдэгдээд, тодорхой хэмжээний туршлагатай газруудаар судалгаа шинжилгээ хийлгээд явах юм бол бид холбогдох норм дүрэм, эрх зүйн зохицуулалтууддаа өөрчлөлт оруулаад цаашдаа явах боломжтой. Гадаргын ус ашиглахад тохиолдолд.

Саарал ус гэж яриад байна. Саарал ус дахин ашиглах цэвэрлэсэн ус гэж бид сүүлийн үед стандарт гарсан. Өнгөрсөн онд дахин ашиглах цэвэрлэсэн устай холбоотой стандартыг батлуулсан байгаа.

Ашиглалттай холбоотойгоор холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд өөрчлөлт гарах, хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах, ашиглалт үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулахаар үзэл баримтлал батлагдсан.

Хууль зүйн яам, Байгаль орчны яамтай бид хамтарч батлахаар явж байна.

Мэдээж хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд дахин ашиглах цэвэрлэсэн уснаас илүү байгалийн нөөцөөс ашигласны, ус ашигласны төлбөр маань өндөр байх ёстой. Энэ хэмжээнд болгож байж бид гадаргын ус ашиглах юм уу, эсвэл дахин ашиглах, цэвэрлэсэн усыг ашиглах энэ нөхцөлийг бүрдүүлнэ.

Тэгэхээр өнгөрсөн долоо хоногт 4 сарын 22-ны Засгийн газрын хуралдаанаар энэ асуудлыг оруулаад, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, саарал ус ашиглахтай холбоотой тариф, аж ахуйн нэгж байгууллагуудын хоорондын харилцааг зохицуулах журмыг батлуулах эрхийг авсан байгаа.

Энэ дагуу бид холбогдох ажлуудаа хийгээд явж байгаа.

Өнөөдөр Мянганы сорилын сангийн шугамаар Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдээд гарч байгаа уснаас хоногт 50 мянган метр куб хүртэл хэмжээтэйг хүлээж аваад дахин боловсруулж ТЭЦ-3, ТЭЦ-4-ийн технологийн хэрэгцээнд нийлүүлэх ажил бэлэн болж байгаа.

Үүнтэй холбоотой бэлтгэл ажлуудыг хангаад явж байгаа.

Л.Соронзонболд: Сангийн яамнаас зардал бууруулах тал дээр. Ажлын хэсгийн 8 номерын микрофоныг нээе.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя. Сангийн яам. Ж.Дэлгэржаргал.

Ер нь гадаад зээл, тусламж, хөрөнгө оруулалтын төслүүд дээр ялангуяа сүүлийн жилүүдэд Монгол Улсад анх удаа хэрэгжиж байгаа төслүүд аягүй их гарч байгаа.

Үүнийг дагаад бидэнд бас нэг тулгамдаж байгаа асуудал бол–

- төслүүдийн менежментийг цаашаа яаж авч явах вэ,
- ашиглалтын үйл ажиллагааг хэрхэн хангах вэ,
- ашиглалтын зардлаа хэрхэн тооцож, хэрхэн нөхөх вэ –

-гэдэг дээр том бодлого зохицуулалт бүх салбар дээр шаардлагатай байгаа.

Ялангуяа сая Барилга, хот байгуулалтын яамнаас танилцуулсан Мянганы сорилтын сангийн хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр ашиглалтад ороход үйлдвэрийн өртгөө нөхөхөд өнөөдөр яг энэ дотоодын стандарт, хууль журмын асуудал зайлшгүй шинэчилж тогтоохгүй бол өнөөдөр үйлдвэрийн өртгөө нөхөхөд хүндрэлтэй байдал үүсэхээр байна гэж судалгаа гарсан.

Тэгэхээр эндээс гарч байгаа дахин ашиглах саарал ус, ус бохирдуулсны төлбөр, ус ашигласны төлбөр гээд устай холбоотой бүхэлдээ энэ салбар дээр менежментийн тогтолцооны... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 8 номерын микрофон. Хариултыг гүйцээж дуусгая.

Ж.Дэлгэржаргал: Шинэчлэл хийж байж бид оруулсан хөрөнгө оруулалт, хэрэгжүүлсэн төслүүдийнхээ өртгийг нөхөх ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх асуудал чухал байгаа.

Ер нь цаашдаа зээл, тусламжийн төслүүд, хөрөнгө оруулалтын төслүүд дээр төлөвлөлтийн шатанд нь бид яг энэ ашиглалтаа тооцдог байх асуудал бас шинээр үүсэх зохицуулалт юм байна гээд дараагийн төслүүд дээр бид энэ асуудлыг бас тусгаж явж байгаа.

Л.Соронзонболд: А.Ундраа гишүүн тодруулъя.

А.Ундраа: Шингэн хог хаягдлын асуудал маш их чухал байгаад байна л даа. Зарчим нь бохирдуулагч төлнө гэдэг зарчмаар. Тийм ээ.

Тэгээд усны үнэ тарифтай цэвэр усны болон саарал усны хэрэглээний үнэ тариф, тэгээд татварын болон бусад зохицуулалтууд одоогийн байдлаар хэт энгийн, тэгээд хатуухан хэлбэл жоохон ядмаг байгаа.

Энэ дээр бид дорвитой арга хэмжээ авахгүйгээр цаашаа урагшлахад хэцүү л дээ. Хог хаягдлын тухай хууль дээр Улсын Их Хурлын тогтоолын төслийг Б.Мөнхсоёл гишүүн ахалсан ажлын хэсэг тогтоолын төсөл батлуулахаар

ажиллаж байгаа. Байгаль орчны байнгын хороон дээр. Гэхдээ шингэн хаягдлын тухайд тарифын асуудлыг илүү нарийсгаж хийхгүй бол болохгүй.

Тэгэхээр Засгийн газрын зүгээс, ялангуяа төсөв төлөвлөх үед энэ дээр төсвөө боохоос өмнө хийгдэх тийм дасгал ажлууд гэх үү, эсвэл янз бүрийн сценари байдлаар тэгж ажиллах тийм шаардлага байна гэж харж байгаа.

Л.Соронзонболд: Санал хэллээ. Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

23 гишүүнээс 13 гишүүн дэмжсэн буюу 56.5 хувийн саналаар төслийг хэлэлцэхийг дэмжлээ. /алх цохив/

Санал хураалт явагдаж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг зөвшилцөх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар танилцуулна.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

**Гурав. “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**
/Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
нэг дэх хэлэлцүүлэг/

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийн талаарх Засгийн газрын танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Жадамбын Энхбаяр танилцуулна.

Сайдын микрофоныг нээнэ үү. Ажлын хэсгийн 5 номер.

Ж.Энхбаяр: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт Засгийн газар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурал 6 дугаар сарын 01-ний дотор батална гэж заасны дагуу Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төслийг боловсруулж, Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар нэг дэх хэлэлцүүлгийг хийж байна.

Уг төлөвлөгөөн төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1, 6.10.2 дахь заалтад заасан шаардлагад нийцүүлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан болно.

Мөн түүнчлэн бид үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилгын 76 шалгуур үзүүлэлттэй уялдуулан тодорхойлсон нь Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг, амлалтыг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах юм.

Монгол Улсын хөгжлийн 2027 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь Засгийн газрын **“Чөлөөлье”** санаачилгыг дэмжиж –

- ▶ Эдийн засгийн чөлөөлөлт,
- ▶ Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлт,
- ▶ Ногоон хөгжлийн чөлөөлөлт,
- ▶ Авлигын эсрэг чөлөөлөлт –

-гэсэн 4 чөлөөлөлтийн бодлого байх болно.

▷ **Нэгдүгээрт, Эдийн засгийн чөлөөлөлтийн хүрээнд.**

Бизнесийн орчныг тогтвортой, эрх чөлөөтэй болгож, татвар ба төсвийн шинэчлэл хийж, ажил эрхлэлт, үйлдвэрлэл, бүс нутгийн хөгжлийг дэмжиж, зээлийн хүүг бууруулж, санхүүгийн зах зээлийг өрсөлдөөнтэй болгож, төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжих болно.

Энэ хүрээнд дараах үр дүнгийн нөлөөлөл өндөртэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- **Эрчим хүчний салбарт** –
-

- Тавантолгойн 450 мегаваттын хүчин чадалтай дулааны станц,
- Дулааны V цахилгаан станц,
- Эрдэнэбүрэнгийн 90 мегаваттын хүчин чадалтай УЦС-ыг барина.

- Боловсруулах үйлдвэрийн салбарт -газрын тос боловсруулах үйлдвэр байгуулж Зөөвч овоо төслийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, зэс, ган үйлдвэрлэлийн цогцолборын талбайн бэлтгэл ажлыг эхлүүлнэ.

- Тээвэр ложистикийн салбарт экспорт болон аялал жуулчлалын чиглэлийн авто замууд болон Гашуун сухайт, Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн, Сэхээ хил холболтын төмөр замыг барьж хилийн боомтуудын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хөгжүүлнэ.

- Хөдөө аж ахуйн салбарт Евразийн эдийн засгийн холбоотой байгуулсан худалдааны түр хэлэлцээр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтарсан зураглалыг хэрэгжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.

- Атрын 4 дүгээр аяны хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид болон “Цагаан алт” хөдөлгөөний хүрээнд арьс шир, ноос, ноолуурын үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх болно.

- Соёл аялал жуулчлалын салбарт зам дагуух аялал жуулчлалын үйлчилгээний цогцолбор байгуулж, Гурвансайханд 4D, Ховд, Мөрөн, Чойбалсанд 4C нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлж* соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ.

Эдийн засгийн чөлөөлөлтийн хүрээнд дээрх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг 2027 онд 5.8 хувьд хадгалж, үндэсний өрсөлдөх чадварын индексийг 65 дугаар байрт эрэмбэлэгдэж байгааг 7 байраар ахиулна.

▷ **Хоёрдугаарт, Эрх зүй дүрэм журмын чөлөөлөлтийн хүрээнд.**

- Суралцагчийг мэдлэг, ур чадварын хоцрогдлоос чөлөөлж, эрүүл мэндийн тогтолцоог шинэчилж, ил тод болгоно.

- Хүнд суртлыг бууруулж, зөвшөөрлийн тогтолцоог хялбарчлан төрийн үйлчилгээг цахимжуулж, үр ашигтай болгоно.

- Энэ хүрээнд дараах үр дүнгийн нөлөөлөл өндөртэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх болно.

- Боловсролын салбарт–

- Цөөн хүүхэдтэй анги бодлого баримталж, багийн болон хотхоны бага

сургуулийг байгуулж, нэг багшид нэг туслах, “Эй Ай” туслахыг нэвтрүүлж, **Chromebook** угсрах үйлдвэр байгуулах төслийг эхлүүлнэ.

- Эрүүл мэндийн салбарт –
 - Зүрх судасны үндэсний төв,
 - Эс, эд, эрхтэн шилжүүлэх, суулгах төв,
 - Хавдар судлалын үндэсний төв - II –

-ээрэг эрүүл мэндийн салбарт шаардлагатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, 17 аймгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төсөл хэрэгжүүлж, нийгмийн эрүүл мэндийн төв, дэд төвийг байгуулна.

- ◆ Ажил эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- ◆ Өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээг нэмэгдүүлж, иргэдийн орлогын түвшинд нийцсэн ипотекийн зээлийн төрөлжилтийг бий болгож, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- ◆ Сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр гадаад улс орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны чадавхыг бэхжүүлж, гамшгаас урьдчилан сэргийлэх, мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлнэ.
- ◆ Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлтийн хүрээнд дээрх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүний хөгжлийн индекс 2025 онд 0.756 байгааг 2027 онд 0.7881-д хүргэж дундаж давхаргын эзлэх хувийг одоогийн түвшнээс 5 хувиар нэмэгдүүлнэ.

Мөн үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн индекс 40 хувь байгааг 52 хувьд хүргэж нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтийг одоогийн түвшнээс 5 хувиар нэмэгдүүлнэ.

▷ Гуравдугаарт, Ногоон хөгжлийн чөлөөлөлтийн хүрээнд.

- ◆ Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, ногоон дата төв байгуулж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлж эрчим хүчний хараат байдлыг бууруулна.
- ◆ Ногоон дэд бүтэц хөгжүүлэх хүрээнд айл өрхийн нарны хавтан, бага оврын нарны эх үүсвэрүүдийг нэмэгдүүлнэ.

Энэ хүрээнд дараах үр дүнгийн нөлөөлөл өндөртэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- ◆ Сэргээгдэх эрчим хүчний салбарт нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлж, айл өрхийн нарны хавтан, бага оврын нарны эх үүсвэрийг нэмэгдүүлж, сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийн төслүүдийг хэрэгжүүлнэ.
- ◆ Мандалговьд 100 мегаваттын салхин цахилгаан станцын төслийг өрсөлдөөнд сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлнэ.
- ◆ Анхдагч экосистемийг хамгаалах чиглэлээр усны нөөцийг хуримтлуулж, ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэн “Хэрлэн-Тооно”, “Онги-Цагаан бургастай” төслийн бэлэн байдлыг хангана.
- ◆ Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний тодорхойлсон хувь нэмрийн шинэчилсэн зорилтын хэрэгжилтийг хангаж, олон талын оролцоотой хамгааллын менежментийг хэрэгжүүлнэ.
- ◆ Байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн чиглэлээр “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд 10 мянган га талбайг ойжуулж, нөхөн сэргээж, цөлжилт, газрын доройтлыг бууруулах, суурин судалгааны төвийг байгуулж ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны тархац нөөцийг тогтооно.
- ◆ Ногоон хөгжлийн чөлөөлөлтийн хүрээнд дээрх төсөл, арга хэмжээ хэрэгжүүлснээр байгаль орчны гүйцэтгэлийн индекс 2025 онд 37.2 оноотой байгааг 2027 онд 40 оноонд хүргэж, орон нутгийн хөгжлийн индекс 0.506 байгааг 0.553-д хүргэнэ.

▷ **Дөрөвдүгээрт, Авлигын эсрэг чөлөөлөлтийн хүрээнд.**

- ◆ Авлигын индексийн үзүүлэлтийг сайжруулж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг нэвтрүүлж цахим засаглал ил тод байдлыг бодитойгоор нэмэгдүүлж, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжин үндэсний хиймэл оюуныг хөгжүүлнэ.
- ◆ Хариуцлагын тогтолцоог чангатгаж төрийн албаны бүтцийг шинэчилж, шийдвэр гаргалтыг идэвхжүүлнэ. Энэ хүрээнд дараах үр дүнгийн нөлөөлөл өндөртэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- ◆ Авлига, хүнд суртлыг бууруулах чиглэлээр авлигатай тэмцэх иргэний нийгэм, сайн дурын хөдөлгөөнөө дэмжиж, шүгэл үлээгчийг дэмжих мэдээллийн суваг, хамгаалалтыг сурталчлах, авлигын эсрэг соён гэгээрүүлэлт, хууль, хэрэгжилтийн үнэлгээг хэрэгжүүлнэ.
- ◆ Төрийн бүтээмж, засаглалын чиглэлээр төрийн байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгаж, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, эх өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг нэмэгдүүлж, төрийн худалдан авалтад хиймэл оюун нэвтрүүлж, төрийн өмчит компаниудын

засаглал, ил тод байдлыг сайжруулна.

- ◆ Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөрийг өрсөлдөөнт хэлбэрээр нээлттэй хэрэгжүүлж, шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг ашиглалтад оруулж, технологи дамжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

Дээрх үр дүнгийн нөлөөлөл өндөртэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр засаглалын үзүүлэлт 2025 онд 114 дүгээр байрт эрэмбэлэгдэж байгааг 2027 онд 7 байраар ахиулж, дэлхийн мэдлэгийн индекс 39.2 оноог 50 оноонд хүргэнэ.

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд 15.3 их наяд төгрөгийн 124 төсөл, 186 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгалаа. Үүнээс –

- 2.2 их наяд төгрөгийг улсын төсвөөр,
- 0.2 их наяд төгрөгийг орон нутгийн төсвөөр,
- 5 их наяд төгрөгийг гадаадын зээл, тусламжаар,
- 4.5 их наяд төгрөгийг дотоодын хөрөнгө оруулалтаар,
- 1.6 их наяд төгрөгийг гадаадын хөрөнгө оруулалтаар,
- 1.5 их наяд төгрөгийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр,
- 0.3 их наяд төгрөгийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн болно.

Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд Баярлалаа.

Л.Соронзонболд: Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч Занданбазарын Цэдэнжав танилцуулна.

Ажлын хэсгийн 8 номерын микрофоныг нээнэ үү.

З.Цэдэнжав: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга,

Эрхэм гишүүд ээ,

Үндэсний аудитын газар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8.1-д заасан чиг үүргийн хүрээнд жил бүр улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, хөгжлийн төлөвлөгөөг хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулах талаар дүгнэлт, зөвлөмж хүргүүлж ажилласан.

Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд 8 чиглэлийг тодорхойлж–

- үндэсний 10,
 - салбарын 35,
 - төсвийн ерөнхийлөн захирагчийн 85,
 - хөтөлбөрийн 200 үр дүн,
 - 310 төсөл, арга хэмжээг тусгасан байх бөгөөд төлөвлөгөөний төслийг боловсруулах явцад дараах саналыг өгсөн болно. Үүнд,
- ➔ **Нэгдүгээрт**, Улсын хөгжлийн төлөвлөгөөнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан зарчмыг бүрэн баримталж, төлөвлөлтийг судалгаа, шинжилгээнд үндэслэх, шалгуур үзүүлэлтийг тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус ижил агуулгаар тусгагдсан байгааг анхаарах.
 - ➔ **Хоёрдугаарт**, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө хэрэгжилт, үр дүнг хангахад чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэр, шаардлагатай хөрөнгийг бүрэн тооцоолох, үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийг хийхэд чиглүүлэх.
 - ➔ **Гуравдугаарт**, Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.1.2-т урьдчилсан үнэлгээ хийсэн, түншлэлээр хэрэгжүүлэх төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг тусгах гэж заасныг баримтлах.
 - ➔ **Дөрөвдүгээрт**, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа мэдээ, мэдээлэл, өгөгдөл, дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөний гүйцэтгэлд нөлөөлөх шалтгаан, эрсдэл, хүчин зүйлийг тодорхойлж үндэслэн эрсдэлийн суурь судалгааг боловсруулан төлөвлөх.
 - ➔ **Тавдугаарт**, Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд төлөвлөсөн бодлогын чиглэл, үндэсний салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд үндэсний статистик болон олон улсын байгууллагын гаргадаг үзүүлэлт, тайлангийн гарах болон тархаах хугацаанаас шалтгаалж зарим арга хэмжээний үр дүнг үнэлэх боломжгүй байдалд хүрэх эрсдэл үүсэхээр байгааг хэлсэн.

Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг төлөвлөх, тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхээр баталсан холбогдох хууль, журмын цаглаварт хугацаанд дүн шинжилгээ хийж, бүх талуудын оролцоог жигд

ханган, Үндэсний аудитын газраас хүргүүлсэн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн хэлэлцүүлгийн явцад төлөвлөгөөний төслийн шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, санхүүжилтийн эх үүсвэр, түүний тооцоололд анхаарахыг Байнгын хороонд толилуулж байна.

Анхаарал хандуулсанд Баярлалаа.

Л.Соронзонболд: Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд хийсэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн дарга Жамсрандоржийн Дэлгэрсайхан танилцуулна.

Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээнэ үү.

Ж.Дэлгэрсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг танилцуулъя.

Засгийн газраас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуультай уялдуулан “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2025 оны 5 сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь “Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй танилцаж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16⁵.2 дахь заалтын дагуу дүгнэлт, зөвлөмжөө танилцуулж байна.

Зөвлөлийн зүгээс 2027 оны хөгжлийн төлөвлөгөө –

- ▶ **Нэгдүгээрт,** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
- ▶ **Хоёрдугаарт,** 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх суурь он болох.
- ▶ **Гуравдугаарт,** уул уурхайгаас хамааралтай эдийн засгаас бүсчилсэн, төрөлжсөн дэд бүтцийн хангамж зохих түвшинд хүрсэн тогтвортой эдийн засгийн суурийг бэхжүүлэх нэн чухал үе шат болж байгаа энэ үед хэлэлцэгдэж байгаагаараа онцлог гэж үзэж байна.

Юуны өмнө Засгийн газраас боловсруулсан 2026 оны хөгжлийн төлөвлөгөө нь “**Алсын хараа-2050**”, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаатай байдал, хуулийн шаардлага, хөгжлийн бодлогын зарчмыг баримтлах чиглэлд өмнөх жилүүдээсээ тодорхой ахиц гарсан баримт бичиг болсныг дурдаж байна.

Мөн эдийн засгийн бодлогын хувьд чөлөөлөлтийн бодлогыг дэвшүүлж, эдийн засгийн эрх чөлөө, авлигын эсрэг чиглэсэн тэргүүлэх зорилтуудыг тодорхойлж, хүний хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл, эдийн засаг, дэд бүтцийн хөгжил, засаглалын шинэчлэлийн хүрээнд хувийн хэвшлийг дэмжих, төрийн оролцоог бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын чиглэлүүдийг тодорхойлсон нь бодлогын хувьд дэвшил гарсан гэж зөвлөлийн зүгээс үзэж байна.

Гэхдээ хөгжлийн төлөвлөгөө нь зөвхөн зорилго дэвшүүлэх бус—

- бодитой хэрэгжих боломж,
- санхүүгийн эх үүсвэр,
- үр дүнгийн хэмжүүр,
- хариуцлагын тогтолцоотой –

-нягт уялдаатай байх Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн үзэл баримтлал, зарчимд нийцсэн байх ёстой гэдэг үүднээс Зөвлөл дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай хэмээн үзэж, холбогдох дүгнэлтүүдийг өгч байна.

➔ **Нэг.** Макро эдийн засгийн нөхцөл байдлыг бодитой үнэлэх шаардлага хэвээр байна.

2025 оны эдийн засгийн өсөлтийн бүтэц болон өнөөгийн нөхцөл байдлаас харахад 2026-2027 онд эдийн засаг 5.8 хувийн өсөлттэй байх нөхцөл хэр бодитой байхыг магадлах шаардлагатай байна.

2025 онд эдийн засгийн өсөлтийн гол хэсэг болсон хөдөө аж ахуйн салбарын сэргэлтээс хамаарсныг бүгд мэдэж байгаа бөгөөд энэ өсөлт нь цаашид үргэлжлэх эсэх нь тодорхой бус.

2027 оны төлөвлөгөөнд худалдаа, үйлчилгээний салбар нь эдийн засгийн өсөлтийн гол түүчээ болох, хөгжлийн хөтөлбөр, төслүүд нь эдийн засгийн өсөлтийг дэмжих үндэслэлийг тодруулан гаргасан боловч түүний үндэслэл, тооцоо хангалттай бус байна.

Иймээс цаашид хөгжлийн бодлогын хэрэгжилтийн суурь болсон эдийн засгийн өсөлтийн таамаглалыг илүү бодитой эрсдэлийг тооцсон байдлаар боловсруулах шаардлагатай байна.

➔ **Хоёр.** Хөгжлийн тэргүүлэх зорилт үндэсний үр дүнг оновчтой тодорхой болгох шаардлагатай байна.

Хөгжлийн бодлогод үндэсний үр дүнг тодорхойлсон боловч тэдгээрийн хэмжүүр бодит байдал, урт хугацааны зорилготой уялдах байдал, эдийн засгийн

тодорхой зорилгуудыг шийдэхэд чиглэсэн байдалд анхаарах шаардлага байсаар байна.

Энэ зорилгоор үндэсний үр дүнд–

- хувийн хэвшлийн оролцоо,
- ядуурал,
- дундаж давхарга,
- боловсрол,
- эрүүл мэнд –

-гэсэн зэрэг суурь салбарын үр дүнг илүү тодорхой, шалгуур үзүүлэлтээр хэмжих нь үндэсний үр дүнг нэмэгдүүлэх нөлөөтэй гэж үзэж байна.

→ **Гурав.** Бодлогын уялдаа, стратегийн нийцэл үндсэндээ хангагдсан боловч хэрэгжилтийн түвшинд доголдолтой хэвээр байна.

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө нь “Алсын хараа -2050”, таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй зорилгын хувьд уялдсан хэдий ч үндэсний болон салбарын хөтөлбөрийн үр дүнгүүд хоорондоо нягт уялдаатай байдал хангалттай биш байна.

Өөрөөр хэлбэл төлөвлөгөөнд тусгасан зарим төсөл, арга хэмжээнд ямар тэргүүлэх чиглэл ямар үндэсний үр дүнтэй холбоотойг илүү тодорхой болгох шаардлагатай.

→ **Дөрөв.** Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд смарт байх шаардлагыг бүрэн хангаагүй байна.

Хэдийгээр хөгжлийн төлөвлөгөөнд смарт зарчмыг баримталсан гэж байгаа боловч жилийн төлөвлөгөөнд тусгасан 334 шалгуурууд үзүүлэлтийн зарим нь зорилтот түвшингүй, хэт ерөнхий, хэмжих боломжгүй байдлаар тодорхойлсон нь үр дүнд суурилсан үнэлгээ хийх боломжийг сулруулж байна.

Иймээс шалгуур үзүүлэлтүүдийг илүү тодорхой, хэмжигдэхүйц бодитой байдлаар боловсруулах шаардлагатай байна.

→ **Тав.** Санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй хөрөнгө оруулалтын үр ашиг, эдийн засгийн тооцоо бүрэн хийгдээгүй байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан нийт төсөл, арга хэмжээний 5 төсөл нь санхүүжилтийн эх үүсвэргүй, олон төслийн хувьд эх үүсвэрийн бүтэц тодорхой бус байгаа нь... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 3 номер микрофоныг нээе.

Ж.Дэлгэрсайхан: Хэрэгжилтийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Мөн мега төслүүдийн хувьд төслийн нийт өртөг, санхүүжилтийн эх үүсвэр, үр өгөөжийг тодорхой болгох, олон жил дараалан жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төслүүдийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

→ **Зургаа.** Төслийн сахилга бат хөрөнгө оруулалтын үр ашигт анхаарал хандуулах шаардлагатай байна.

Томоохон төсөл, хөтөлбөрүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, хариуцах эзэн, байгууллагыг тодорхой болгох, хөрөнгө оруулалтын ач холбогдол, үр өгөөжийн тооцооллыг сайжруулах шаардлагатай байна.

Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө нь –

- Эдийн засгийн чөлөөлөлт,
- Төрийн бүтээмж,
- Бүсчилсэн хөгжил,
- Ногоон хөгжлийг дэмжих чухал зорилтуудыг дэвшүүлсэн.

Эдгээр зорилтыг бодит үр дүнд хүргэхийн тулд төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилтийн хяналт уялдааг илүү бодитой, хариуцлагатай, үр дүнд суурилсан хэлбэрт шилжүүлэх шаардлагатай байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс хөгжлийн төлөвлөгөөг сайжруулах дараах зөвлөмжүүдийг өгч байна.

— **Нэг.** Хөгжлийн төлөвлөгөөний үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг илүү оновчтой, тогтвортой, хариуцлагад суурилсан болгох шаардлагатай.

Ялангуяа ядуурлыг бууруулах, дундаж давхаргыг нэмэгдүүлэх зэрэг үндэсний зорилтуудыг тодорхой хэмжүүртэй, хариуцлага тооцох боломжтой байдлаар тусгах нь зүйтэй байна.

Тухайн хэмжүүрүүдийн зорилтот түвшин хөгжлийн төлөвлөгөөнд бодитой тусгагдаагүй байгааг эргэн харах шаардлагатай.

— **Хоёр.** Хөгжлийн бодлогын уялдаа холбоог сайжруулах.

Хөгжлийн бодлого, жилийн төлөвлөгөө, төсөв болон хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний уялдаа холбоог бүх түвшинд илүү тодорхой болгох шаардлагатай.

Тодруулбал, хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ бүр тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөний үндэсний ямар үр дүнд хүргэхийг тодорхой харуулсан байх шаардлагатай байна.

— **Гурав.** Хөрөнгө оруулалтын төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн тодорхой болгох.

Хөрөнгө оруулалтын төсөл, мега төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, санхүүжилтийн эх үүсвэр, эдийн засгийн үр өгөөжийг бүрэн тодорхой болгож, хэрэгжих бодит боломжийг мега төслүүдийн хувьд үе шаттай эрэмбэлэн хэрэгжүүлэх нь зүйтэй.

— **Дөрөв.** Төлөвлөлт, төсөвлөлтийн уялдааг сайжруулах.

Төлөвлөлт болон төсөвлөлтийн уялдаа холбоог сайжруулж, төсвийн сахилга бат, өрийн тогтвортой байдлыг хангахад онцгой анхаарч сайжруулах шаардлагатай.

— **Тав.** Том төслүүдийн удирдлагыг сайжруулах хэрэгтэй.

Томоохон төслүүдийн эрсдэл өндөр байгаа гэж үзэж байгаа тул төслийн санхүүжилт, хэрэгжилтийн нөхцөл байдал, эдийн засгийн үр өгөөжийг бодитой үнэлж, хэрэгжих боломжтой төслүүдийг үе шаттайгаар эрэмбэлэн хэрэгжүүлэх, судалгаа, үндэслэлийг сайжруулах шаардлагатай байна.

— **Зургаа.** Улсын Их Хурлаас Засгийн газарт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах.

Улсын Их Хурлаас өмнө Засгийн газарт өгсөн үүрэг чиглэлүүдийг хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд тогтмол хяналт тавьж, тайлагнах механизмыг боловсронгуй болгон хэрэгжилтийг болон нийслэлийн үнэлгээг хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан хийж байх шаардлагатай гэж үзэж байна.

Анхаарал хандуулсанд Баярлалаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийг танилцуулъя.

Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Содномдаржаагийн Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Лханаажавын Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга. Байгаа юм уу? Байхгүй байна шүү дээ.

Бат-Ирээдүйн Анар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Энэ чинь байхгүй байгаа юм биш үү?

Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр эрдэс, баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөр-Очирын Ням-Очир

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мягмарсүрэнгийн Баярмагнай Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Балдангомбын Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төмөр-Уяагийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бавуужавын Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Байхгүй байна. Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга. Байхгүй байна. Намжилын Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга,

Пүрэвсүрэнгийн Сарангэрэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Вандансүрэнгийн Жавзан Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга, Намдангийн Ганбаатар Ёс зүйн хорооны ажлын албаны дарга,

Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Рэнцэнбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн,

Ганболдын Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Нанжидын Ургамалсувд Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал, Батмөнхийн Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Мангалжавын Оюунжаргал Үндэсний статистикийн хорооны Эдийн засгийн статистикийн газрын дарга, Занданбазарын Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Буяндэлгэрийн Баттуяа Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, Шагдарын Наранбаатар Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Сүхбаатарын Цогтгэрэл Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Баттулгын Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга, Жаргалсайханы Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга,

Батсуурийн Даваадалай “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал, Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга. Байхгүй байна.

Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Төмөрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг,

хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Зияханы Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга,

Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга,

Бямбасүрэнгийн Туяа Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Энэбишийн Оюунсүрэн Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Батсүхийн Бадамжав Боловсролын яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Нэргүйн Амарбаяр Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, зохицуулалтын газрын Захиалагчийн хэлтсийн дарга, Чимэдсорогдонгийн Батболд Боловсролын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах шинжээч.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Ж.Ганбаатар гишүүнээр тасаллаа. О.Батнайрамдал гишүүнийг нэмье. Б.Пунсалмаа гишүүнийг, С.Эрдэнэбат гишүүнийг нэмье.

Г.Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе.

Бид таван жилийн үндсэн чиглэлээ баталснаас хойш анх удаагаа таван жилийн үндсэн чиглэл дээрээ үндэслээд, боловсруулаад оруулж ирж байгаа жилийн хөгжлийн төлөвлөгөө байгаа.

Ахиц дэвшил маш их байна. Тогтвортой хөгжлийн зорилготойгоо уялдуулаад орж ирсэн байна. Үр дүнд суурилсан байдлаар жилийн төлөвлөгөө боловсруулах оролдлогыг маш их хийсэн байна.

Гэхдээ засаж сайжруулах зүйлүүд их байна. Эдийн засгийн хөгжлийн яамнаас асууя.

Таван жилийн үндсэн чиглэлд туссан мөртлөө 2027 оны жилийн төлөвлөгөөнд тусаагүй байгаа шалгуур үзүүлэлтүүд хэд байна вэ? Төсвийн ерөнхийлөн захирагч нараас Та бүхэнд явуулахдаа ийм шалгуур үзүүлэлтийн саналыг явуулсан уу, эсвэл танай дээр ирэхэд нь заримыг нь хассан тийм зүйлүүд байна уу, үгүй юу?

Хоёрдугаарт нь, салбарын ангиллаар аль салбарт хэдий хэмжээний төсөв, төлөвлөгөө төлөвлөж байгаа вэ гэсэн ангиллын мэдээлэл танилцуулга дээр байхгүй байна. Жишээлбэл, эрчим хүчний салбарт хэдэн тэрбум төгрөг төсөвлөж байгаа гэх мэтээр. Тийм ээ. Иийм мэдээлэл хэрэгтэй байна. Бидэнд

Гуравдугаарт нь, Засгийн газраас 2027 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгож зарласан. Энэ салбар дээр хэдий хэмжээний төсөв төлөвлөж байна аа? Бодитоор эрүүл мэндээ дэмжиж чадах жил болох уу? Эрүүл мэндийн даатгалын сан хоосорчхоод байдаг. Энэ асуудлуудыг цэгцлэх ажлууд жилийн төлөвлөгөө дээр байна уу? Эсвэл 2026 ондоо багтаад үүнийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна уу?

Зам, тээврийн яамнаас асууя. Лүнгийн 100 орчим километр зам 1.4 их наяд төгрөгөөр барина, гадаадын зээлээр барина гэсэн төсөл орж ирж байна. Эдийн засгийн үр өгөөжөө бодох юм бол Лүнгийн замаас илүүтэйгээр бид Алтанбулаг, Замын-Үүд чиглэлийн замыг бид 4 эгнээ болгох ёстой. Тэгж байж бид нийлүүлэлттээс хамааралтай инфляцыг бууруулах боломж бүрдэнэ. Тийм ажил төлөвлөж байна уу?

Яагаад Лүнгийн зам ийм өндөр өртөгтэйгээр ороод ирсэн бэ гэдэг дээр тайлбар авмаар байна.

Sandbox зон байгуулна гэсэн байна. Цахим хөгжлийн яам үүнийг хаана байгуулахаар төлөвлөж байгаа вэ?

Боловсролын яам **Chromebook** үйлдвэрлэдэг үйлдвэр барина гэсэн байна. Үүнийг хаана, ямар төсөл, арга хэмжээгээр хэрэгжүүлэх гэж байгаа юм бол?

Гуравдугаарт нь, “**Цөлжилттэй тэмцэх судалгааны төв**” гэж байна. Байгаль орчны яамны харьяанд байгаа байх. Тийм ээ. Энэ хаана барихаар төлөвлөж байгаа судалгааны төв болох бол? Эдгээр асуултад хариулт авъя.

Г.Лувсанжамц гишүүний асуултад Ажлын хэсгийн. Ж.Энхбаяр Тэргүүн шадар сайдын микрофоныг нээе. 5 номер.

Ж.Энхбаяр: 7 номер дээр яамд ирээд очерлоод асуулт хариулахад бэлдээрэй.

Салбарын санхүүжилттэй холбоотойгоос эхэлье. 2027 онд –

- Эрүүл мэндийн яам 488 тэрбум,
- Эрчим хүчний яам 5.3 их наяд,
- Боловсролын яам 617 тэрбум,
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам 122 тэрбум,
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 98 тэрбум,
- Зам, тээврийн яам 2.3 их наяд,
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 413 тэрбум төгрөгийн –

-салбарын санхүүжилтүүд тус тус очиж байна.

Энэ дотроосоо 2027 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласан байгаа.

“Эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд –

- эрүүл мэндийн засаглал, эрх зүйн орчныг боловсронгуй болгон, санхүүжилт ба даатгалын тогтолцоог нь бэхжүүлнэ.
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Иргэдийн оролцоо хариуцлагыг дээшлүүлнэ.
- Хөдөөгийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- Уламжлалт анагаах ухааны үйлчилгээг дэмжиж хөгжүүлнэ.
- Зайлшгүй шаардлагатай технологийн хангамжийг нэмэгдүүлнэ.
- Салбарын хүний нөөцийн чадавх ба нийгмийн баталгааг бэхжүүлнэ.
- Эрүүл мэндийн салбарын цахим шилжилт, мэдээллийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлнэ гэсэн Эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд явагдаж байгаа гол бодлого байгаа.

Эрүүл мэндийн салбар ер нь ажлаа хамгийн зөв төллөж гадаад, дотоод хөрөнгө оруулалтын асуудлуудаа амжилттай шийдэж чадсан байгаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 4 номер.

Б.Мөнгөнсүх: Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх.

Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулья.

Шалгуур үзүүлэлтийн тухайд Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэлд нийтдээ 516 шалгуур үзүүлэлт, 362 үр дүнг тусгасан байдаг. Үүнээс Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2027 оны төсөлд 271 үр дүн, 398 шалгуур үзүүлэлтийг нэг бүрчлэн таван жилийн үндсэн чиглэлээс буулгаж ирж төлөвлөж байна.

Энэ хүрээнд 80-аас 90 шалгуур үзүүлэлтэд тодорхой урсгал зардлаар санхүүжилт хийх, санхүүжүүлэх шаардлагагүйгээр үр дүнд хүрэх ийм шалгуур үзүүлэлтүүд байна.

Мөн түүнчлэн 91 шалгуур үзүүлэлт нь тооцох буюу шинээр арга, аргачлалыг боловсруулж тооцоолон гаргах шаардлагатай шалгуур... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 4 номерыг нээе.

Нэмэлт хариулт өгөхдөө 1 минутад л хариулж байгаа учраас яг гол асуултад шууд хариулмаар байна. Ажлын хэсгийн 4 номерыг нээе.

Б.Мөнгөнсүх: Тусгасан байгаа.

Тэгээд энэ хүрээнд Үндэсний статистикийн хороо бусад яамд, холбогдох байгууллагуудтай хамтран 91 шалгуур үзүүлэлт, арга аргачлалыг боловсруулах, тогтмол хэмжиж үнэлж дүгнэх ажлыг хийж гүйцэтгэж эхлэхээр судалгааны ажил, бэлтгэл, бэлэн байдлууд хангагдаж байна.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

Ж.Энхбаяр: Эрүүл мэндийн салбартай холбоотой эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төсөл 17 аймгийн нэгдсэн эмнэлгээ сайжруулахаар.

Яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасаг, мэс заслын барилгыг шинэчилж өргөтгөхөөр орж ирж байгаа.

Нийт 809.0 тэрбум төгрөгийн гадаад зээлээр хэрэгжиж байгаа.

Үр дүнд нь эрчимт эмчилгээний тасаг, мэс заслын өрөөний барилга, өргөтгөл, шинэчлэл хийгдэнэ. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй, бүх аймгуудад жигд хүрэлцээтэй байдлыг үүсгэнэ.

Хөдөө орон нутгийн яаралтай тусламжийг багуудын телемедициний дэмжлэгээр хангах болно.

Яаралтай тусламжийн эмч, сувилагч, түргэн тусламжийн ажилтнууддаа зориулсан мэргэшсэн сургалттай хөтөлбөрүүдийг сайжруулна.

- Аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн шинэчлэл – 135,
- эмнэлгийн тоног төхөөрөмж – 42,
- яаралтай тусламжийн автомашин, явуулын эмнэлэгт – 115,
- цахим эрүүл мэндийн үйлчилгээ сонирхвол – 9,

- хүний нөөц дээр – 4,
- зөвлөх үйлчилгээ дээр – 5

-гэх мэтийн ингээд эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтууд шийдэгдсэн.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

Ж.Энхбаяр: Лүнгийн замтай холбоотойгоор Лүнгийн зам маань манай 13 аймаг руу нийслэлээс гарч байгаа гол гарц.

Нөгөө талаар шинэ Хархорум нийслэл хотыг Улаанбаатарт холбох гол зам. Нийт 356 километр зам төлөвлөгдөж байгаагаас эхний 100 орчим километр замыг Лүнгийн замаар эхэлж байгаа.

Нөгөө талаас авто замын салбараас ирсэн хамгийн эрчимжилттэй, хамгийн түгжрэл үүсгэж байгаа гол зам бол Улаанбаатар, Лүнгийн зам нэгээр эрэмбэлэгдэж байгаа. Иймд Лүнгээсээ эхэлье гэсэн хувилбар байна.

Таны санал дээр бас өөр хувилбар байгаа.

Нэгэнт эрчимтэй эдийн засгийн хувьд хамгийн ачаалалтай энэ замыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр зарлаад хэрэгжүүлэх хоёр дахь хувилбар. Гадаад зээлийн ашиглалтыг дараагийн босоо тэнхлэгийн эдийн засгаа дэмжсэн бусад замууд руу шингээх хувилбар бас байж болно. Аль аль нь яригдаж байгаа.

Одоогийн төлөвлөлтөөр гадаадын зээлээрээ Лүнгийнхээ замыг хөдөлгөө гэсэн... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 7 номер.

Т.Ням-Очир: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулья.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир.

Боловсролын салбарын цахим шилжилтийн хүрээнд одоо байгаа сургалтын зориулалтаар нэг компьютерт 11 хүүхэд оногдож байгааг бид ойрын 3 жилдээ ер нь 2 хүүхдэд нэг компьютер оногдохоор ийм төлөвлөлтүүдийг хийж байгаа.

Тэгээд жил болгон 100 мянган chromebook-ийг бид сургалтын зориулалтаар нийлүүлэхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд бид санхүүгийн түрээсийн хэлбэрээр 3 жилийнхээ төлөвлөлтийг бол хийж байгаа.

Энэ хүрээнд 100 мянгаас дээш chromebook компьютерыг нийлүүлсэн тохиолдолд энэ chromebook-ийн үйлдвэр өөрөө Монголд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийлүүлсэн байгууллагууд өөрөө байгуулж үүнийг сэлбэх, угсрах энэ бүх үйл ажиллагааг хийх боломжтой учраас бид энэ дээр төр, хувийн

хэвшлийн түншлэл буюу улсын төсөвт дарамтгүйгээр зохион байгуулах боломжтой.

Дээрээс нь 100-аас 120 хүний... /минут дуусав/

Л.Соронзонболд: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. Ажлын хэсгийн 7 номерын микрофоныг нээе.

Б.Мягмарнаран: Эрхэм гишүүний асуултад хариулъя.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тусгай сангийн 6.1.6-д заасны дагуу хиймэл оюун, их өгөгдөл, блокчэйн, сансрын дэвшилтэт технологид суурилсан sandbox-ын журмын төслийг эхний байдлаар боловсруулаад явж байгаа.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 6.1.6-д заасан хиймэл оюун ухаан, их өгөгдөл, блокчэйн, сансрын дэвшилтэт технологид чиглэсэн sandbox-ийн тухайн шийдлүүд зах зээл дэх өрсөлдөөнийг эрчимжүүлж, хэрэглэгчдэд бизнесийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээр төлөвлөөд явж байгаа.

Эхний ээлжээр “Мэдээлэл технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газар дээр хийхээр төлөвлөөд явж байгаа.

Л.Соронзонболд: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас хүн байгаа юм уу? Цөлжилттэй холбоотой асуулт асуусан шүү дээ.

Зам, тээврийн яамнаас бас асуусан. Зам тээвэр яамнаас хариулах уу? 7 номерын микрофон дээр. Ажлын хэсгийн 7 номерын микрофон.

М.Баярмагнай: Сайн байцгаана уу? Та бүгдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Гишүүний асуултад хариулъя.

Түрүүн Ж.Энхбаяр Тэргүүн шадар сайд Лүнгийн замтай холбоотой хариулсан.

Энэ дээр нэмэхэд төсөв яагаад жоохон өндөр байгаа асуулт асуусан. Энэ дээр 6 эгнээ зам байгаа. Хөдөлгөөний эрчмийн хувьд хамгийн өндөр гэж судалгаагаар гардаг. Оргил ачааллынхаа үед 21 мянган хөдөлгөөн гарахаар байж байгаа.

Дээр нь гүүрний төсөв нэмэгдэж байгаа учраас ийм төсөвтэй гарсан.

Алтанбулаг, Замын-Үүдийн 4 эгнээ замыг хөгжлийн жилийн төлөвлөгөөнд оруулсан. Үүнийг төр, хувийн хэвшлийн санхүүжилтийн хүрээнд шийдэхээр оруулсан байгаа. Баярлалаа.

Л.Соронзонболд: Г.Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Дэлгэрэнгүй хариулсанд баярлалаа.

Салбараар нь, ангиллаар нь хөрөнгө оруулалт зарцуулж байгаа төсвийнх нь хувийн харьцааг нь бичгээр авах сонирхолтой байна.

Тэгээд тав дахь өдрийн чуулганаас өмнө харчихвал энэ төлөвлөгөөн дээрээ суугаад асуултуудаа бэлдэх боломжтой байна.

Тэгээд Байгаль орчны яам ч гэсэн. Одоо байхгүй байгаа юм шиг байна. Тийм ээ.

Тэгэхээр тав дахь өдрийн нэгдсэн чуулган дээр саяын асуултад хариулахыг хүсэж байна.

Chromebook угсрах үйлдвэр төр, хувийн хэвшлийн түншлэлээр жилд 100 мянган ширхэгийг үйлдвэрлэх боломжтойгоор гэрээ хийж үйлдвэр байгуулна гэж ойлголоо. Том зорилт тавьж байгаа юм байна.

Гэхдээ гаднаас худалдаж авснаас үнэтэй тусах уу, ямар байх вэ гэдэг бид нөлөөг бодох ёстой. Тийм ээ. Монголд угсарсан нь илүү үнэтэй байх юм бол бид гаднаас авсан нь илүү төсөвтөө ачаалал бага үүсгэхээр байгаа. Тийм ээ.

Л.Соронзонболд: Санал хэллээ. Б.Пунсалмаа гишүүн.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөл танилцуулагдаж байна.

Энэ жил 15.3 их наядын 124 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ гэж тусгаж оруулж ирсэн байна.

Монгол Улсын төсвийн зарлага энэ жил 36 орчим их наяд төгрөг байгаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалт хэсэг дээр нь 10 орчим хувь бид ер нь жил болгон барилга, байшин, бүтээн байгуулалтад зориулж явдаг юм. Энэ бол ойролцоо дүнгээр манайх 5 орчим их наяд төгрөгийн бүтээн байгуулалт жилдээ ойролцоодуу төлөвлөдөг гэсэн үг.

Тэгэхээр 15.3 их наядыг бид энэ жил хөгжлийн төлөвлөгөөндөө оруулсан байна. Үүнийгээ төсөв дээрээ яаж багтаах юм? Ямар шалгуураар төслүүдээсээ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр тусгах юм бэ гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаарт нь, хөдөө аж ахуйн чиглэлээр буюу Евроази эдийн засгийн холбооны худалдааны түр хэлэлцээр хийсэн байгаа.

Энэ түр хэлэлцээрийн хүрээнд бид “Атрын-IV” дүгээр аян, арьс ширний үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлнэ гээд тусгасан байгаа.

Өнөөдөр хөдөө аж ахуйн салбарт арьс шир маш ихээр хаягдаж байгаа.

Тэгээд арьс ширээ бид түүхийгээр нь ч болтугай экспортод гаргах боломж, бололцоо яагаад байдаггүй юм бол оо? Энд хууль эрх зүйн болон ер нь ямар саад тотгор байдаг юм?

Хоёрдугаарт нь, “Аж үйлдвэржилтийн парк” гээд “Эмээлт аж үйлдвэржилтийн парк” гээд хотод баригдаж байгаа.

Тэр утгаараа Улаанбаатар хотын эргэн тойронд байгаа арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг бүгдийг нь аж үйлдвэржилтийн парк руугаа нүүлгэх бодлого хэрэгжүүлэх юм.

Тэгэхээр одоо бидний энэ жилийн олгох гэж байгаа дэмжлэг, туслалцаа чинь аль чиглэл дээрээ, ер нь арьс ширний ямар хэмжээний, ямар хүрээний дэмжлэг үзүүлж, хэр олон компаниуд энд хамрагдаж, хэдэн жилийн дараа үр дүн гарч, ямар өөрчлөлт үзүүлнэ гэсэн ийм тооцоолол байгаа юм бэ?

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номерын микрофоныг нээе.

Ж.Энхбаяр: Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулахаар улсын хэмжээнд 2 үйлдвэр, технологийн паркийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлээд хийж байна.

Эхнийх нь “Ховдын үйлдвэр, технологийн парк” улсын төсвөөр шаардлагатай дэд бүтэц, цэвэрлэх байгууламж, эрчим хүч, дулаан, зам, харилцаа холбооны хөрөнгө оруулалтууд хийгдэж дууссан.

Энэ дээр баруун 5 аймгийн арьс шир, түүхий эд боловсруулах үйлдвэрүүд төвлөрнө.

Монгол Улсын хэмжээнд үндсэндээ арьс ширний 24 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа.

- 2 үйлдвэр Дарханд,
- 1 үйлдвэр Өвөрхангайд,
- Бусад нь Улаанбаатар хот Хан-Уул дүүрэгт байгаа.

Энэ суурьшлын бүсдээ орсон байгаа.

Арьс ширний үйлдвэрийн гол онцлог нь цэвэрлэх байгууламж, химийн хортой олон бодис ашигладаг тул бие даасан өөр цэвэрлэх байгууламж байдаг. Ахуйн цэвэрлэх байгууламж руу нийлүүлэх бололцоогүй.

Үүнтэй холбоотойгоор Улаанбаатар хотын төсөв дээр цэвэрлэх байгууламж, эрчим хүч, дулаан, шаардлагатай бусад дэд бүтцийг нь 300 гаруй тэрбум төгрөгийн төсөв батлаад, санхүүжүүлээд ажил нь ид явж байна.

Энэ хөрөнгө оруулалтын ажил дууссаны дараа хотын төвд байгаа 21 үйлдвэр нүүн шилжиж “Эмээлт аж үйлдвэрийн парк” дээр төвлөрнө. Түүний дараа энэ орон байрыг нь, газрыг нь суллах, чөлөөлөх, дахин төлөвлөх бодлогын арга хэмжээ явахаар хийж байгаа.

Ингэж байж л бид энэ арьс ширнийхээ боловсруулалтыг бүрэн хийнэ. Хөдөө аж ахуйн салбарт ноолуур, ноосны боловсруулалтыг бүрэн хийж байна. Богийн, бодын арьс шир боломжийн байна. Бог буюу ямаа, хонины арьс нэхийн дээр зах зээл маш хязгаарлагдмал байгаа.

Нөгөө талаар дэлхий нийтийн хэрэглээнд их том өөрчлөлт гарч илүү зөөлөн, уян, нано, бусад синтетик материалаар хийсэн хувцас хунарын хэрэглээ их өндөр болж уламжлалт савхин эдлэл, хувцасны хэрэглээ, нэхий эдлэл, нэхий дээл хувцасны хэрэглээ эрс багассантай холбоотойгоор манай бог дээр нэлээн асуудал байгаа.

Үүнийгээ тэгээд шийдэхийн тулд энэ 2 төв дээр л боловсруулаад явахад манай суурилагдсан чадавх бүрэн хангана гэсэн тооцоотой.

Энэ дээр бас Евро Азийн зах зээлтэй хийсэн 3 жилийн гэрээ бол гол хөшүүрэг болно. Яагаад гэвэл энэ 180 сая хүн амтай сэрүүн бүсийн, манай 1990 оноос өмнөх уламжлалт зах зээл байгаа. Хуучин манай түүхий эд, бараанууд танигдсан.

Гэрээг үр дүнтэй болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг Евразийн орнуудтай холбогдох хорио цээр, мэргэжлийн хяналтын, гаалийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

5 орны парламент үндсэндээ эцэслэн баталсан. Одоо ингээд хэрэгжих хугацаа тоолоод эхэлсэн. Үндсэндээ 7 сарын 01 гэхэд энэ гэрээ хүчин төгөлдөр болоод явна.

Улсын төсөвт 2027 оны төсвийн хүрээ 2.2 их наяд л хөрөнгө оруулалт хийх орон зай байгаа.

Яагаад гэвэл бид өнгөрсөн хугацаанд улс төрийн шийдвэр парламентаар их гарсан. Урсгал зардал эрс нэмэгдсэн. Үндсэндээ 2027 онд урсгал зардал 4-өөс 6 их наядын нэмэгдэл орж ирж байгаа.

Үүнтэй холбоотойгоор шинэ хөрөнгө оруулалт хийх төсвийн орон зай дууссан.

Тэгэхээр одоо 2026 онд үргэлжилж байгаа хөрөнгө оруулалтаас 2.2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэх л төсвийн орон зай байгаа.

Энэ дээр бид гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэхээр төсвийн хүрээг өргөн барьсан. Хэрвээ Алтанширээ нефтийн үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төсөл энэ шалгуураас ангид одоо өнөөдөр Их Хурал дээр хэлэлцэж байгаа хууль дэмжигдвэл оронд нь 5 орчим их наяд төгрөгийн гадаад зээлийн ашиглалт нэмэгдэнэ.

Энэ гадаад зээлийн ашиглалт гэдгээр түрүүний хэлсэн эрүүл мэндийн салбар, 17 аймаг бага дунд боловсролын хүрээнд гадаад зээлээр хийгдэж байгаа маш олон хөтөлбөрүүд хэрэгжих орон зай үүснэ.

Энэ 2 төслийг чөлөөлөхгүй бол бусад гадаад зээлийн ашиглалт мөн энэ хэмжээгээр хязгаарлагдана.

Тэгэхээр бидний төсвийн шинэ хөрөнгө оруулалтын... /минут дуусав/

Л.Соронзонболд: С.Эрдэнэбат гишүүн. Б.Пунсалмаа гишүүн тодруулъя.

Б.Пунсалмаа: Тэгэхээр дараа жил бид дахиад жилийн хөгжлийн төлөвлөгөөнийхөө үр дүнг тооцож гаргаж ирдэг.

Тэгэхээр 15.3 их наядыг төлөвлөсөн байдаг. Яг боломжтой суулгаж болох хэмжээ нь 2.2 их наяд. Хэрвээ дахиад боломж гарах юм бол 5.5 их наядар нэмэгдүүлэх. Нийт 7 гаран их наядыг суулгах бололцоотой гэсэн ийм хариултыг сонслоо. Сая.

Тэгэхээр үлдсэн хэсгийг нь бид ирэх жилийн гүйцэтгэлд тооцож байхад энэ хийгдээгүй ажилд тооцогдох юм уу? Энэ ер нь ямар хэлбэрээр ирэх жилийн үр дүн болж тайлагнагдах юм.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

Ж.Энхбаяр: Энэ 6 эх үүсвэр байгаа. 2.2 их наяд бол зөвхөн улсын төсөв.

Гадаадын зээл гэж бас тусдаа. Гадаадын зээл бол бидын 5 орчим их наяд орон зай үүсэж байна.

Мөн төр, хувийн хэвшлийн түншлэл буюу гол гол дэд бүтцийн, эрчим хүчний шаардлагатай улсын төсвөөр хийж хүрэлцээгүй байгаа салбаруудаа, төслүүдээ бид хувийн хэвшил, гаднын хөрөнгө оруулалтад урина гэсэн үг. Жишээлбэл, –

- ТЭЦ-5 станцаа төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжинэ.
- Бөөрөлжүүт төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжиж байна.

Энэ мэтчилэн энэ төслүүд чинь бас улсын хөгжлийн бодлогодоо болохоор бүгд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэх, гадаадын зээлээр хийгдэх, гадаад зээл, гадаадын буцалтгүй тусламжаар хийгдэх, мөн орон нутгийн төсөв гээд улсын төсөв, гадаадын зээл, төр, хувийн түншлэл, орон нутгийн төсөв, гадаадын тусламж гэсэн ийм 6 эх үүсвэр байгаа юм.

Энэ бусад эх үүсвэрээ бид ашиглана л гэсэн үг. 2.2 маань зөвхөн улсын төсөвт байх боломж.

Яагаад гэвэл улсын... /минут дуусав/

Л.Соронзонболд: 5 номер, микрофоныг нээе. Хариултыг гүйцээе.

Ж.Энхбаяр: Тэгэхээр бид энэ 2.2 чинь улсын төсвөөр л хийх бололцоо. Энд шинэ хөрөнгө оруулалт багтахгүй. 2025, 2026 онд хэрэгжиж байгаа төслүүдээ үргэлжлүүлнэ гэсэн үг.

Гадаад зээлийн ашиглалт хэрвээ хууль батлагдвал тэр орон зайн дээр нэгэнт бид баталсан 13.8 их наяд төгрөгийн гадаад зээлийн гэрээ байна.

Үүнийгээ бид бүрэн ашиглана гэсэн үг. Үүнийг чинь бид ашиглаж чадахгүйгээр цаана нь жилдээ 40-өөс 60 тэрбум төгрөгийн эх үүсвэр блоклосны төлбөр гээд хүү төлөөд, алданги төлөөд байдаг байхгүй юу.

Тэгэхээр энэ ашиглалт нэлээн сайжирч орж ирнэ.

Бусад ажлууд шууд хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн хийж байгаа ажил, үйлчилгээ, бусад эх үүсвэрээр хийгдээд явна.

Тэгэхээр үүнийгээ бид гаргахын тулд бүх голлох аж ахуйн нэгжүүд, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд бүгдтэй нь холбогдож мэдээг нь авч статистиктайгаа Монголбанктайгаа, Сангийн яамтайгаа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэйгөө нийлж байж боловсруулж байгаа ийм тоон мэдээллүүд үндэслэж гарч байгаа зүйлүүд.

Л.Соронзонболд: С.Эрдэнэбат гишүүний микрофоныг нээе.

С.Эрдэнэбат: Нөгөө таван жилийн төлөвлөгөөг боловсруулж байхад бас тэгээд л алдаатай оноотой шахуу орж ирчхээд нэг юм баталсан юм.

Одоо ингээд уг нь засчихмаар байдаг. Зарим тоон мэдээллүүдийг харахаар сонин сонин дүр зургууд харагдаад байгаа юм.

Тухайлбал, “хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ” гээд тавьсан чинь “хамтын маргааны гэрээ, хэлэлцээрийг сайжруулна” гээд нэг юм тавьсан байгаа юм. Яах вэ нэг арга нь мөн.

Гэхдээ яг бодитоор яг хэчнээн чанартай байнгын ажлын байрыг бий болгох юм бэ гэдэг ийм тодорхой зорилтууд тавих ёстой.

Сая Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хүмүүс бас хэлж байх шиг байна. Зарим юмнууд чинь тодорхойгүй байна. Хэмжиж болохгүй байна. Хэт ерөнхий байна гэж. Тэр бол үнэн.

Тийм учраас маш олон улс орнууд эдийн засгаа сайжруулахад хамгийн түрүүн чанартай ажлын байрны тоог маш чухалчилдаг.

Тийм учраас ирэх 2027 он гэхэд хэчнээн чанартай ажлын байрыг бий болгох юм. Нэг чанартай ажлын байр буюу урт хугацааны ажлын байрыг бий болгоход хэдэн төгрөгөөр тооцож Та бүгд энэ төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулдаг юм бэ?

Зарим том том төсөл, хөтөлбөрүүд чинь ихэнх нь гаднын хүмүүс орж ирчхээд, ажиллах хүчээ оруулж ирээд гаднаас ихэвчлэн бараа, бүтээгдэхүүн аваад, сургуулийн сандал ширээ хүртэл Хятадад үйлдвэрлэсэн Хятадын ажлын байрыг дэмждэг сандал ширээг оруулж ирдэг юм хэвээрээ байгаа шүү дээ.

Тэгэхээр ийм зүйлийг уялдуулах тал дээр яг ямар төлөвлөгөө байна?

Энэ бол тэгэхдээ зөвхөн Хөдөлмөрийн яамны асуудал биш шүү. Манай яам болгон, төсөв захирч байгаа хүн болгон энэ мөнгөний хэдэн хувь нь жижиг, дунд үйлдвэрлэл Монголдоо үлдэх, цаашдаа ажлын байрыг бий болгох, цаашлаад нийгмийн даатгал, улсын төсөвт татвар төлдөг ийм хүмүүсийн тоог бий болгох вэ гэдэг дээр нь нэг тийм ерөнхий тооцоолоод л хармаар санагдаад байгаа юм.

Даанч үүнийг олон удаа л ярилаа. Гаргаад тавьдаг хүн байхгүй.

➤ Дундаж давхаргыг нэмэгдүүлнэ гэсэн.

Тэгээд дундаж давхарга гээд муу сайн хэлүүлээд л цалин малин нэмье гэхээр ерөөсөө л болохгүй юм өсчихнө гээд байдаг нэг ийм яриатай. Яг дундаж давхарга чинь. Яах вэ, сая багш, эмч нарын цалин хөлсийг нэмлээ. Тодорхой хэмжээнд дундаж давхаргыг чинь эзлэх хувь нэмэгдэх болов уу гэж би харж байна.

Тухайлбал, ахмадуудыг ярихад нийт ахмадуудын чинь үндсэндээ 90 хувь нь 1 сая 500-аас доош тэтгэвэртэй. Нөгөө ядуурал буурахгүй байгаа шалтгааны чинь ихэнх хувь нь энд явж байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд чинь 300, 400 орчим мянган төгрөгөөр амьдарч байгаа.

Тэгэхээр дундаж давхаргыг нэмэгдүүлнэ, ядуурлыг бууруулна гэхээр энэ хүмүүсийн орлогыг нэмэгдүүлэх асуудал дээр яг ямар юу байнавэ? Яах вэ, нэг гялтайж харагдаж байгаа юм нь юу вэ гэхээр энэ ахмадын тэтгэвэр дээр 8 хувь гэж байсан 29 гээд тавьж. Энэ тоог дэлгэрүүлж тайлбарлаж өгөхийг хүсье.

- Орон сууцын асуудал гээд байгаа. Моргейжийн зээлийг нэмэгдүүлнэ гэсэн.
- Моргейжийн зээл чинь нэмэгдсэн үү?
- Нэмэгдэх найдвар байна уу, байхгүй байна уу?
- Хөдөө орон нутагт боловсон хүчний тогтвор суурьшлыг нэмэгдүүлнэ гэсэн.

Энэ маш том нэг зүйл нь—

- Нэгдүгээрт, цалин хөлстэй холбоотой асуудал.
- Хоёрдугаарт, орон сууцтай холбоотой асуудал.

Суманд очиход орон сууц байхгүй учраас тэр хүмүүс нэгээс хоёр жил ажиллаад л буцаад хүрээд ирж байна.

Тийм учраас энэ тал дээр эхний ээлжид сум болгонд орон сууц барина гээд байсан. Энэ асуудал юу болов.

- Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ гэсэн.
- Зээлийн хүү хэдэн хувиар буурав?
- Банк, санхүүгийн байгууллагуудын хүү хэдэн хувиар буурав?
- Хэчнээн хүн зээл авсан?
- Дунджаар авсан хүү нь төлсөн мөнгө нь хэдэн хувиар буурав гэдэг.
- Төрийн албаны мерит зарчим, тогтвор суурьшлыг нэмэгдүүлнэ гэсэн.

Төрийн албанаас хэчнээн хүн гарсан бэ, хэдэн хүн шилжсэн бэ гэдгээр би энэ төрийн албаны тогтвор суурьшил, чадавх нэмэгдэх болов уу гэж би бодож байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр 98 тэрбум гэж байх шиг байна. Зарим яамдынх нь их наядаар тоологдож байх шиг байна.

Тэгэхээр дундаж бүлгийг нэмэгдүүлье гэдгийн чинь тооны хамаарал яг яаж харагдаж байна вэ гэдгийг... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номерын микрофоныг нэе.

Ж.Энхбаяр: Хөдөлмөр эрхлэлтээс нь эхэлье.

2025 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хүн ам 3.5 сая.

Хүн амын 66 хувь буюу 2.4 сая хүн хөдөлмөрийн насных байна. Хөдөлмөрийн насны 100 хүн тутмын –

- 59 нь ажил хийж,
- 3 нь ажил хайж,
- 38 нь ажил хийх боломжтой ч сонирхолгүй –

-гэсэн ийм хэлбэртэй байгаа.

Хөдөлмөр эрэлттэй байгаа ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 38 хувиар нэмэгдсэн. 1 сая 384 мянгад хүрсэн. Зөвхөн би Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт “Атрын-IV”, “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд 38 мянган ажлын байр шинээр бий болсон байдаг.

Тэгэхээр ажиллах хүчний оролцоо манайх 62.3 хувь байгаа. Нийт ажиллах хүчнийхээ. Энэ их өндөр тоо.

Ер нь эдийн засгийн ойролцоо үзүүлэлттэй манай хөрш Солонгос, Хятад, Казакстан, Вьетнам гээд авахад ажиллах хүчний оролцоо 65-аас 66 хувьтай байгаа юм.

Манай 62.3, 66 хувийн хооронд үзэхэд 60-аас 70 мянган хүний ажиллах хүчнийг бид нэмж ажлын байраар хангахад манай ажиллах хүчний оролцоо дээд потенциалдаа хүрнэ.

Өнөөдөр үндсэндээ бүхий л салбарт эдийн засгийн өсөлт гарсан.

Бидэнд тулгамдаж байгаа нэг асуудал бол ажиллах хүчний хомсдол. Бүх салбар мэргэжилтэй боловсон хүчнээр дутаж байна. Дотоодын ажлын хөлс хангахаас илүү бид салбарын өсөлтийг хангахад гадаад ажиллах хүчний оролцоог хангах бодлогыг авч хэрэгжүүлэхгүй бол оройтож байгаа.

Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, боловсруулах салбар, уул уурхай, аялал жуулчлал, үйлчилгээ гээд бүхий л салбарт гадаад ажиллах хүчийг авч ашиглах цаг нь болсон.

Энэ 62, 63 хувь гэдэг бол их өндөр хувь шүү. Өнөөдөр Монгол Улсад ажил олдохгүй байгаа зүйл байхгүй. Сайн дурын залхуурал их өндөр байгаа.

Ялангуяа орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах чиглэлээр төрийн албанд 20-иос 40 хувийн нэмэгдлүүдийг өгсөн. 2025 оны макро эдийн засгийн үзүүлэлтээр “өрхийн орлого” дээр “орон нутгийн орлого” хамгийн өндөр. 10-аас дээш хувиар хөдөө орон нутагт иргэдийн өрхийн орлого нэмэгдсэн. Төв суурин газар өрхийн орлого 2 хувьтай. Дунджаас бага байгаа.

Тэгэхээр хөдөө орон нутагт орлого сүүлийн жилүүдэд нэмэгдэж, тогтвор суурьшилтай ажиллах орон зай, боломж нэмэгдэж байгаа.

Ялангуяа сүүлийн хэдэн жил мал, мах, түүхий эдийн үнийн өсөлттэй холбоотойгоор малчдын орлого нэлээн өндөр түвшинд хадгалагдаж байгаа.

Орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын цалин орлого ч төв суурин газрынхаас 20-иос 40 хувийн илүү нэмэгдэлтэй. Доор хаяад моргейжийн зээл авахад 3 хувийн моргейжийн зээлтэй амины орон сууц барих хөтөлбөрт хамрагдах давуу боломжтой ийм байж байгаа.

Тэгэхээр 2027 оны төсвийг бид төлөв байдлыг яаж хийв гэвэл эдийн засгийн идэвхжил жоохон сул гарч байгаа. Ялангуяа уул уурхай, хөдөө аж ахуйг суурилоод харах юм бол хамгийн их ажлын байрыг хангаж байгаа худалдаа, үйлчилгээ, тээвэр, барилгын салбарын идэвхжил жоохон сулрах хандлага үүсэж байгаа.

Иймд төсвийн алдагдлыг жоохон нэмж өгөөд, энэ зарцуулалтаараа дамжуулаад эрэлтийг нэмэгдүүлж, эдийн засагт дэмжих бодлогыг 2027 онд төсвийн хүрээнд ийм бодлого оруулж ирж байгаа.

Нөгөө талаар эсрэгээрээ эдийн засгийн идэвхжил сайн байгаад 2012 оных шиг эдийн засаг өсөөд халаад эхлэх юм бол бид төсвийг ашигтайгаар батлаад төсөв дээрээ хуримтлал үүсгээд явдаг.

Тэгэхээр эдийн засагт хэт өндөр идэвхжил бий болгохгүй, инфляц өсөхгүй байх, макро эдийн засгаа тогтворжуулдаг бодлого.

Тэгэхээр ирэх жилийн тухайд, энэ жил ч мөн адилхан бид төсвийн алдагдлыг тодорхой хуулийн хэмжээнд нэмэгдүүлээд эдийн засгийн эрэлтийг нэмэгдүүлж эдийн засгаа дэмжих ийм бодлогыг хэрэгжүүлнэ.

2027 оны төсвийн хүрээний нэмэгдэл дээр төслийг 1.7 их наяд төгрөгийн алдагдлыг тэнцэх хэмжээнд барьж орж байгаа.

Л.Соронзонболд: Төрийн албаны зөвлөл асуултад хариулах ёстой. 7 номер дээр очоод бэлдэж байгаарай.

Монголбанк дараагийн тэр санхүүгийн хүртээмж, зээлийн хүү яаж буурсан бэ гэдэг асуултад орон сууцын зээл өсгөх боломж нь хэр найдвартай вэ гээд асуусан шүү дээ. Тийм ээ.

Энэ дундаж давхаргатай холбоотой асуултад хэн хариулах юм? 7 номер дээр очиж байгаарай хүмүүс. Ажлын хэсгийн 7 номерын микрофоныг нээе.

В.Жавзан: Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга В.Жавзан.

Нийт 226 мянга 895 төрийн албан хаагч байсан бол 2025 оны жилийн эцсээр 27 мянга 517-гоор цөөрсөн байна. Энэ нь 9 хувийн бууралттай нэлээн хамааралтай.

Түүнээс ажлаас өөрийн санаачилгаар 18 мянга 994 чөлөөлөгдсөн байгаа.

Ингээд Төрийн албаны зөвлөлийн тайланд бүх ангиллаар тайлан гаргасан. Гишүүдэд хүргүүлсэн байгаа. Баярлалаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

Ж.Энхбаяр: Дээрээс нь 9 хувийн хэмнэлтийн бодлогыг Засгийн газрын бүх байгууллагын бүх яамд хэрэгжүүлсэн.

Мөн сул 10 мянга гаруй орон тоо байгаа. Энэ дээр нөхөн хангалт буюу шинээр ажлын байр үүсгэж, зардал нэмэхгүй байгаа.

Тэгэхээр Засаг бол бололцоотой бүх хэмжээнд хэмнэлтийн бодлого хэрэгжүүлээд эхэлсэн байгаа.

Л.Соронзонболд: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. 7 номерын микрофон дээр.

Ж.Энхтөр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр байна.

Монгол Улсын 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бие даан хэрэгжүүлэх 16, хамтран хэрэгжүүлэх 7 төсөл, арга хэмжээ туссан. Нийтдээ 98.1 тэрбум төгрөгийн хөрөнгийн хэмжээ туссан байгаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой–

- эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих,
- хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих,
- залуучуудын хөдөлмөрийг дэмжих гэсэн арга хэмжээ туссан.

Энэ арга хэмжээнд хэрэгжүүлэх хөрөнгө 72.4 тэрбум төгрөгийн хөрөнгө манайд байдаг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөс хэрэгжихээр хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгагдсан.

Дундаж давхаргын хувьд орлогын түвшинд ажилгүйдэл, ядуурлын түвшин өндөр, дундаж орлого бага байгаа нь иргэдийн амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байгаа.

Үндэсний статистикийн хорооноос жил тутамд ядуурлын түвшнийг тооцдог. Ядуурлын түвшин одоогийн байдлаар 27.1 хувь байгаа. Шинжлэн тогтоосон.

Үндэсний статистикийн хороо Дэлхийн банктэй хамтарч ядуурлын шугам 418 мянга 090 төгрөг болгон шинэчлэн тогтоосон байгаа.

Ядуурлын шугамаас... /минут дуусав/

Л.Соронзонболд: Хариултыг гүйцээе. 7 номерын микрофоныг нээе.

Ж.Энхтөр: Ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй 914.2 мянган хүн байгаа бөгөөд ядууралд өртөхөд ойрхон 346.4 мянган хүн байна.

Ядуурал 10.3 хувиар нэмэгдэх эрсдэлтэй байгаа нь нийт ядуу хүн амын –

- 57 хувь нь хот суурин газарт,
- 43 хувь нь хөдөө орон нутагт байна. Үүнээс–

- Улаанбаатар хотод 37 хувь,
- аймгийн төвд 19 хувь,
- сумын төвд 20 хувь,
- хөдөө 23 хувь нь амьдарч байгаа гэсэн ийм дүн гарсан байна.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 7 номер. Монголбанк.

Н.Ургамалсүвд: Монголбанк. Н.Ургамалсүвд. Мөнгөнийн бодлого, судалгааны газар.

2026 онд ерөнхийдөө ипотекийн зээлийн санхүүжилт 680 гаруй тэрбум төгрөг байхаар байгаа.

Үүний 400 гаруй тэрбум нь ипотекийн зээлийн бондын эргэн төлөлтөөр хийгдэнэ. 280 орчим тэрбум төгрөг нь хуримтлалын сангийн эх үүсвэр хийгдэхээр төлөвлөгдсөн байгаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 7 номер.

Санхүүгийн хүртээмж яаж нэмэгдсэн бэ? Зээлийн хүүг бууруулах ажил чинь юу болсон бэ гэсэн асуултууд асуусан шүү дээ. Тийм ээ.

Н.Ургамалсүвд: Зээлийн өсөлт ерөнхийдөө 20 гаруй хувьтай байгаад, өнгөрсөн оны сүүл гэхэд. Одоо бол 16, 17 хувь руу ирж буурч. Ерөнхийдөө бодит дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн түвшинд буюу зохистой түвшинд ирж буурсан байгаа.

Үүн дотроо бизнесийн зээлийн өсөлт өндөр түвшинд буюу харьцангуй өндөр түвшинд буюу 20 орчим хувьтай байж байна. Хэр хэрэглээний зээлийн

өсөлт 10-аас доош буюу 9, 8 хувь руу ирж буурсан, саарсан ийм дүр зурагтай байгаа.

Ерөнхийдөө бизнесийн буюу хувийн хэвшилд олгогдож буй зээл харьцангуй өндөр түвшинд хадгалагдаад хүртээмж боломжийн байгаа гэж харахаар байгаа.

Л.Соронзонболд: С.Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Монголбанк би зээлийн хүү хэдэн хувиар буурав аа? Моргейжийн зээл чинь ирэх жил хэдэн хүнд хэчнээн метр квадрат орон сууцад олгох вэ гэдэг талаар би тодорхой хариулаач ээ гэж. Сайн байна.

Дээрээс нь энэ дундаж бүлгийг бий болгож, чанартай ажлын байр бий болгоход. Яах вэ, би өөрөө Хөдөлмөрийн яам, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд байхад мэдэж байна.

Ерөнхийдөө манай энэ том том төслүүд, мега төслүүд, хөнгөлөлттэй зээлүүд гээд энэ зүйл дээр нэг зүйлийг орхиод байдаг нь яг энэ төслийг давуу эрхээр гэдэг юм уу, тендерээр авснаараа хэчнээн ажиллах хүчийг бий болгох юм, хэчнээн жижиг, дунд үйлддвэрлэлийг араасаа дагуулж дэмжлэг бий болгох юм гэдэг дээр ерөөсөө үнэлгээ нэг их сайн хийдэггүй.

Манай Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл маань үндсэндээ 90 тэрбум төгрөг тавьдаг.

Бүх аймгууд дээр энэ мөнгүүд нь хасагдсан байна лээ.

Тодруулаад 1 минут авчих уу?

Л.Соронзонболд: Хариулт хангалтгүй гэж үзвэл 1 минут авна.

Ажлын хэсгийн 5 номерын микрофоныг нээе.

Ж.Энхбаяр: 2026 оны гуравдугаар улирлын байдлаар зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар өссөн байна. Үүн дотроо –

- бизнесийн зээл 20.1 хувиар,
- хэрэглээний зээл 9 хувиар өссөн.

Тэгэхээр харьцангуй зээлийн эрэлт боломжийн байна.

Хамгийн гол нь зээлийн чанар ямар байна гээд харахад чанаргүй зээл нийт зээлийн үлдэгдлийн 5.1 хувь буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна.

Гэхдээ энэ бол 1, 2, 3, 4 дүгээр сар шүү дээ.

Бидэнд бодитой тулж байгаа томоохон сорилт, эрсдэл. Энэ бол гадаад аюулгүй байдлын орчинтой үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор шатахууны үнийн өсөлттэй холбоотойгоор инфляцын нөлөө орж ирнэ.

Дунд үед 6, 7 сараас авхуулаад бодитой нэмэгдэх байх. Хэрвээ энэ байдал тогтворжихгүй урт хугацаандаа ужгирах хандлагатай байх юм бол –

- хүнс,
- шатахуун,
- бордоо,
- тэсрэх бодис –

-гээд манай гол 100... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 7 номерын микрофоныг нээе.

Н.Ургамалсүвд: Зээлийн хүү 3 сарын байдлаар дундаж хүү 17.37 хувьтай байгаа.

Шинээр олгосон зээлийн хүү ерөнхийдөө 17.6 хувь орчим хувьтай байна.

Ерөнхийдөө сүүлийн жил гаран хугацаанд зээлийн хүү 0.7 нэгж хувиар өссөн ийм дүр зурагтай харагдаж байна.

Гол нь энэ дээр бизнесийн зээлийн хүү болоод хэрэглээний зээлийн хүүнүүд ерөнхийдөө өсөх хандлагатай явж байна. Үүнд гол нь инфляц нэмэгдсэн, гадаад орчны эрсдэлүүд нэмэгдсэн, тодорхой бус байдал нэмэгдсэнтэй холбоотойгоор зээлийн эрсдэлүүд нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн гэж харж байна.

Л.Соронзонболд: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. 7 номер дээр гүйцээж хариульъя.

Ж.Энхтөр: Яг бодитой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Хөдөлмөр эрхлэлт дэмжих сангаас тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж хэрэгжүүлж байгаа.

Энэ жилийн хувьд яг 5 мянган зорилтод өрхийг хөдөлмөр эрхлэлтэд сургаад, хөдөлмөр ажлын байранд сургаад ийм ажлуудыг хэрэгжүүлж байгаа.

Энэ ажлууд ирэх жилүүдэд үргэлжлээд явахаар хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгагдсан байгаа.

Л.Соронзонболд: С.Эрдэнэбат гишүүн тодруульъя.

С.Эрдэнэбат: Яах вэ, асуугаад байвал зөндөө юм байгаа учраас ингээд орхиё гэж бодож байна.

Ерөнхийдөө энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд яамд маань яг нарийвчилсан ямар төлөвлөгөөтэй байгаа юм бэ гээд, үүнийг цахимаар тавиад тэр юун дээр нь дарахаар нарийвчилсан төлөвлөгөө юмнууд чинь, дэд юунууд нь гарч ирж байвал их ойлгомжтой байхаар байна. Тийм боломж байвал бэлдэж өгвөл сайн байна гэдгийг хэлмээр байна.

Тэр зээлийн хүүгийн хувьд үндсэндээ зорилт хангагдахааргүй л харагдаж байна гэж бараг хэлэх шиг боллоо. Тухайлбал, үүний эсрэг тэгвэл яг ямар арга хэмжээ хийх юм бэ гэдэг юмыг нь хөгжлийн төлөвлөгөө дээр тодорхой тавьж өгвөл их сайн байна гэдгийг хэлмээр байна.

Яах вэ, тэр хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хэлэхэд одоо манай төрөөс худалдан авалт хийж байгаа, төрийн ажил төрөл гүйцэтгэж байгаа зүйлүүд дээр бодит үнэлгээ хиймээр байна. Эргээд эдийн засагтаа ямар нөлөө үзүүлж байгаа юм, хэдэн төгрөг нь Монголдоо үлдэж байгаа юм, хэчнээн ажлын байр бий болгож байгаа юм, хэчнээн аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж байгаа юм гэдэг үнэлгээг гаргаж өгвөл уг нь их сайн байна гэдгийг хэлье.

Л.Соронзонболд: Санал хэллээ. Ж.Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Би уг нь хөгжлийн төлөвлөгөө, Ж.Энхбаяр сайд уг нь та бид их олон жилийн мөрөөдлийн энэ жагсаалтыг өөрчилье гээд л их олон ярьдаг байсан.

Тэгээд л ахиад л сонсоход гаднын зээл авахгүй л бол энэ төлөвлөгөө биелэхгүй. Төсөв хязгаарлагдмал.

Бид хэтэрхий хийсвэр юм яриад байхаар нийгэмд хэтэрхий хүлээлт үүсгэдэг. Худлаа хүлээлт.

Тэгээд гишүүд хөгжлийн төлөвлөгөө дээр бүтэхгүй баахан юм хураалгадаг. Тэгээд тэрийгээ хөгжлийн төлөвлөгөөнд тусгалаа гээд зарладаг. Тэр хэмжээгээрээ нийгмийн уур амьсгал, уур уцаар, хүлээлт.

Би хоёр асуулт асууя. Өнөөдрийн төсвийн алдагдал хэд байгаа юм? Сангийн яам. Яагаад алт, зэс, нүүрс ийм өндөр байх төсөв алдагдалтай байгаа юм. Яагаад? Юунаас шалтгаалж байгаа юм?

Монголбанкнаас би хоёр асуулт асуугаадахъя. Энэ үнэт цаасны үлдэгдэл ер нь хэд байна?

Ж.Энхбаяр сайд үүнийг мэдэж байгаа болов уу гэж бодож байна. Хамаг мөнгө чинь энэ дээр гацчихсан байгаа юм биш биз дээ? Зээлийн хүү, бодлогын хүү чинь 12, 13 хувьтай гэхээр банкууд чинь зээл гаргах сонирхолгүй л байгаа л

даа. Зээл 17 хувьтай. Яаж юм бүтээж бий болгоно оо? Маш хол сонсогдож байна даа.

Ер нь би хэлэлтгүй бүгдээрээ энэ дотор сууж байгаа хүмүүс мэдэж байгаа байлгүй. Бидний “Хөгжлийн төлөвлөгөө” гэдэг чинь ер нь бид экспортод бүтээгдэхүүнээ гаргах л гол зорилготой байх ёстой шүү дээ.

Ж.Энхбаяр сайд аа. Бид ерөөсөө яг дотооддоо үйлдвэрлэдэг үйлдвэрүүдийг дэмжээд өгвөл тэр үйлдвэрүүд чинь хоёр жилийн дараа эдийн засгийн хувьд хэцүү болно шүү. Энэ үйлдвэрүүд чинь гадаадад юм гаргадаг байж өөрөө өөрийнхөө үйлдвэрийг цааш нь хөгжүүлэх тийм чадвартай болно.

Тэгээд манай байдлыг харахаар –

- дэд бүтэц маш өндөр өртөгтэй,
- эрчим хүч маш өндөр өртөгтэй,
- ажилчдын цалин дунджаас дээш.

Тэгээд ажиллах хүн олдохгүй. Тэгээд бүгдийг нь харахаар бүгдээрээ эсрэг. Нөгөө экспортынхоо эсрэг.

Тэгээд одоо бид “Хөгжлийн төлөвлөгөө” гээд баахан юм суулгадаг.

Хэрвээ саяын явж байгаа хууль батлагдахгүй бол тэгээд өө..., уучлаарай, тэр хууль батлагдаагүй учраас бид зээл авч чадахгүй байна. Хөгжлийн төлөвлөгөө байхгүй боллоо гээд ийм л юм ярих нь л дээ.

Тэгээд саяын хууль чинь ерөөсөө хоёр төсөвтэй болно. Их замбараагүй болно шүү дээ.

2012-2016 онд үүнийг чинь их шүүмжилдэг хүмүүсийн нэг нь Та байсан. Хамаа замбараагүй төсөвтэй байж болохгүй. Би үүнийг шүүмжилмээргүй байна л даа.

Зүгээр яах вэ гаргалгааг нь харах гээд ерөөсөө чадахгүй байна.

Тэгээд муу ч, сайн ч гэсэн нэг жижиг, дунд үйлдвэрлэл хийгээд юмыг ард нь гараад, ганц хоёр юмны ард нь гарсан хүн л дээ би.

Тэгэхээр ерөөсөө энэ экспорт байхгүйгээр бид ер нь хөгжил ярих үнэхээр хэцүү дээ. Амиа аргацаасан л юмнууд. Тэгэхээр бид өрсөлдөх чадвар. Энэ бүх дэлхий чинь өөрөө өрсөлдөх чадварын төлөө л хоорондоо асуудалд орж байна шүү дээ.

Яаж бид өрсөлдөх чадвараа дээшлүүлэх вэ гэж бүх улс төрч нар хоорондоо далдуураа ерөөсөө тэр шүү дээ.

Яаж бид энэ дотоодын үйлдвэрийн өрсөлдөх чадварыг бууруулахгүй байх вэ? Еврог яаж долларын эсрэг бууруулах вэ, юанийг яах вэ гээд. Энэ бүх бодлого чинь өөрөө ингээд.

Тэгэхээр манайх тэгж чадахгүй ч гэсэн ядаж ганц хоёр үйлдвэр. Одоо ингээд арван хэдэн жил сонслоо л доо. Нэг ч үйлдвэр... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номерын микрофоныг нээе.

Ж.Энхбаяр: Экспорт 4 сарын 27-ны байдлаар 6.6 тэрбум ам.долларт хүрсэн байна.

Энэ нь ноднингийн мөн үеэс харьцуулахад 2.6 тэрбум ам.доллараар буюу 65 хувиар нэмэгдсэн байгаа.

Экспортыг идэвхжүүлэх ажлын хэсгийн Эдийн засгийн хөгжлийн яам хариуцаж ажиллаж байгаа. Бүхий л шатны хил, гааль, худалдаа, тээвэртэй холбоотой зохицуулалт, арга хэмжээг авч байгаа.

- Нүүрсний экспортын биет хэмжээ 37.8 сая тоннд хүрээд,
— өмнөх оноос 71 хувиар,
- Зэсийн баяжмалын биет хэмжээ 870.0 мянган тоннд хүрээд,
— өмнөх оноос 40 хувиар тус тус өсөөд байна.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын валютын нөөц 7.3 тэрбум доллар буюу Монгол төгрөгийн худалдан авах чадвар, төгрөгийн ханш тогтвортой байдлыг хангаж байна.

Нийтлэг бидэнд ирж байгаа хамгийн том хүндрэл бол яах аргагүй гадаад орчны нөлөөтэй холбоотойгоор, шатахууны өсөлттэй холбоотойгоор инфляцын нөлөө орж ирж байна.

Эндээс л иргэдээ хамгаалах, орлогоо хамгаалах, өрхийн орлогыг хамгаалах л гол бодлого. Энэ бидний гол тулгамдсан асуудал.

Иймд 2027 оны гол төсвийн хүрээнд урсгал зардлууд нэлээн нэмэгдэж байгаа.

Энэ дээр манай Улсын Их Хурлын шийдсэн олон саналууд байна. Эмч нар, багш нар, шинжлэх ухааны, боловсролын гээд, тэтгэвэр гээд нэмэгдлүүд 4-өөс 6 их наядын нэмэлт үүсгэж байгаа.

Уламжлалт эдийн засаг өөрийн потенциал чадавхаа үйлдвэрлээд экспорт өмнөх оноосоо дандаа илүү. Бүхий л салбар өсөлттэй явж байгаа.

Огцом нэмсэн урсгал зардал маань өөрөө бидэнд шинээр улсын төсвөөр дамжиж хөрөнгө оруулалт хийх боломжийг хязгаарлаж байгаа юм.

Иймд төсвийн хүрээнд бид гадаад зээлийн ашиглалтыг сайжруулах нь эдийн засагт мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, бизнест дэмжлэг болно гэж үзэж байгаа юм.

Иймд энэ 2 том төслөө гаргаад, оронд нь нийгмийн шинж чанартай. Бидэнд чинь амлагдсан нийт Монгол Улсын хэмжээнд 13.6 их наядын ашиглах орон зай байгаад байдаг. Бид ашиглаж чаддаггүй. Яагаад гэвэл гадаад зээлийн ашиглалт таазандаа, хязгаартаа хүрээд байдаг.

Тэгэхээр ингэж стратегийн урт хугацаанд хэрэгжиж байгаа Эрдэнэбүрэн, Алтанширээгээ гаргахад бусад эдийн засгийг салбаруудыг дэмжих энэ эх үүсвэрийг ашиглах юм бол 4-өөс 5 их наядын боломж үүсэж байгаа.

Тэгэхээр хэрвээ ийм гадаад орчинд нөлөөллийн өндөр өсөлт, урсгал зардлын огцом нэмэгдэл хийгээгүй бол манай эдийн засаг яг бодит боломжоороо тун эвтэйхэн бүхий л үзүүлэлтээ хангаад өсөөд явж байгаа байдал. Шинээр үйлдвэр, аж ахуйн нэгжүүд их олон орсон.

Ялангуяа хөдөө аж ахуйн салбарт Ерөнхийлөгчийн санаачилсан хөтөлбөрийн хүрээнд олон үйлдвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэн, экспорт, тоо, чанарт эрс өөрчлөлт гарсан. Үүнийг Та мэдэж байгаа байх. Үгүйсгэж болохгүй.

Зөвхөн хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар гэхэд л 38 мянган ажлын байр шинээр бий болсон. Тэгэхээр алхам алхмаар урагшилж байна.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 7 номер.

Н.Ургамалсүвд: Төвбанкны үнэт цаасны үлдэгдэл 3 сарын байдлаар 12.5 их наяд төгрөг байгаа.

Банкуудын нийт активын 25 хувийг төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай өндөр **liquid asset** хөрөнгөөр байршуулах шаардлагатай байдаг. Энэ шаардлага 25 хувь. Төвбанкны үнэт цаас энэ шаардлагын 17 орчим хувь дээр хадгалагдаж байгаа гэсэн үг.

Тэгэхээр банкууд харилцагчдынхаа өдөр тутмын наад захын шаардлагыг хангахын тулд ийм эрсдэл багатай **liquid asset**-ыг барих шаардлагатай. Тэр хүрээнд ерөнхийдөө 25 хувийнхаа өөрийнхөө **asset**-ыг хангах ийм шаардлагатай байдаг.

Тэгэхээр үнэт цаас үүний дөнгөж 17 хувийг хангаж байгаа.

Нөгөө талаасаа бодлогын хүү ерөнхийдөө сүүлийн жил орчмын хугацаанд 12 хувь дээр хадгалагдаад явж байгаа. /минут дуусав/

Л.Соронзонболд: Ж.Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Нэгхэн минутын дотор их юм ярих боломжгүй л дээ.

Ж.Энхбаяр сайд аа, үнэхээр 7.4 тэрбум долларын нөөц байгаа бодлогын хүүгээ буулгах хэрэгтэй. Тэгэх юм бол олон зүйлийг наад эдийн засаг чинь өөрөө хийгээд өгнө шүү дээ.

Бүгд төр өөрөө хийнэ гээд ч та надтай ингээд л. Наадхыг чинь олон бизнесүүд өөрсдөө хийгээд өгнө. Наад 12.0 тэрбум төгрөгөө наад банкнаасаа гаргах хэрэгтэй шүү дээ.

Наад бүсгүй чинь буруу яриад байна. Намайг Эдийн засгийн байнгын хорооны дарга байж байхад 5 их наяд төгрөг л байсан шүү дээ. Тэгээд 13, 14 их наяд төгрөгийн юм байлгачхаад тэгээд бодлого.

Үнэхээр 7.4 их наяд чинь байгаа юм бол. 4 тэрбум болохоор нь буцаад бодлогын хүүгээ өсгө л дөө. Бид 2 тэрбум доллартой, бүр хасах тэрбум доллартой 2016 онд хүлээж авч байсан биз дээ. Бодлогын хүү чинь ийм байхад. Тэгээд зээлийн хүү чинь 17.

Л.Соронзонболд: Ж.Ганбаатар гишүүн түрүүн алт, зэсийн үнэ ийм өндөр байхад төсөв яагаад алдагдалтай гарав гээд асуусан шүү дээ.

Тийм ээ. Сангийн яам түүнд хариулахаар бэлдэж байгаарай.

Ажлын хэсгийн 5 номер.

Ж.Энхбаяр: Төсвийн байдал. Төсвийн орлого эхний 3 сарын байдлаар 6.3 их наядын орлоготой байгаа.

Энэ нь ноднингийн мөн үеэс 153.0 тэрбум төгрөгөөр буюу 2.5 хувиар илүү явж байгаа.

Төсвийн зарлага 7.7 их наяд болж, өмнөх үеэс 1.2 их наяд буюу 17 хувиар өссөн байгаа.

Ингээд тэнцэл маань дотоодын нийт бүтээгдэхүүний 1.3 хувьтай тэнцэх хэмжээний буюу 4.1, 4 тэрбумын тэнцлийн алдагдалтай.

Хуулиар зөвшөөрөгдсөн, Улсын Их Хурлаас баталсан хуулийн хүрээнд бид 1 хувь дээр жилийн эцэст гарах ёстой. Үүнийг дунд хугацаандаа зохион зохицуулаад хүрнэ гэж тооцож байгаа.

эгээд яагаад ийм байдал үүсэх вэ гэдэгт. Алдагдал дээр. Урсгал зардлын хэт нэмэлт. Энд үнэхээр Их Хурлын гишүүдэд хандаж хэлэхэд урсгал зардлыг хэт нэмсэн. 4-өөс 6 их наяд дээр огцом нэмсэн нэмэлт маань өөрөө эдийн засаг, мөнгөний бодлого... /минут дуусав/

Л.Соронзонболд: 5 номерын микрофоныг нээе. Гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Урсгал зардлыг эрс нэмсэн байдал маань өөрөө инфляц, мөнгөний бодлого, бүхий л макро эдийн засгийн нөхцөлд нөлөөлж байгаа байдал маань энэ.

Нөгөө талаас бид харзнаад байна шүү дээ. Шатахууны үнийн өсөлт огцом өндөр гарсан нөхцөлд импортоор дамжаад бид чинь сардаа 250 мянган тонн орчим шатах тослох материал. 200 гаруй сая доллар шилжүүлж байгаа. Одоо энэ чинь 400 сая доллар шилжүүлэх болоод байгаа байхгүй юу.

Ингээд гадаад валютын нөөц дээр хэрвээ үнэ өсөөд баррель нь 150-иас 160, 180 гээд бүгд дээр нь тооцсон. 2-оос 4 тэрбум долларын гадаад валютын нөөцөд дарамт ирэх эрсдэл байна. Энэ болгоныг бид ажиглаад, хараад аль болох зардлаа багасгаж байна. Бүх орлогыг нэмэгдүүлэх, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг хийж байна. Ханшийнхаа тогтвортой байдлаа хадгалах, валютынхаа нөөцийг хадгалах нь их чухал байна. Ийм л байна.

Тэгээд засаг ахиад хэлье. Бүхий л шатад хэмнэлтийн бодлого хэрэгжүүлж байгаа.

Л.Соронзонболд: Ж.Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Би түрүүн тэр экспортыг асуухдаа би зүгээр түүхий эдийг асуугаагүй юм л даа. Үйлдвэрлэл л асуусан юм. Эцсийн бүтээгдэхүүн асуусан юм.

Би мах, нүүрс, зэс яриагүй юм л даа. Би наадхыг чинь маш сайн мэдэж байгаа шүү дээ. Би өөрөө сайд байсан. Миний үед л.

Та өнөөдрийг яриад байгаа юм бол миний үед бүр харин их нэмэгдсэн. Хэд боллоо. Мэдэж байгаа байх.

Санаанаас ганц өгүүлбэр юм уу, нэг үсэг аваад. Эдийн засаг чинь үнэхээр бүр ямар ч юугүй болсон шүү. Сая хэний тайланд гарав? Аж ахуйн нэгжүүд үнэхээр татвараа төлөх боломжгүй байна. Зээл их аваад байна гэж. Тэр зээл их аваад байна гэдэг чинь хөөрхий чармайгаад л байна гэсэн үг шүү дээ. Тэгээд үлдэгдэл нь нэмэгдээд л байна гэсэн үг.

Тэгэхээр бусдад боломж өгөх хэрэгтэй дээ. Төр өөрөө л бүгдийг нь чадна гээд л дайраад байх биш. Бодлогын хүүг бууруулах хэрэгтэй. Би дараагийн энэ Монголбанкны тайлан дээр үүнийг... /минут дуусав/

Л.Соронзонболд: Санал хэллээ. О.Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Тодорхой хэдэн асуулт асууя.

2027 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөл. Ямар ч байсан урьд өмнөх жилүүдийнхээ, ялангуяа уялдаа холбооны хувьд илүү сайжраад орсон гэж харлаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн үнэлгээ байна. Тийм ээ.

Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуумаар байна. Үнэлгээн дотроо хангалтгүй гэж үзсэн нь хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоо. Нэг ёсондоо бид бодлогоо буцаад хянаж чадахгүй бол хэрхэн хэрэгжиж байгаа вэ гэдгээ бид үнэлж чадахгүй шүү дээ. Энэ дээр нэмэлт тайлбар авмаар байна.

Мөн үнэлгээн дээрээ хязгаарлагдмал гэж дүгнэсэн нь төсвийн хуваарилалт бодитой хэрэгцээнд суурилсан байх дээр хязгаарлагдмал байна гэж дүгнэсэн байна.

Тэгэхээр энэ хоёр дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс тайлбар авъя.

Хоёр дахь асуулт. Тэргүүн Шадар сайдаас асууя.

Бид таван жилийнхээ үндсэн чиглэлийн дагуу яг энэ орж ирсэн хөгжлийн төлөвлөгөөгөөр 326 төсөл, арга хэмжээнд 65.5 их наядын санхүүжилт тавигдсан байна. Тийм ээ. Тэгээд яах вэ, энэ жил 2027 онд шаардлагатай нь 18.3 гэж.

Тэгээд бодлогын чиглэлээрээ бид 8 хувааж байгаа. Тэр дундаа хүний хөгжлийн. Боловсрол, эрүүл мэнд гэсэн үг шүү дээ. Аваад үзэхээр нийт санхүүжилтийнхээ ер нь таван жилийнхээр аваад үзэх юм бол 6 хувь л байна.

Тэгэхээр бид “хүний хөгжил” рүү нийт санхүүжилтийн 6 хувь гэдэг маань чамлалттай сонсогдоод байна л даа.

Ер нь том зургаараа макро түвшинд нь бид аваад үзэх юм бол. Ер нь бид хаашаагаа хөгжлийн төлөвлөгөөгөө чиглүүлж байна, ямар төсөл, хөтөлбөрөө бодлогын хүрээнд илүү дэмжих юм гэдэг дээр “хүний хөгжил” энэ дээр 6 хувь л гэж гарч ирж байна.

Яах вэ, 2027 оны шаардлагатай санхүүжилтээр бодохоор 8.5. Яамдаар нь ангилж үзсэн байна. Төсвийн ерөнхийлөн захирагчдаар. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээр боловсрол, эрүүл мэнд хоёрыг нэмээд үзэх юм бол нийт санхүүжилтийн 5.3 хувь харагдаж байгаа юм.

Тэр дундаа Боловсролын яам 1.3 их наяд. Тийм ээ. Нийт санхүүжилт нь шүү. Гэтэл энэ дүн маань Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаасаа бага байх юм л даа.

Тэгэхээр чинь бид боловсролоо, хөрөнгө оруулалтаа ч анхаарахгүй болохоор чинь тэр цахим хөгжил чинь боловсролоос шууд хамааралтай шүү дээ.

Тэгэхээр том зургаараа энэ хүний хөгжил рүү 6-аас 7 хувь хөрөнгө оруулалт орж байгаа нь нийт төсөл, арга хэмжээний хувьд авч үзэж байгаа нь Та үүнийг юу гэж дүгнэж байна?

Дараагийн нэг асуулт жижиг, дунд үйлдвэрлэлтэй холбоотой юм асууж байна. Тэргүүн Шадар сайд асууя. Та Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд байсан. Өнөөдөр 200 орчим тэрбум төгрөгийн нийт зээлийн эргэлт жижиг, дунд үйлдвэрлэлийн сан дээр байгаа юм билээ.

Ер нь энэ Жижиг, дунд үйлдвэрлэлийн сан өөрөө үнэхээр яг үнэнийг хэлэхэд Монгол шиг яг ийм жижигхэн эдийн засаг дээр үнэхээр ач холбогдолтой. Сонгон шалгаруулалтын хувьд өчигдөр дэд хороон дээр авч үзсэн. Ер нь нэлээн сайжраад явж байгаа юм байна. Цаашдаа илүү бэхэжсэн бие даасан институц болох зайлшгүй шаардлагатай юм билээ.

Гэтэл 2026 оны төсөв дээр 55 тэрбумыг буцаад улсын төсөвт орлого олж төвлөрүүлэх үүрэгтэй юм байна.

Тэгэхээр 55 тэрбум төгрөг эргээд зээл болж гарах биш улсын төсөвт буцааж очдог нь яг ямар учиртай юм бэ?

Сүүлийн асуулт. Боловсролын яам. 2026 оны төсөв дээр Боловсролын зээлийн сангийн эргэн төлөлт 145.0 тэрбум гэж тусгасан. Энэ 145.0 тэрбум эргэн төлөгдөж байж 145.0 тэрбум төгрөгийн хэмжээний боловсролын боломж болж очих ёстой байгаа.

Одоогийн байдлаар хэдэн тэрбум төгрөг эргэн төлөгдсөн байгаа вэ? Үлдэгдлийг нь хэрхэн төлүүлнэ гэж стратеги төлөвлөгөө гарган ажиллаж байгаа вэ гэдэг асуулт асууя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

Ж.Энхбаяр: Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан нэлээн муу нэртэй байсан. Одоо нөхцөл байдал өөр болсон. Та танилцсан байх.

Өнөөдөр улсын төсөв, гадаад зээл, татан төвлөрүүлсэн зээлдэгчдийн өмнө бүх өр төлбөрөө төлөөд, өөрийн эргэлтийн эх үүсвэртэй болсон. Хамгийн чанартай эргэн төлөлт хийгддэг. Жижиг, дунд үйлдвэр, бичил бизнесийг хамгийн сайн дэмжиж байгаа Монголд байгаа цорын ганц сан.

Сүүлийн 5 жил, 6 жил улсын төсвөөс нэг ч төгрөгийн хөрөнгө оруулалт ороогүй. Өөрөө өөрөөрөө явж ирж байгаа. 2026 онд 30 гаруй тэрбум төгрөгийг л зарцуулах орон зайтай. Тэгээд үүнийгээ арвижуулах бодлогыг барьдаг.

Орон нутгийн хөгжлийн сангууд байгаа. Хөгжлийн эх үүсвэрүүдийг. Жишээлбэл, Өмнөговь их сайн байдаг. 2 тэрбум төгрөгийн Жижиг, дунд үйлдвэрийн сангаас хөрөнгө оруулалт, зээлийн эх үүсвэр гаргахад аймаг 2 тэрбумыг нэмж өгдөг. Ингэвэл 4 тэрбум болдог. Энэ мэтчилэнгээр хэрэглээг жоохон арвин болгох бодлогыг л авч хэрэгжүүлдэг.

Улсын төсвөөс нэмэх шаардлага байгаа. Гэхдээ даанч санхүүгийн тийм боломж байхгүй. 50 тэрбум төгрөгийг буцаан улсын төсөвт төвлөрүүлэх үүрэгтэй. Ийм байдалтай л байгаа.

Тэгэхээр хамгийн сайн эргэн төлөгддөг, хамгийн үр дүнтэй ашиглагдаж байгаа ийм зээлийн багц байдаг юм шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиа бид баталсан. 2026-2030 оны нийгэм, улс орныг хөгжүүлэх хөтөлбөрөө баталсан. Энэ хөтөлбөрт нийцүүлж хөгжлийн бүх дараа дараа жилийн төлөлтүүд ордог болсон.

Улс төрийн намууд зөвхөн энэ таван жилийн төлөвлөгөөнд нийцүүлж улс төрийнхөө сонгуулийнхаа мөрийн хөтөлбөрийг боловсруулахаар хуулиар хүлээсэн.

Хэрвээ энэ хууль нь нийцэхгүй бол сонгуульд нэр дэвшихийг нь хязгаарладаг. Оруулахгүй, бүртгэхгүй байх хүртэл хатуу зохицуулалттай. Монгол Улсын бодлого тогтвортой, улс төрөөсөө ангид, урт хугацаанд хэрэгжих бололцоо дөнгөж л саяхнаас бүрдэж эхэлж байна шүү дээ.

Ингээд хаана хаана төсвийн сахилга бат нь сайжраад, төсвийн хүрээг нэлээн өндөр түвшинд боловсруулдаг. Төсвийн хүрээн дотроос Сангийн яам төсвөө зохиодог болж байна.

Үүнээс дур зоргын нэмдэг. Ялангуяа гишүүд таван жилийн үндсэн чиглэлд ороогүй хөтөлбөрүүдэд санал гаргаад хураагаад шийдэх, оруулах ямар нэгэн байдал хуулиар хязгаарлагдаж байгаа. Ингэхээрээ бодлого тогтвортой хэрэгжих нөхцөлүүд бүрдэж байна.

Тэргүүлэх чиглэл дээр ерөөсөө л нэг номерт эрчим хүч байгаа. Эрчим хүчний уурхай, нүүрсний уурхай, нүүрс тээвэрлэлт, түгээх, үйлдвэрлэх, хэрэглэх гээд бүх түвшинд үнийг хатуу барьсан. Сүүлийн 15 жил. Үүнтэй холбоотойгоор салбар хүндэрсэн. Монгол Улсын хөгжлийнхөө зорилтыг хангах боломжгүй болсон. 2027 оноос нэг ч байшин барилга, үйлдвэр бариад, цахилгаан, дулаанаар хангах техникийн чадавх байхгүй болсон.

Иймд тэргүүн ээлжид эрчим хүчний салбарыг либералчлах, үнэ тарифын зохицуулалтыг хийх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь онцгой чухал байгаа.

Мөн хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, аялал жуулчлал гээд салбарыг дэмжих бидэнд 4-өөс 5 жилийн цонх үе байна. Уул уурхайн идэвхжилийн үе. Энэ үеийг ашиглаад энэ салбартаа түлхүү хөрөнгө оруулалт, бодлогын бөгөөд дэмжлэгийн арга хэмжээг зайлшгүй хийх шаардлага байгаа.

Нөгөө талаар заавал анхаарах юм бол урсгал зардлыг нэмэх асуудлыг хязгаарлахгүй бол Монгол Улсын төсөв үндсэндээ дээд потенциалгаа үндсэндээ шавхаад дуусаж байна.

Хөгжлийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт хийх чадавхаа дуусаж байгаа. Зөвхөн үргэлжилж байгаа төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх хэмжээ 2.2 их наядын хэмжээнд орж ирж байна.

Гадаад зээлийг хууль эрх зүйн орчинд таатай болбол жоохон эх үүсвэр нэмэгдэнэ. Бусдаараа хязгаарлагдмал. Үүнтэй холбоотой... /минут дуусав/

Л.Соронзонболд: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Ажлын хэсгийн 3 номер хариулъя.

Ж.Дэлгэрсайхан: Баярлалаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Ж.Дэлгэрсайхан.

О.Батнарамдал гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, сая Ж.Энхбаяр сайдын ярьсан дээр үргэлжлүүлээд.

Энэ жилийн хөгжлийн төлөвлөгөө бодлогын хувьд хуулийн нийцэл шаардлагыг хангасан байдлаараа нэлээд өндөр ахиц дэвшил гарсан гэдгийг манай зөвлөлийн дүгнэлтэд дурдсан.

Эхний асуулт болох төсвийн хуваарилалт нь бодит хэрэгцээнд суурилсан байх зарчим нь явах тэр хязгаарлагдмал гэдэг дээр Эдийн засаг, хөгжлийн яамтай яг ижилхэн зарчим яриад байгаа юм.

2.2 их наяд төгрөгөөс илүү яг бодит хэрэгцээнд суурилоод төсөв хуваарилъя гэхээр улсын төсвөөр дамжуулж төсвийн хөрөнгө оруулалт хийх боломжгүй болсон. Үүнийг манай зөвлөл өмнөх дүгнэлтүүд дээрээ бодлогын орон зай шахагдаж байна. Бодит хөрөнгө оруулалтыг шахан гаргах үзэгдлийг нь урсгал зардлыг хэт өсөлтөөсөө болоод гарч байна гэсэн ийм зүйлийг бид ярьсан.

Хоёр дахь асуултад тэр “смарт” гэдгийг манай Эдийн засаг, хөгжлийн яам, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хоёулаа ашиглаад байгаа.

Гэсэн хэдий боловч энэ 300 хэдэн төсөл дотор... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 3 номерыг нэе. Гүйцээж хариулъя.

Ж.Дэлгэрсайхан: Смартыг бид хоёулаа ашиглаад явж байна. Бид яг тэр чиглэлээр нь дүгнэлтээ гаргаж байна.

Эдийн засаг, хөгжлийн яам маань яг түүгээр хийж ирүүлсэн гэдэг ийм зүйлийг баримтаар дурдсан. Гэхдээ зарим төслүүд дээр яг үр дүнгийн үзүүлэлт нь төслийн хэрэгжилтээр барилгын ажлын гүйцэтгэлээр хэмжинэ гээд орхичихоор эргээд смарт зарчмаараа үнэлэх, хянах боломж нь хязгаарлагдаж байна гэдгийг зарим төслүүд дээр дурдсан.

- Гүйцэтгэл нь хэдэн хувь байх юм,
- Бүрэн дууссан байх юм уу,
- Төслийн 30 хувь нь явсан байх юм уу гээд.

Үүнийг илүү нарийвчлан улам цаашаа сайжруулъя гэдэг агуулгаар үүнийг хэлсэн. Баярлалаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 7 номерыг нэе.

Т.Ням-Очир: О.Батнайрамдал гишүүний асуултад хариулъя.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир.

Энэ жил Боловсролын зээлийн сангийн батлагдсан төсөв 157.0 тэрбум. Хэрэгцээ шаардлага нь өөрөө 187.0 тэрбум.

Тэгэхээр зээлийн эргэн төлөлтийг энэ жил 30 тэрбумаар төлөвлөсөн.

Тэгэхээр одоо Боловсролын зээлийн сангаас өгч байгаа мэдээллээр 3.7 тэрбум төгрөгийн л эргэн төлөлт хийгдсэн байна. Үүний –

- дотоодын хөнгөлөлттэй зээл 684.0 сая,
- дотоодын оюутны хөгжлийн зээл 2.7 тэрбум,
- гадаад зээл 217.6 сая гэсэн нэг ийм тоо байгаа.

Зээлийн эргэн төлөлтийг сайжруулахын тулд Та бүхэн мэдэж байгаа байх. Боловсролын сайд, Монгол Улсын ерөнхий прокурортой хамтарч зээлийн эргэн төлөлтийг сайжруулах чиглэлээр уулзалт хэлэлцээрүүдийг эхлүүлсэн.

Тэгэхээр үүнтэй холбоотой зээлийн эргэн төлөлт дээр тодорхой сайжруулалтууд гарна гэж тооцож байгаа.

Дээрээс нь, ер нь Та бүхэн мэдэж байгаа. Боловсролын зээлийн сан нь одоогийн байдлаар... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 7 номерыг нээе. Гүйцээж хариулъя.

Т.Ням-Очир: Өөрийн гүйцэтгэх чадавхаас хэтэрсэн ачаалалтай ажиллаж байгаа.

Өөрөөр хэлбэл 523.0 тэрбум төгрөгийн хөрөнгө, 28 мянга гаруй тэтгэлэгтэн, 1255 гадаад зээлийг ерөөсөө л 32 хүнтэй ажлын алба гүйцэтгэж байгаа.

Тийм учраас цаашдаа зөвхөн зээл олгох, санхүүжүүлэх гэхээсээ илүүтэйгээр бүтэц, зохион байгуулалт, стратегийн хувьд цоо шинэ концепцоор авч явах хэрэгцээ шаардлага байгаа гэж харж байгаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номерыг нээе.

Ж.Энхбаяр: Хүний хөгжлийн бодлого Засгийн газрын тэргүүлэх чиглэл байгаа.

Боловсрол, эрүүл мэндийн салбарт л гол цалингийн өсөлт. Яагаад гэвэл “хүний хөгжил” гол тулгамдсан асуудал гэж үзсэн.

2025 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 5.7 хувь. Энэ их өндөр гарсан. Улсын төсвийн нийт зарлагын 19.6 хувийг зөвхөн боловсролын салбарт хүргэж байгаа. Эрс нэмэгдүүлсэн.

2027 онд 37 цэцэрлэг, 53 сургуулийг ашиглалтад оруулна. Шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр нь хангах ажлыг улсын төсөв болон гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэхээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа.

Тэгэхээр энэ салбарт хүний хөгжил, эрүүл мэнд, боловсролын чиглэлээр хийгдэж байгаа ажлууд чамлахааргүй. Манай бүх төсвийн гол ачаалал бараг энэ дээр явж байгаа. Энэ 2 салбар дээр гол явж байгаа.

Нийт төсвөө, зарлагаа ингээд үзэх юм бол 37 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө... /минут дуусав/

Л.Соронзонболд: Тодруулах юм уу? О.Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: Тэргүүн Шадар сайд аа, төсвийн ерөнхийлөн захирагчдаар нь аваад үзэхээр Та хараарай.

Боловсролын яаман дээр байгаа нийт санхүүжилт Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас чинь бага байгаа байхгүй юу. Том зургаар нь гарч байгаа юм л даа.

Тэгэхээр хүний хөгжил гэхээр урсгал зардал гэж харж болохгүй. Хүний хөгжил дээр Монголд дутаад байгаа юм нь хөрөнгө оруулалт байхгүй юу.

Боловсрол, эрүүл мэндийн салбар дээр явах хөрөнгө оруулалт. Бид урсгал зардлаа томруулаад шинэ хөрөнгө оруулалт нь тэр салбар дээр орохгүй байгааг л асуугаад байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Боловсролын яам сая надад 2025 оны тоо хэлээд байна шүү. Төрийн нарийн. Тийм ээ. Анхаараарай. 2026 оны тоо асуугаад байгаа шүү дээ.

Тэр 33.6, 158.4 гэдэг гэдэг чинь 2025 оны төсөв шүү. 2026 оны төсөв дээр 145.6 тэрбумыг эргэн төлөлт гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр эргэн төлөлтийг та нар ийш тийш хаяхгүй шүү. Энэ Та нарын үндсэн ажил шүү. Эргэн төлөлтөөр Та нарын ажлыг буцаагаад дүгнэнэ.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер хариулъя.

Ж.Энхбаяр: Нийт улсын төсвийн маань боломж хязгаарлагдмал.

2025 онд их сонин тоо гарсан.

- ▶ Монгол Улс эрчим хүчний салбар түүхэндээ байгаагүй хамгийн дээд хэмжээний цахилгаан, дулаан үйлдвэрлэсэн байна лээ.
- ▶ Эрдэнэт үйлдвэр түүхэндээ байгаагүй хамгийн дээд хэмжээний олборлолт, баяжуулалт, экспорт хийсэн.
- ▶ Нүүрсний салбар 95 сая тонн. Түүхэндээ байгаагүйг олборлож 90 саяыг экспортолсон.
- ▶ Төмөр зам түүхэндээ байгаагүй хамгийн дээд ачаа тээвэр хийсэн.
- ▶ Ажиллах хүчний оролцоо 63 хувь. Хамгийн дээд түвшиндээ шахсан.

Үндсэндээ бид байгаа эдийн засгийн суурь потенциалгаа бүрэн ашиглаад дуусаад байна.

1 тэрбум долларттой байсан эдийн засгаа 25 тэрбум доллар болгочоод, 1 хүнд ногдох орлого нь 7300 доллар хүрчхээд байна. Бас чамлахааргүй амжилт нь бидний өнгөрсөн 20 жил.

Одоо бидэнд –

- шинэ эдийн засаг,
 - шинэ экспорт,
 - шинэ зах зээл,
 - шинэ эрчим хүч,
 - шинэ төмөр зам,
 - шинэ Тавантолгой,
-

- шинэ Оюу Толгой,
- эдийн засгийн шинэ бүтэц хэрэгтэй байна.

Одоо байгаа потенциал чинь дуусаад байна. Тэр хэмжээндээ төсөв...
/минут дуусав/

Л.Соронзонболд: М.Энхцэцэг гишүүн асуулт асууя.

М.Энхцэцэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсыг 2027 онд хөгжүүлэх төлөвлөгөөгөө бид бүхэн ярьж байна.

Тэгэхээр ийм чухал юман дээр салбар хариуцсан сайдууд байхгүй байна.

Ялангуяа Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг ганц боомлоод байгаа эрчим хүчний салбар, ард түмнийг өвөлдөө хөлдөөх гээд байгаа эрчим хүчний салбарын сайд нь өнөөдөр алга байна.

Тэгээд хэн асуултад хариулах байгаа юм? Тэгээд хэд хэдэн асуулт байна л даа.

— **Нэгдүгээрт**, өмнөх онуудын төлөвлөгөөн дээр байсан нэлээн олон ажлууд 2027 оны төлөвлөгөө дээр байхгүй болсон байна.

- Энэ ямар учиртай юм бол оо?
- Ямар үндэслэлээр хасагдсан юм бэ?

- › Байдрагийн усан цахилгаан станц,
- › Эгийн голын усан цахилгаан станц,
- › төвийн бүсэд 100 мегаваттын ус хуримтлуурын усан цахилгаан станц,
- › Багануурын цахилгаан станц,
- › Архангай, Өвөрхангайд 10 мегаваттын нар, 20 мегаваттын цагийн батарей барина –

-гэсэн ажлууд байсан. Бүгдээрээ байхгүй болсон байна. Үүний үндэслэлийг нь тайлбарлаж өгөөч.

— **Хоёрдугаарт**, айл өрхийн сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төлөвлөгөө дээр ямар нэгэн тоо хэмжээ алга. Мянган киловатт гэсэн байна.

Тэгэхээр мянган киловатт чинь аль хэдийн баригдчихсан шүү дээ.

Ерөнхий сайд болохоор мэдэгдэлдээ хэд хоногийн өмнө “10 мянган айл” гээд мэдэгдсэн.

Тэгэхээр 10 мянган айлыг үнэхээр 2027 онд төлөвлөсөн юм уу, үгүй юу? Энэ дээр яг тодорхой хариулт өгөөч ээ.

— **Гуравдугаарт**, мөн Ерөнхий сайд хэдхэн хоногийн өмнө 5 аймаг дээр 150 мегаваттын тархмал эх үүсвэрийг барина гэсэн.

Энэ тархмал эх үүсвэр Эрчим хүчний яамнаас төлөвлөөд байгаа 6 аймаг дээрх 115 мегаваттын тархмал эх үүсвэрээс тусдаа асуудал юм.

Тэгэхээр Ерөнхий сайдын яриад байсан 5 аймгийн тархмал эх үүсвэр энэ төлөвлөгөө дээр бас алга байна. Энэ ямар учиртай вэ?

Мөн Ерөнхий сайд ногоон зээлийн хүүг бууруулж байж тэр айл, өрхүүд сэргээгдэх эрчим хүч ашиглаад эрчим хүчээ хэмнэх, мөн илүүдэл цахилгаанаа сүлжээнд борлуулаад орлого олох боломжийг нэмэгдүүлнэ гэсэн.

Тэгэхээр энэ ногоон зээлийн хүүг бууруулах талаар ямар нэгэн төлөвлөгөө дээр алга байна. Та бүхэн яаж, ямар механизм ашиглаж ногоон зээлийн хүүг бууруулна гэж төлөвлөж байгаа вэ гэсэн ийм 4 асуулт байна. Та бүхэнд тодорхой хариулж өгнө үү.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

Ж.Энхбаяр: Эрчим хүчний салбарт либералчлалыг үргэлжлүүлэх, тарифыг чөлөөлөх асуудал тулгамдсан асуудал. Олон жил үнэ барьсан.

Үүнтэй холбоотойгоор салбар өөрөө өөрийгөө хөгжүүлээд аваад явах, өөрөө өөртөө эргэж хөрөнгө оруулалт хийх, шинэ технологи нэвтрүүлэх бололцоогоо алдсан.

Нүүрсний уурхайгаас авхуулаад нүүрс тээвэр, эрчим хүч үйлдвэрлэл, түгээх, дамжуулах, хэрэглэгчийн бүх түвшинд үнийн бодлого хатуу мөрдөж байгаа.

Энэ хатуу мөрдсөний үр дүнд үндсэндээ салбар хүндэрсэн. Өнөөдөр манай эрчим хүчний салбар дээд хүчин чадалтай тулсан. Одоо дахиж ямар нэгэн байшин барилга, үйлдвэр, аж ахуйн нэгжид эрчим хүч, дулаан, цахилгаан хангах бололцоогүй болж байгаа.

Иймд эрчим хүчний салбарт яаралтай бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

Тийм болохоор 2027 оны гадаад зээл, тусламж, гол бодлого эрчим хүчний салбарыг нэг номерт анхаарч хэрэгжинэ. Нөгөө талаараа эрчим хүчтэй холбоотой тариф, үнийн чөлөөлөлтийн асуудлыг авч хэрэгжүүлэхээс зайлшгүй шаардлага үүсэж байгаа.

Нийт эрчим хүчний салбарыг яамнаас ирсэн 41 саналыг нь бүтэн тусгаж явж байгаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх бололцоонууд байхгүй. Гадаад зээлийн ашиглалт дээр 10-аад төсөл. Нийт 1.3 их наядын өртөгтэй гадаад зээлийн ашиглалт эрчим хүчний салбарт төслүүд дээр явж байгаа.

Аль болох л хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр шууд хөрөнгө оруулалтаар л явна. Таны яриад байгаа сэргээгдэхийн энэ бүх төслүүд дандаа нээлттэй дуудлага худалдаагаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт дээр л тулгуурлана.

Одоо энэ Налайх, Чойрын районд баригдаж байгаа Баянгийн, Бөөрөлжүүтийн бүх цахилгаан станцууд, тэр Сэлэнгийн. Бүгд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа.

Б.Чойжилсүрэн сайд 1200 мегаваттын хүчин чадлыг аваад 1800 болгоод 600 мегаваттыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шийдэж өгөөд ажлаа өгсөн.

Одоо бид үнэ тариф, салбараа либералчлах бодлогоо хэрэгжүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг урамшуулахгүй бол энэ асуудал манай улсын хөгжлийн гол гацаах бодлого энэ болж байгаа.

Нөгөө талаар урсгал зардал нэмэгдэлтэй холбоотойгоор улсын төсвөөр шийдэх бололцоогүй болж байгаа.

Ийм ийм л хайчинд бид орж ирж байна л даа.

Тэгэхээр аль болох л энэ салбарт яаралтай бодлогын арга хэмжээнд авч хэрэгжүүлнэ. Энэ яригдаж байгаа зорилтууд дандаа хувийн хэвшил дээр тулгуурлаж явагдана.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 7 номер.

Н.Ургамалсүвд: Ногоон зээлийн үлдэгдэл 3 сарын байдлаар 2.5 их наяд төгрөгт хүрсэн байна. Нийт банкны системийн зээлийн багцын 5.7 хувийг эзэлж байна.

Зээлийн хүү нь 14.1 хувьтай байна. Дундаж хүү нь. Ерөнхийдөө шинээр олгосон ногоон зээлийн хүү 14 хувьтай. Шинээр олгосон бусад зээлийн жигнэсэн дундаж хүү 17.8 хувьтай буюу бусад зээлүүдтэй харьцуулахад харьцангуй бага хүүтэй олгож байна гэж статистик мэдээлэл харахад ингэж харагдаж байна.

Өнгөрсөн онд ногоон зээлийн багц оны эцэст нийт багцын 5.3 хувийг эзэлсэн. 2.3 их наяд төгрөгт хүрсэн байсан. Оны эхнээс өсөөд 200 орчим тэрбум төгрөгөөр өсөөд 2.5 их наяд төгрөгт хүрч нэмэгдсэн байна.

Л.Соронзонболд: М.Энхцэцэг гишүүн тодруулъя.

М.Энхцэцэг: Асуултад ерөөсөө хариулахгүй байна л даа.

Би яг тодорхой дөрөвхөн асуулт асуусан шүү дээ. Ерөөсөө асуултад хариулсангүй. Зөвхөн энэ салбарын хүн болгоны мэдэж байгаа проблемыг л урдаас яриад байна л даа.

Миний саяын ярьсан 5 төсөл яагаад алга болсон юм. Тэр айл өрхийн 10 мянга гэж Ерөнхий сайд мэдэгдсэн. Энэ яагаад орж ирээгүй юм. Ерөнхий сайдын мэдэгдсэн 5 аймаг дээр тархмал барина гэсэн. Тэр яагаад төлөвлөгөөнд чинь орж ирээгүй юм гэсэн. Энэ чинь тэнэг хүн ч ойлгохоор ийм ойлгомжтой асуулт асуусан юм.

Гуравдугаарт нь, ногоон зээлийн хүүг бууруулна гэж Ерөнхий сайд хэлсэн.

Тэгэхээр тэр төлөвлөгөө чухам энэ дээр яаж орж ирсэн юм бэ? Бууруулна гэдэг чинь тэр яриад байгаа 14 хувиас чинь тэр 6 хувь руу, эсвэл 7 хувь руу оруулна гэдэг механизм хэрэгжүүлнэ л гэсэн.

Тэгэхээр үүнийг яаж оруулах юм бэ гэдэг энд л хариулаач гэсэн дөрвөн асуулт л асуусан. Тэгээд яг хариултаа авч чадахгүй байна л даа.

Яагаад гэхээр эрчим хүчний салбарынхан нэг ширхэг ч хүн энд алга.

Тэгээд яаж бид бүхэл бүтэн улс орноо хөгжүүлэх юм бэ?

Л.Соронзонболд: Эрчим хүчний яамнаас өнөөдөр энд хуралд хүн ирээгүй байгаа.

Тэгэхдээ саяын асуусан асуултуудад тэмдэглэж аваад, Эрчим хүчний яамнаас яг албан бичгээр М.Энхцэцэг гишүүнд хариулт өгөх ёстой гэж бодож байна.

Тэгэхээр энэ дээр манай Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаныхан анхаараарай гэж хэлмээр байна.

Ажлын хэсгийн 5 номерын микрофоныг нээе.

Ж.Энхбаяр: Төслүүд алга болохгүй. Нэгэнт Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиар улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 88 хөтөлбөр батлагдчихсан.

Тэгээд л аль болох л бид санал болгоод л хөөцөлдөөд л байгаа.

Жишээлбэл, Байдрагийн усан цахилгаан станцын төсөл Засгийн газрын хурлаар саналаа авсан. Төр, хувийн түншлэлээр хэрэгжихээр, нөгөө түншлэлийн хөтөлбөр болгож зарлах гээд орж ирж байгаа жишээтэй.

Хэнтийн Цэнхэрмандалын усан цахилгаан станц төсөл судлагдаж байна.

Хоёр улсын нөгөө хилийн усны хэлэлцээртэй холбоотойгоор асуудлууд цаг жоохон хойшлоод судалгааны ажлууд явагдаад байна.

Яг үндсэндээ Монгол Улсад хөрөнгө оруулах орчин маш муу байна.

Ялангуяа эрчим хүчний салбарт үнэ тарифын бодлоготой холбоотойгоор хөрөнгө оруулалт орж ирэхгүй байна. Энэ бүх төслийг чинь бид аль болох л нэмэхийн тулд бүгдийг л зарлаад л, хөөцөлдөөд л, яриад л байна. Үнэхээр хөрөнгө оруулалтаа дагуулж ирээд хийе гэвэл... /минут дуусав/

Л.Соронзонболд: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Ж.Ганбаатар гишүүнээр тасаллаа. Ж.Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Үг хэлье. Ж.Энхбаяр гишүүн жоохон инээж байх шиг байна.

Ер нь яах вэ, үгээ жоохон эрчийг нь бууруулаад хэлнэ. Тэгээд би 5 зүйл. Таны мэдэж байгаа 5 зүйлийг зүгээр сануулж хэлье.

Байнга ярьдаг байсан. Сайд болохоосоо өмнө надтай их сайхан харьцаатай байхдаа ярьдаг байсан 5 зүйлийг чинь сануулаад хэлье. Одоо ч сайхан харьцаатай байгаа л даа. Жоохон загнахгүй сонсоно шүү.

Төрийн данхар бүтцээ буулгая. Ж.Энхбаяр сайд аа. Тийм үү. Та урсгал зардал тулчихлаа гээд байна шүү дээ.

Үгүй ээ, зоримог хийе л дээ. Тийм. Та урсгал зардал тулчихлаа гэж. Төрийн зарим албан тушаалтнууд чинь үнэхээр санхүүтэйгээ харьцаж чадахгүй, ямар ч сахилга бат байхгүй.

Үүнийг Та зохион байгуулах бүрэн Шадар сайдын хувьд боломжтой байгаа шүү дээ.

Санхүүгийн сахилга бат үнэхээр бүр “тэг”. Ар гэрээ авч явж чаддаг юм уу, үгүй юу. Ийм хүмүүс төрийг авч явж чадна гэхээр үнэхээр. Манайд мөнгө байгаа гээд Та хэлж байна шүү дээ. Мөнгө боломж байна.

Тэгээд хувийн хэвшилдээ итгэдэггүй. Хувийн хэвшлээрээ юм хийлгэж сураагүй. Өөрсдөө л хийх гээд дайраад байна.

Тэгээд тэр нь бөөн хээл хахууль, бөөн санхүүгийн зөрчил. Би энэ үгийг анх удаа хэлээгүй шүү.

Ж.Энхбаяр сайд аа. Би сонгогдсоноос хойш байнга л хэлж байгаа. Хувийн хэвшил гэхээр би биш шүү. Би нэг ч тендер авч үзээгүй. Авах ч үгүй. Шаардлага байхгүй. Зарим хүмүүс хувийн хэвшил гэхээр өөрийгөө ярьж байна гээд боддог юм. Тэгээд баахан юм бичдэг юм над руу.

Тэгээд гаднын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хэрэгтэй шүү дээ.

Тэрийг дэмжихгүй байгаа хүмүүст маш юу гэдэг юм байгаа юм. Тэр хүмүүсийг ажиллуулахгүй байх хэрэгтэй шүү дээ.

Тэгээд Мөнгөний зөв бодлого хэрэгтэй байна.

Монголбанк зүгээр улс төрчдийн үгээр ажилладаг биш байх хэрэгтэй байна. Маш зөв мөнгөний бодлого явуулах хэрэгтэй.

Үүнийг Эдийн засгийн хөгжлийн яам зангидах. Би таны мэддэг юмыг хэлж байгаа шүү. Заахаар аягүй бол заалаа гэх.

Энэ мэдэж байгаа зүйлүүдээ уялдуулаач ээ. Би ахиад хэлье.

- ◆ Төрийн данхар бүтцээ бууруулаач.
- ◆ Санхүүгийн сахилга баттай байгаач.
- ◆ Хувийн хэвшилдээ итгээч.
- ◆ Гаднын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжээч.

- ◆ Уул уурхайн бус салбарт экспортын чиглэлд мөнгөний зөв бодлого явуулаач.

- ◆ Монголбанк улс төрчдийн үгээр биш өөрөө бие дааж үйл ажиллагаагаа явуулдаг болооч.

Үүнийг нь энэ яам нэгтгээч. Эд нарыг. Тэгээд үр дүн гарна шүү дээ. Зоримог байх хэрэгтэй шүү дээ.

Та өөрөө зөндөө олон зүйлүүдийг зөв талаас нь ярьдаг, санаачилдаг. Тэгэхдээ яг сайд болоод хийхэд хэцүү байгаа л даа. Би дэмжмээр байна.

Би ер нь сандал суудалтай холбоотой хурал дээр суухгүй байгаа. Яг ийм эдийн засагтай холбоотой хурал дээр би байнга сууж байгаа. Сайд аа.

Сая бүхэл бүтэн бараг 6, 7 сар сандал суудал ярилаа. Би нэг ч хуралд нь суугаагүй. Цаашдаа ч суухгүй.

Тэгээд хөгжлийн төлөвлөгөө уг нь ингээд бүр эрс өөр болох ёстой л доо. Тийм ээ. Та надтай нэг ярилцъя, яаман дээрээ дуудъя гээд таарахаараа нэг хэлдэг юм. Тэгээд цаашаа харахаараа мартчихдаг юм шиг байгаа юм.

Хөөе, Ганбаа нэг ирээрэй л гэдэг юм. Тэгээд худлаа. Би ч уг нь юм бэлдчихээд л байгаа юм л даа. Хавтсаа.

Л.Соронзонболд: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Үндэсний аудитын газраас өгч байгаа дүгнэлт санал, зөвлөмж ерөнхийдөө 2024 оноос хойш л хоёр ч удаа явлаа.

Тэгэхээр гаргаж байгаа зарим асуудлууд нь, алдаанууд нь дахин дахин давтагдаад байгаа асуудал аягүй их харагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр удирдагч хүмүүсийн хамгийн гол хийх ёстой ажлын чинь нэг бол төлөвлөгөө шүү дээ. Төлөвлөгөөгөө зөв хийж чадахгүй бол бид тэгээд сайн хэрэгжүүлж чадахгүй.

Тэгэхээр хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр алдааг дахин дахин гаргаад байгаа яам, хариуцсан ажилтнууд дээр хариуцлага тооцох тал дээр ер нь ажлын хэсгийн ахлагчийн хувьд ер нь цаашдаа яах юм бэ гэдэг дээр бодох хэрэгтэй болов уу гэж бодож байна.

Г.Лувсанжамц гишүүний хувьд ялангуяа шалгуур үзүүлэлтүүд дээр нэлээн тодорхой чиглэлүүд өгөөд байхад дахин дахин алдаатай орж ирээд байгаа асуудлууд гарч ирээд байна шүү дээ.

Энэ бол энэ ажлыг тухайн хариуцаж байгаа хүмүүс нь хийж чадахгүй байна аа л гэсэн үг.

Тэгэхээр тийм хийж чаддаггүй хүмүүс ажиллах шаардлагагүй байх гэж бодож байгаа.

Тийм учраас ер нь жилийн ажлын төлөвлөгөө дээр ажиллаж байгаа хүмүүсийн хувьд ажилдаа хандаж байгаа хандлага, хийсэн ажлынх нь чанар дээр үндэслээд хариуцлага тооцдог байх ёстой шүү гэдэг саналыг хэлмээр байна.

Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц танилцуулна. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

**Дөрөв. Монголбанкны 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,
Хяналтын зөвлөлийн тайлан**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.4-т заасан Монголбанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг хэлэлцэж эхэлье.

Монголбанкны санхүүгийн тайлангийн танилцуулгыг Монголбанкны Ерөнхийлөгч Санжаагийн Наранцогт хийнэ.

5 номерын микрофоныг нээе. Монголбанкны Ерөнхийлөгч.

С.Наранцогт: Эрхэм Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга,

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны эдийн засгийн болон Монголбанкны үйл ажиллагааны үр дүн, улмаар Төв банкнаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг Та бүхэнд товч танилцуулъя.

Монголбанкны үндсэн мандат болох үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах, инфляцын зорилтот түвшнийг барих, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хамгаалах чиглэлд бид онц тодорхой анхаарч ажиллаж байна.

1.Макро эдийн засаг болон мөнгөний бодлогын үр дүн.

2025 онд Монгол Улсын эдийн засаг урьдчилсан гүйцэтгэлээр 6.8 хувиар өслөө.

Энэхүү өсөлтөд уул уурхай, хөдөө аж ахуйн салбараас гадна өрхийн хэрэглээ, цэвэр экспорт голлон нөлөөлсөн байна.

Өнгөрсөн онд эдийн засгийн идэвхжил сайн байсан ч оны эхний хагаст импортын үнэ, эрчим хүчний тарифын өөрчлөлт, төсвийн тэлэлтээс шалтгаалан инфляц эрчимжиж, 2 дугаар сард 9.6 хувьд хүрсэн.

Энэхүү сорилтын эсрэг Монголбанк мөнгөний бодлогыг хатууруулж, бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлэн 12 хувьд хүргэсэн.

Үүний үр дүнд инфляц аажмаар буурч оны эцэст улсын хэмжээнд 7.5 хувь болж, Төв банкны зорилтот интервалд орж буурсан.

Гадаад секторын хувьд төлбөрийн тэнцэл 1 тэрбум ам.долларын ашигтай гарснаар гадаад валютын улсын нөөц оны эхнээс 1.5 тэрбум ам.доллаар нэмэгдэж, 7 тэрбум ам.долларт хүрсэн.

Энэ нь макро эдийн засгийн дархлаа, төлбөрийн чадвар, төгрөг итгэх итгэлийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Хэдийгээр бид өнгөрсөн онд ийм эерэг үр дүнд хүрсэн ч импортыг хөөрөгдөж буй хэрэглээний зээлийн хэт өсөлтийг хязгаарлах, гадаад валютын нөөцөө хамгаалахад илүү хатуу зогсох шаардлага бидний өмнө тулгарч байна.

Иймд оны эхэнд мөнгөний бодлогын хороог ээлжит бусаар хуралдуулж, өр орлогын харьцааны дээд хязгаарыг 45 хувь болгон бууруулж, банкны төгрөг болон гадаад валютын заавал байлгах нөөцийг нэмэгдүүлэх шийдвэрийг цаг алдалгүй гаргасан.

Энэхүү урьдчилан сэргийлж угтуулсан бодлогын хатуу арга хэмжээ сайн үр дүнгээ өгч энэ оны 4 дүгээр сарын байдлаар манай улсын гадаад валютын нөөц түүхэн дээд хэмжээ буюу 7.3 тэрбум ам.долларт хүрч баталгааждаг байна.

2. Банк санхүүгийн салбарын тогтвортой байдал.

Банкны салбар нь эдийн засгийн гол судас болохын хувьд Монголбанкнаас хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрээр эрчимтэй явуулж байна.

Банкны системийн чанаргүй зээлийн харьцаа 5.1 хувь болж буурсан нь эерэг сайн үзүүлэлт юм.

Системийн нийт өөрийн хөрөнгө 8.1 их наяд төгрөгт хүрч, өөрийн хөрөнгийн хүрэлцээ 15.8 хувьтай гарсан нь салбарын эрсдэл даах чадвар сайжирсныг илтгэж байна.

Оны эхнээс бид санхүүгийн салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд томоохон алхмуудыг хийж байна. Тухайлбал, шинээр байгуулагдсан Ногоон санхүүжилтийн хэлтсээрээ дамжуулан Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк, Азийн хөгжлийн банктэй хамтарсан төслүүдийг эхлүүлж, эмэгтэй бизнес эрхлэгчдийн болон ногоон зээлийн хүртээмжийг бодитой нэмэгдүүлэх, салбарын эрсдэл даах чадварыг олон улсын Базелийн стандартад бүрэн нийцүүлэх ажлыг эрчимтэй хэрэгжүүлж байна.

3. Төвбанкны засаглал, санхүүгийн болон бүтцийн шинэчлэл.

Монголбанк өөрийн үйл ажиллагаандаа ч шинэчлэлийг амжилттай эхлүүлж байна. Дэд бүтэц, зохион байгуулалтаа оновчилж, 19 газрыг 10 газар болгон нэгтгэж, 700 байсан орон тоог 560 болгон цомхотгосноор шуурхай, үр ашигтай тогтолцоонд шилжиж эхлээд байна.

Энэхүү шинэчлэл цаашдаа илүү чадварлаг хүний нөөцийг бэхжүүлэх чиглэлд тасралтгүй үргэлжлэх болно.

Шинэ бүтэц, зохион байгуулалтын хүрээнд бид Санхүүгийн тогтвортой байдлын газрыг шинээр байгуулж түүний дотор Тогтвортой ногоон санхүүжилтийн хэлтсийг тусгайлан байгуулж ажиллаж эхэллээ.

Бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож даргын орон тоог 50 орчим, нийт орон тоог 19 хувиар цомхотгосоноор үйл ажиллагааны зардлыг жилд 15.1 тэрбум төгрөгөөр хэмнэж байна.

Энэхүү засаглал, реформ, санхүүгийн тайлагналын сайжруулалт болон өмнө жилүүдэд өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлсний үр дүнд олон улсын хөндлөнгийн аудитаас бид 8 жилийн дараа хязгаарлалтгүй дүгнэлт авч чадлаа.

Монголбанкны Хяналтын зөвлөлөөс Монголбанкны 2025 оны санхүүгийн тайланд болон үйл ажиллагаанд өгсөн санал, зөвлөмжийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөж байна.

Монголбанк өнгөрсөн олон жилийн хугацаанд санхүүгийн болон үйл ажиллагаандаа хуримтлагдаж бий болсон асуудлуудаа углуургаар нь шийдвэрлэх, орчин үеийн технологид суурилсан олон нийтийн итгэл даахуйц хараат бус институт болон төлөвшихийг зорьж байна.

Энэ хүрээнд бид инфляцыг нам түвшинд тогтвортой хадгалж, ард иргэдийнхээ амьдралын чанарыг хамгаалах, цаашлаад бизнес, хөрөнгө оруулалтын таатай, урьдчилан таамаглах боломжтой орчныг бүрдүүлэх алсын хараа бүхий Монголбанкны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг цогцоор нь боловсруулж хэрэгжүүлж эхлээд байна.

Бид энэхүү стратегийнхаа хүрээнд оны эхнээс Монголбанкны үйл ажиллагааг бүрэн цахимжуулах, хяналт шалгалтыг автоматжуулах, технологийн шинэчлэлүүдийг эрчимтэй нэвтрүүлж эхэлсэн бөгөөд Төвбанкны засаглалын реформыг эргэлт буцалтгүйгээр бэхжүүлэн ажиллаж байгаагаа мэдэгдэхэд таатай байна.

4.Хууль, эрх зүйн шинэчлэлийн хэрэгцээ шаардлага.

Эрхэм гишүүд ээ,

Бид богино хугацааны гал унтраах арга хэрэгсэл, арга хэмжээнүүдийг авч тодорхой үр дүнд хүрсэн хэдий ч дунд, урт хугацаанд эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлаа баталгаажуулахын тулд эрх зүйн орчны шинэчлэл зайлшгүй шаардлагатай байна.

Цаашид Төвбанкны хараат бус бие даасан байдлыг олон улсын жишигт нийцүүлэн бэхжүүлэх, өөрийн хөрөнгийн дутагдлыг бүрэн шийдвэрлэж бодлогын орон зайгаа тэлэх, цаашлаад Монгол Улсын зээлжих зэрэглэлийг шат ахиулж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх суурь нөхцөл нь энэхүү хууль эрх зүйн реформ юм.

Иймд Монголбанкнаас боловсруулсан Төвбанкны хууль болон Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг энэ хаврын чуулганаар хэлэлцүүлэн батлахад хууль тогтоогч Та бүхний манлайлал, тууштай дэмжлэг, туйлаас чухал байгааг энд онцлон тэмдэглэе.

5.Цаг үеийн зорилт болон бодлогын чиглэл.

Цаашид гадаад орчинд геополитикийн зөрчил, хөрш орнуудын эдийн засгийн төлөв, түүхий эдийн үнийн савлагаа зэрэг тодорхой бус байдал өндөр байна.

Дотооддоо төсвийн тэлэлт, хэрэглээний зээлийн өсөлтөөс үүдэлтэй инфляцын дарамт дахин сэргэх эрсдэл бодитой байна.

Иймд Монголбанк дараах 5 чиглэлд бодлогоо төвлөрүүлнэ.

1.Инфляцын эсрэг арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, улмаар дунд хугацаанд зорилтот түвшинд бат бөх тогтворжуулах суурь нөхцөлийг бэхжүүлэх.

2.Валютын нөөцийн хүрэлцээг хадгалж хамгаалах.

3.Банкны активын чанар, эрсдэлийн удирдлагад хяналтыг чангатгаж тогтвортой байдлыг хангах.

4.Зээлийн хэт өсөлт, өрийн дарамтын эсрэг макро зохистой бодлогыг цаг тухайд нь ашиглаж хэрэгжүүлэх.

5.Бодлогын ил тод байдлыг хангаж, олон нийтийн хүлээлтийг зөв удирдах.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Эдийн засгийн сорилттой өнөөгийн орчинд тулгамдаж буй макро эрсдэлүүдийг дан ганц Төвбанкны бодлогын мөнгөний бодлогоор шийдвэрлэх боломжгүй юм.

Төсөв, мөнгө, санхүүгийн бодлогын харилцан уялдаа, сахилга бат, бүтцийн суурь реформыг хэрэгжүүлэхэд Эдийн засгийн байнгын хорооны гишүүд Та бүхнийг дэмжиж ажиллана гэдэгт үнэн итгэж байна.

Анхаарал хандуулсанд Баярлалаа.

Л.Соронзонболд: Монголбанкны Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг Хяналтын зөвлөлийн дарга Нинжбатын Ууганбаатар хийнэ.

Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нээе.

Н.Ууганбаатар: Эдийн засгийн байнгын хорооны дарга болон эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг нэлээн товчилсон байдлаар Та бүхэнд танилцуулъя.

Та бүхэнд бичгээр тараагдсан байгаа болов уу гэж бодож байна.

Өнгөрсөн оны Монголбанкны санхүүгийн тайланд бид санал, зөвлөмж бүхий дүгнэлт гаргаад санал, зөвлөмжийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд гэсэн 4 санал, зөвлөмж, Монголбанкны удирдлагад гэсэн 5 санал, зөвлөмж бүхий ийм дүгнэлт гаргасан байна.

➤ **Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд.**

1.Төв банк, Монголбанкны тухай хуулийн 38¹ заалтын хэрэгжилт буюу нийт өр төлбөр, нийт хөрөнгийн зөрүү болох 4.8 их наяд төгрөгийг Засгийн газар үнэт цаас гаргах замаар нөхөх асуудлыг шийдвэрлэх нөхцөл байдал 2012 оноос хойш үүссэнд анхаарах хэрэгтэй байна.

2.Төв банк, Монголбанк нь хуримтлагдсан алдагдалтай үед тухайн жилд ашигтай ажиллах буюу цэвэр орлого эерэг гарвал Төв банк, Монголбанкны тухай хуулийн 38.3 заалт үйлчлэх эсэх нь тодорхой бус байгаад анхаарч, шаардлагатай холбогдох заалтад өөрчлөлт оруулах эрхтэй байна.

3.Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоол, 2020 оны иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай зэрэг хууль, тогтоол, шийдвэрээр Монголбанканд санхүүгийн сөрөг эрсдэлтэй үр дагавар бүхий үүрэг чиглэл өгөх нь Монголбанкны санхүүгийн байдлыг муутгах, бие даасан, хараат бус байдлыг алдагдуулахад нөлөөлж буйд анхаарах шаардлагатай байна.

4.Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйл болон Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар Монголбанкны санхүүгийн тайлан, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хуралдаанаараа бусад харьяа байгууллагын үйл ажиллагааны тайланг хэлэлцдэг жишгээр хэлэлцэж байна.

Харин Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан, Монгол Улсын төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд зааснаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуралдаанаар хэлэлцэж байна.

Цаашид эдгээр санхүүгийн тайланг хэлэлцдэг жишгээр Монголбанкны санхүүгийн тайланг мөн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй эсэхийг хэлэлцэн шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэж байна.

Монголбанкны удирдлага.

- **1.**Засгийн газраас авах авлага нь Төв банканд санхүүгийн эрсдэл учруулж буй тул цаашид энэ төрлийн хэлцлийн нөхцөл, гэрээ болон эргэн төлөлт дээр эрсдэл, Төвбанкны алдагдал үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийж, захирлын зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж байх шаардлагатай байна.

Төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлэхээс эрс татгалзах хэрэгтэй байна.

- **2.**Хөндлөнгийн аудитын өөрчлөлтгүй дүгнэлтийг цаашид хэвээр хадгалахад онцгой анхаарах хэрэгтэй байна.
- **3.**Мөнгөний зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, Төвбанкны үнэт цаасыг борлуулах, Засгийн газрын богино хугацааны үнэт цаасыг мөнгөний зах зээлд нэвтрүүлэх замаар Төвбанкны үнэт цаасны хүүгийн зардлыг бууруулах, үргүй зардал гаргахгүй байх хэмнэлтийн горимыг чанд мөрдөх хэрэгтэй байна.
- **4.**Санхүүгийн тайланг олон нийтэд хүртээмжтэй байдлаар хэвлэмэл, дохионы хэл, видео, инфографик зэрэг олон хэлбэрээр гаргах чиглэлээр Чили, Перу, Малайз зэрэг бусад Төвбанкны сайн жишгийг нэвтрүүлэх хэрэгтэй байна.
- **5.**Хяналтын зөв зөвлөлийн 2025 оны 6 сарын 23-ны өдрийн 02 дугаар тогтоолоор өгсөн Монголбанкны жилийн тайлантай холбоотой зөвлөмжүүд бүрэн хэрэгжээгүй байгаад анхаарах хэрэгтэй байна. Баярлалаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

С.Наранцогт Монголбанкны Ерөнхийлөгч, Б.Батбаяр Санхүү, удирдлагын газрын захирал, Н.Ургамалсувд Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал, П.Мөнхбаяр Санхүүгийн зах зээл, валютын газрын захирал, Д.Баянзул Эрсдэлийн удирдлага, дотоод аудитын газрын захирал, Б.Амгалан Санхүүгийн тогтвортой байдлын газрын захирал, Л.Эвшинхорлоо Санхүүгийн тогтвортой

байдлын газрын Тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн захирал, С.Цэрэннадмид Монголбанкны ерөнхий менежер, Б.Эрдэнэхуяг Хуулийн газрын Эрх зүйн бодлого, судалгааны хэлтсийн захирал, Э.Жавхлан Санхүү, удирдлагын газрын Бодлого, төсөв, тайлагналын хэлтсийн захирал, Н.Батсайхан Стратеги төлөвлөлтийн албаны ахлах референт.

Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга Н.Ууганбаатар, Г.Эрдэнэбаяр Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүн, У.Хосжаргал Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүн, С.Лхагвадорж Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүн, Д.Энхжаргал Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүн.

Монголбанкны 2025 оны аудитлагдсан Санхүүгийн тайлан, Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмж болон Улсын Их Хурлын Тамгын газраас Монголбанкны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн дүн шинжилгээг Та бүхэнд тараасан байгаа.

Монголбанкны санхүүгийн тайлан болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. /алх цохив/

Б.Пунсалмаа гишүүнээр тасаллаа. /алх цохив/ Д.Үүрийнтуяа гишүүнийг нэмье.

Г.Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Та бүхэнд оройн мэнд хүргэе.

▷ **Нэгдүгээрт,** Хяналтын зөвлөлөөс гаргасан 2.1.4. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд өгч байгаа чуулганы нэгдсэн хуралдаанаар санхүүгийн тайланг хэлэлцье гэж байна. Тийм ээ.

Дэгийн тухай хууль дээр ажлын хэсэг гараад ажиллаад явж байгаа.

Та бүхний энэ өгсөн саналыг ажлын хэсэгт өгье гэж бодож байна.

Тэгээд нэгдсэн чуулганаар хэлэлцсэн нь зүйтэй гэж санал нэгдэж байна.

Өнгөрсөн жилийн 4 сарын 04, 7 сарын 01-нд Хяналтын зөвлөлөөс асууж байсан. Та бүхэн нэг томилогдож байх үед. Тийм ээ. Үр дүнд суурилсан байдлаар дунд хугацааны төлөвлөгөөг гаргана гэсэн. Жилийн хугацаа өнгөрлөө. Одоогийн байдлаар надад үр дүнд суурилсан дунд хугацааны төлөвлөгөөг ирүүлээгүй байна.

Та бүхнээс Эдийн засгийн байнгын хороонд ч юм уу, тийм төлөвлөгөө явуулсан зүйл байна уу, эсвэл боловсруулж дууссан уу? Энэ төлөвлөгөөгөө гэдэг эхний асуулт.

▷ **Хоёрдугаарт**, Монголбанкнаас асууя. Хэдүүлээ үр дүнгээ л ярилцаад явна. Таван жилийн үндсэн чиглэл дээр Та бүхний оруулсан оновчтой шалгуур үзүүлэлтүүд байгаа.

— **Нэгдүгээрт нь**, инфляцыг тогтвортой барина гэсэн. Тийм ээ. Эрэлтийн инфляцыг 5 хувьд хязгаарлана гэсэн. Сая та 2025 онд ямар түвшинд хүрч чадсан бэ гэдэг. Тийм ээ.

- 2024 онд 8.2 хувь байсан.
- 2026 онд 8 хувь болгож бууруулна –

-гэсэн зорилтыг Та бүхэнд тавьсан байсан.

2025 оны гүйцэтгэлээр хэдэн хувьтай байгаа вэ гэсэн эхний асуулт.

— **Хоёрдугаарт нь**, зах зээл дэх чанаргүй зээлийн эзлэх хувийг 2024 онд 5 хувь байсныг 2026 онд 4.9 хувь болгоно гэж байгаа. 2025 оны байдлаар 5.1 хувь гэж ойлголоо. Тийм ээ. Саяын таны танилцуулгаас.

— **Гуравдугаарт нь**, олон нийтийн санхүүгийн боловсролын чадамжийн түвшнийг дээшлүүлнэ гэсэн нэг зорилт байгаа. Та бүхэн дээр.

2022 онд 9.9 оноотой. 3 жил тутам дата цуглуулж энэ оноог гаргадаг юм байна. 2025 оны дата гарсан байх ёстой болов уу гэж бодож байна. Хэрвээ гарсан байвал хэдэн оноотой гарсан бэ?

Үүнийг сайжруулахын хүрээнд Монголбанкны зүгээс ямар үйл ажиллагаа хэрэгжүүлсэн бэ? Яг үнэнийг хэлэхэд инфляц, банкны зээлийн хүүгийн талаар эдгээр нь яаж тогтдог талаар олон нийтэд яг оновчтой мэдээлэл очихгүй байгаа гэж би хардаг.

Түүнээсээ үүдээд банкууд мөнгө хүүлээд сууж байдаг гэсэн тийм хандлага олон нийтээрээ тогтоод, хөгжлийн төлөвлөгөөн дээрээ хүртэл хүүг бууруулна гэсэн зорилтуудыг Засгийн газар нь оруулаад ирдэг. Ийм байдлаар байх юм бол Та бүхний хараат бус байдлыг бэхжүүлнэ гэдэг зүйл боломжгүй болов уу гэж бодож байна.

Уг нь Засгийн газраас өргөн барьж байгаа хөгжлийн төлөвлөгөөнд ийм агуулгатай зорилго тусаж болохгүй. Тийм ээ.

Тэгэхээр Та бүхний зүгээс эрэлтийн гаралтай инфляцыг 2027 онд төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулаад хэд түвшинд байлгахаар зорьж байгаа вэ гэсэн асуултууд байна.

Л.Соронзонболд: Б.Мөнхсоёл гишүүнийг асуух гишүүдийн жагсаалтад нэмье.

Саяын Г.Лувсанжамц гишүүний асууж байгаа Улсын Их Хуралд танилцуулах тухай асуудал бол Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 115.5 дээр энэ хуулийн 115.2.3, 115.2.15-д заасан илтгэл, тайланг холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдаанд заавал танилцуулах бөгөөд бусад тайлан, илтгэл, мэдээллийг холбогдох Байнгын хороо хэлэлцээд, шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаанд танилцуулж болно гэж заасан байгаа шүү.

Тэгэхээр хэрвээ Байнгын хорооны гишүүд горимын санал гаргаад танилцуулъя гэвэл үүнийг Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэх боломж байгаа гэж харж байна.

Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нээе.

Н.Ууганбаатар: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Бид үр дүнд суурилсан төлөвлөгөөгөө 3 жилээр боловсруулаад өнгөрсөн оны 9 сард Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн байгаа.

Сая дахиад төлөвлөгөөнийхөө гүйцэтгэлийг хэлэлцээд, тэгээд суурь үзүүлэлтүүд энэ тэрээ дахиж эргэж харах шаардлагатай болоод түүнд засвар оруулаад дахиад update хийсэн байгаа. Би танд явуулъя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

С.Наранцогт: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг дунд хугацааны зорилтоо Төв банкнаас Улсын Их Хурлаар 5 дээр нэмэх нь 2 хувийн ийм хязгаарт батлуулж байгаа.

Яг “эрэлтийн гаралтай инфляц” гэдэг ойлголтыг хөгжлийн төлөвлөгөөнд баталсан юм билээ.

Тэгэхээр албан ёсоор гарч байгаа энэ инфляцын дүн 2025 онд 7.5, сая 2 сард хамгийн доошоо буугаад 6.5 буюу манай зорилтот хэмжээнд орж ирсэн гэсэн үг.

Тэгээд буцаад энэ хүнсний үнийн өсөлтөөс болон 3 сарын инфляц 7.4 хувьтай болж буцаад өсөж байгаа.

Тэгэхээр таны хэлж байгаа инфляцыг үүсгэж байгаа эрэлтийн болон нийлүүлэлтийн шалтгаануудыг тодорхойлж байгаа.

Таны өөрийн сая дурдсан төсөв, мөнгөний бодлого, төсвийн зарцуулалт, Төв банкнаас явуулж байгаа мөнгөний бодлого хоёр уялдах юм бол дунд хугацаанд бид энэ дунд хугацааны тавьсан зорилтоо хэрэгжүүлэх боломжтой.

Ийм учраас бид яг Төвбанкны хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Их Хурлын ажлын хэсэгтэй хамтарч ажиллаж байгаа.

Энэ дээр бид суурь асуудлуудаа тодорхойлоод, энэ эрх зүйн өөрчлөлт хийгдсэн тохиолдолд бид дунд хугацаанд Төвбанкны зорилтыг тогтвортой хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр бид хуулийнхаа механизмуудыг тодорхой болгох юм бол энэ зорилтоо биелүүлээд ажиллаад явах бололцоотой.

Та чанаргүй зээлийн яг асуусан. 2026 оны 3 дугаар сарын байдлаар чанаргүй зээл системийн хэмжээнд 5.1 хувьтай байгаа. Энэ боломжийн сайн үзүүлэлт байгаа.

Энд нөлөөлж байгаа нэг зүйл бол хэрэглээний зээл, тэр дундаа цалингийн зээлийн чанаргүй байдал нэмэгдэж байгаа. Энэ нэмэгдэхэд нөлөөлж байгаа.

Санхүүгийн боловсролын чиглэлд, ялангуяа сая миний дурдсан хэрэглээний зээл, тэр дундаа цалингийн зээлийн чанаргүйдэлд их нэмэгдэж байгаатай уялдуулаад ер нь манай зээлийн бүтэц дотор хэрэглээний зээл нэлээн өндөр хувийг эзэлдэг.

Энэ нь системийн гажуудлын нэг. Үүнтэй холбогдуулаад ер нь олон нийтийн боловсролыг дээшлүүлэх чиглэл дээр бид дунд хугацааны стратеги дээр ч тодорхой зорилтуудыг тавьж нэлээн анхаарч ажиллах ийм хөтөлбөр боловсруулаад гаргаж байгаа.

Л.Соронзонболд: Г.Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Тэгвэл дэгийн тухай хуулийн 115.2-ын дагуу нэгдсэн чуулганаар санхүүгийн тайланг хэлэлцье гэсэн горимын санал гаргаж байна. Өнөөдөр саналаа хураах уу? Тийм ээ. Окэй.

Дараагийн Байнгын хороогоор санал хураая. Санал гаргаад санал хураая. Тийм ээ.

Тодорхой тоогоор хариулж байгаад Баярлалаа.

Төлөвлөгөөнүүд гаргаж хөтөлбөр боловсруулж байгаа юм байна. Тийм ээ. Ойлголоо. Өнөөдөр хэлэлцэх байсан Улсын Их Хурлын 57 дугаар тогтоолоор хэрэгжилтийн асуулга явуулсан байгаа. Тэгээд Агаарын бохирдолтой тэмцэх Үндэсний хорооны дарга байхгүйн улмаас ирэх долоо хоног болж хойшлуулсан. Энэ хүрээндээ ногоон зээлийн хүрээнд би олон асуултууд асууна гээд бэлдэж байгаа.

Тэгэхээр Та бүхэн маань ногоон зээлийн журам гэж шинээр гарч байгаа юу, үгүй юу. Энэ зохицуулалтууд дээр ямар зүйлүүд тусаж байгаа вэ. Байшин гэрийн

дулаалга буюу хэрэглээг хэмнэх бүтээгдэхүүнүүдэд ногоон зээл олгох эсэх талаар асуултууд тавих учраас Та бүхэн маань бэлтгэлтэй байгаарай гэж хүсэж байна.

Л.Соронзонболд: Санал хэллээ. Б.Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Засаглалтай холбоотой хэдэн асуулт асууя гэж бодлоо.

▷ **Нэгдүгээрт нь,** Ерөнхийлөгч дээр нэлээн их эрх мэдэл төвлөрсөн байгаа шүү дээ.

Тэгээд Төвбанкны тухай хууль нэмэлт, өөрчлөлт хийгдэхээр орж ирэх юм байна гэж ойлгосон. Тэр хуулийн төсөл дээр төлөөлөн удирдах зөвлөлтэй болно гээд. Ямар өөрчлөлтүүд орохоор яригдаж байгаа вэ гэдгийг асууя.

▷ **Хоёрдугаарт нь,** сая Ерөнхийлөгч өөрөө танилцуулгадаа хэлж байна. Төсөв мөнгөний бодлогын уялдаа холбоо гээд. Ер нь бид дандаа л хэлдэг, ярьдаг. Хатуу бодлого барих гэхээр төсөв тэлдэг. Зөрүүтэй болохоор ингэдэг, тэгдэг гээд.

Тэгэнгүүт “уялдаа холбоо” гэдэг дээр хэрхэн яаж энэ уялдаа холбоог хангана гэж харж байна. Засагтаа яана гэсэн үг вэ? Өөрсдөө тэндээ бодлогоо боловсруулаад байдаг. Тэгэхээр Засагтай Төв банк гэрээ хийж зарим тохиолдолд ажилладаг. Тэгээд веб руу нь орохоор дээр үед байгуулсан 3 гэрээ л ил тод байршсан байгаад байдаг.

Түүнээс хойш Засгийн газартай хийсэн хоорондын гэрээ байна уу? Ямар төрлийн, ямар гэрээ байна гэдгийг асууя.

Тэгээд нөгөө өрний асуудал байгаа шүү дээ. 7.5 билүү. Тэрбум төгрөг буураад 6 руу орсон гэж ойлгож байгаа. Тэрийг хэрхэн шийдвэрлэхээр байгаа вэ? Энэ асуултуудыг асууя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

С.Наранцогт: Б.Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Та суурь асуудал хөндөж байна.

Тэгэхээр ер нь энэ Төвбанкны болоод банкны салбарын реформыг хоёр үе шаттай хийх ийм төлөвлөгөөтэй байгаа.

Яагаад тэгж байна вэ гэхээр эхний ээлжид суурь асуудлыг ер нь бүгдээрээ ойлгож байгаа. Яг өнөөдрийн цаг үе, нөхцөл байдал дээр тулгамдаж байгаа суурь асуудлаа шийдье.

Яагаад энэ асуудлууд Төвбанкны болоод төсөв дээр, төсөв мөнгөний бодлогын уялдаан дээр олон жил хуримтлагдсан бэ гэхээр бид цаг үед дандаа аргалж явж ирсэн. Одоо ингээд сүүлдээ аргалах ч орон зайгүй болсон.

Тийм учраас үүнийг эхний ээлжид бүх гишүүдийн хувьд консенсус үүсэх бололцоотой. Их Хурлаас томилогдсон ажлын хэсэгтэй ажиллаад үзэхэд бидний гаргаж байгаа саналыг санал нэгдэхгүй байгаа тохиолдол бараг байхгүй байгаа.

Тийм учраас энэ асуудлыг эхний ээлжид энэ хаврын чуулганаараа шийдээд, дараа нь таны ярьж байгаачлан Төвбанкны засаглал дээр ярих асуудлууд байгаа.

Үүнийг Их Хурлын гишүүдийнхээ бас ажлын хэсэг гаргаад ер нь талууд зөвшилцөл нэлээн хэрэгтэй. Олон зүйл хамрах гээд байгаа.

Тэгэхээр хаврын чуулганд энэ олон зүйлүүдийг зөвшилцөлгүй оруулж ирэх юм бол батлахад хүндрэл үүсэх байх гэж үзсэн.

Тийм учраас намрын юм уу, чуулганд хоёр дахь ээлжийг оруулж ирэх ёстой. Банкны хууль тухай хууль дээр ч гэсэн бид яг тулгамдсан асуудлаа шийдээд дараа нь цогцоор нь нэмэлт, өөрчлөлт биш шинэчилсэн найруулга болгож оруулж ирэх нь зүйтэй юм байна. Одоо оруулж ирж байгаа өөрчлөлтүүд нэмэлт, өөрчлөлт байж байгаа.

Хоёрдугаар асуудал бол яг үүнтэйгээ, саяын ярьсан зүйлтэй уялдана. Төсөв, мөнгөний бодлого гээд.

Тэгэхээр Улсын Их Хуралд мөнгөний бодлогоо ч баталдаг, төсвийн бодлогоо ч баталдаг ийм онцгой эрх байгаа.

Тэгээд хамгийн гол нь үүнийг төсөв дээрээ л нэлээн анхааралтай ажилладаг. Төсвийн бодлого дээр яг төсөв хэлэлцдэг шиг тийм нарийн хэлэлцүүлэг юм хийдэггүй явж ирсэн.

Тэгэхээр бид Төвбанкны тухай хууль, дагалдаад Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, бусад төсвийн тодорхой хуулиудад өөрчлөлт орохоос өөр аргагүй байгаа.

Тэгэхээр үүгээр юу шийдье гэж байгаа вэ гэхээр Их Хурал дээр хаврын чуулганаараа ирэх жилийн төсөв, инфляцын төсөөлөл, энэ нөхцөл байдал, төсөөллөө бүгдийг нь төсөв хэлэлцэж байгаа юм шиг хэлэлцээд мөнгөний бодлогын үндсэн чиглэл батлахдаа ирэх жилийнхээ төсвийн нийт зардал юмаа хамтад нь баталдаг ийм механизмыг бий болгоё гэдэг саналыг хуулийн өөрчлөлтөөр оруулж ирж байгаа юм.

Өөрөөр хэлбэл төсөв, мөнгөний бодлогыг яг бодитой, тодорхой уялдуулахгүй, уялдах ёстой гэж яриад, төсөв, мөнгөний бодлогын үндсэн

чиглэлийг нэг тоо тэгсхийгээд батлаад, төсвөөрөө түүнтэйгээ уялдаагүй баталдгаас болоод өнөөдрийн асуудлуудын нэлээд хувийг энэ зүйл эзэлж байгаа юм.

Тэгээд үүнтэй үүдээд манай макро эдийн засгийн суурь бүтэцтэй ч холбоотой. Таны хэлж байгаа бодлогын зардал, Төвбанкны төсвийн шинжтэй үйл ажиллагаанууд, ийм олон зүйл нийлээд Төвбанкны хуримтлагдсан алдагдал 6.8 их наядад хүрсэн. Цаашдаа ч суурь гажуудлыг засахгүй тасралтгүй нэмэгдэх ийм төсөөлөл, тооцоолол гарч ирж байгаа.

Тийм учраас өнөөдөр хууль дээр байгаа юм. Улсын Их Хурал Төв банк алдагдал хүлээвэл үүнийг Засгийн газраас үнэт цаас гаргах журмаар шийдвэрлэнэ гэсэн зохицуулалт байгаа боловч яг яаж зохицуулах вэ гэдэг механизм нь өөрөө байдаггүй. Байхгүй учраас мөн энэ асуудал хуримтлагдаад өнөөдөр хүрээд ирсэн.

Тэгэхээр үүнийг яг олон улсын сайн зарчмын дагуу шийдвэрлэх... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номерыг гүйцээж хариулъя.

С.Наранцогт: Тэгэхээр мөн ялгаагүй сая төсөв, мөнгөний бодлогыг уялдуулах хуулийн механизмыг тодорхой зааж байгаа шиг Төвбанкны алдагдлыг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг механизмыг нь дунд хугацаанд мэдээж шийдвэрлэнэ.

Үүний тооцоолол, бүх механизмуудыг нь Төв банканд дээр хөрөнгийн дутагдал үүсэх тохиолдолд ямар шийдэл гаргах вэ, ямар процедураар энэ асуудлыг шийдэж явах вэ гэдэг зүйлийг бас хуулийнхаа өөрчлөлт дээр тодорхой оруулаад ирсэн байгаа.

Тэгэхээр ийм байдлаар суурь асуудлуудаа шийдвэрлэж байж бид цаашдаа ахиж ийм асуудлуудыг үүсгэхгүй. Инфляц тогтвортой, нам түвшинд явах энэ суурь нөхцөл бүрдэнэ гэж үзэж байгаа юм.

Л.Соронзонболд: Монголбанкны өрийг яаж шийдэх гэж байгаа вэ? Засгийн газартай нэмж гэрээ хийсэн үү гэдэг асуултууд асуусан шүү дээ. Түүнд хариулъя.

Ажлын хэсгийн 5 номер.

С.Наранцогт: Тэр төсөв, мөнгөний бодлогын уялдааг гэрээ биш яг хуулиар зохицуулж өгөх гэж байгаа. Хуулийн шийдлийг нь гаргаж өгч байгаа.

Бид дахиж нэмж гэрээ байгуулаагүй. Алдагдлыг бас энэ хуулийн механизмаар тодорхой болгож өгч байгаа учраас алдагдлыг Засгийн газрын тусгай үнэт цаасаар солих, яг олон улсын сайн шийдлүүдийг харьцуулаад тодорхой шийдлүүдийг гаргасан байгаа.

Үүнийг хууль өргөн баригдахаар Их Хурал дээр дэлгэрэнгүй хэлэлцэгдээд явна гэж ойлгож болно.

Л.Соронзонболд: Монголбанкны өрийг асуугаад байгаа шүү дээ. Монголбанкны өр яаж шийдэж байгаа юм бэ?

С.Наранцогт: Хуримтлагдсан алдагдал нь 6.8 их наяд гээд би хэлсэн. Өөрийн хөрөнгийн дутагдал нь 4.8 их наяд байгаа.

Л.Соронзонболд: С.Наранцогт Ерөнхийлөгч Монголбанкны өр байгаа шүү дээ.

Монголбанкны өрийг яаж шийдэх гэж байгаа вэ гэж Б.Мөнхсоёл гишүүн асуугаад байна шүү дээ. Алдагдлыг ярьсан юм уу?

Б.Мөнхсоёл гишүүн тодруулъя.

Б.Мөнхсоёл: Тийм. Засгийн газрын гэрээ дахиж хийгээгүй гэж ойлголоо. Тийм ээ. Тэр дээр үеийнхээс хойш байхгүй. Гэрээгүй учраас. Түүнээс ил тод бус байгаадаа биш юм байна гэж ойлголоо.

Түрүүн би бас тэрбум гээд буруу хэлсэн шүү. Их наяд. Тэгээд буурсан ч гэсэн 6.8 их наяд чинь өндөр. Тэр төлөвлөгөөг нарийн шаардах хэрэгтэй. Ямар ч байсан өнөөдөр хариулт авлаа гэж үзье.

Тийм. Итгэхгүй байгаа. Ямар ч байсан чуулган дээр ч дахиж асуугдаж магадгүй. Илүү дэлгэрэнгүй хариулт бэлдээрэй. Тийм ээ. Баярлалаа.

Л.Соронзонболд: Б.Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Баярлалаа. Монголбанкнаас нэг асуулт байна.

Монголбанк иргэдэд олгож байгаа ипотекийнхээ зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, сан, эх үүсвэрийг нэмэгдүүлэх бололцоо байна уу?

Өнөөдөр залуучууд ипотекийн байранд орох гээд урьдчилгаагаа бэлдээд 2, 3 жил хүлээж байгаа байхгүй юу. Тэр хооронд нь нөгөө байрны квадратын үнэ өсөөд, ингээд байранд орох энэ бодол нь алсрах ийм эрсдэл байгаад байна.

Тийм болохоор Монголбанкны зүгээс арилжааны банкуудад ипотекийн зээлийн хэмжээг өсгөх бодлогыг хэрэгжүүлэх ийм алхмуудыг Та бүхэн юу гэж харж байгаа?

Яагаад гэхээр Төвбанкны үнэт цаас хэлбэрээр арилжааны банкуудаас татан төвлөрүүлсэн 10 орчим их наяд төгрөг байгаа. Энэ эх үүсвэрийг ипотекийн

зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд зориулах боломж байна уу гэж асуух гэж байгаа юм.

Хоёрдугаарт нь, дэлхийн зах зээл дээрх алтны үнэ ханш өсөөд байгаа юм.

Манай Монгол Улс жилдээ 20 орчим тонн алт олборлож байгаа. Олборлож байгаа энэ алтныхаа нөөцийг бүгдийг нь Монголбанкандаа тушааж чадаж байна уу?

Яагаад гэхээр бусад улс орнууд валютынхаа нөөцийг алтаар баталгаажсан ийм хэлбэрт оруулаад байгаа. Валютын ханш унаад байх ийм асуудал байна. Нөгөө тал нь алтны үнэ ханш өсөөд байгаа учраас энэ алтаар баталгаажсан валютын нөөц гэдэг ийм арга хэрэгсэл хэрэглэж байгаа. Энэ тал дээр Монголбанк ямар бодолтой байгаа юм?

Монголд өнөөдөр алт тушаалтны хэмжээ буураад байгаа нь би харахдаа энэ рояалти хэмжээ нь өндөр байна. Үүнийг буулгах ийм арга механизмаар Монголд олборлож байгаа энэ хэмжээ бүгдээрээ Монголбанкандаа тушаагдах ийм бололцоотой юм болов уу гэж харж байгаа.

Тэгээд энэ тал дээр түрүү жил бид авч хэрэгжүүлсэн ямар арга хэмжээ байна. Энэ жил юу зорьж байна гэдгийг асууя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

С.Наранцогт: Ипотекийн 6 хувийн хөнгөлөлттэй хөтөлбөр хэрэгжээд явж байгаа.

Өнөөдөр үүний дараалал, очер гэж нэлээд нэмэгдсэн байгаа. Яагаад тэгж байна вэ гэхээр энэ өөрөө зах зээлийн зарчмаас жоохон гажууд явж байгаа.

Эхний ээлжид Төв банк мөнгө хэвлэж энэ хөтөлбөрийг санхүүжүүлж явсан. Дараа нь Баялгийн сангийн хууль батлагдсанаар 2024 оноос хуримтлалын сангийн эх үүсвэр энэ хөтөлбөр лүү орж ирсэн учраас хөтөлбөр хэмжээ нь нэмэгдсэн.

Энэ жил буцаад Баялгийн сангийн Засгийн газрын хөрөнгийн удирдлагын бодлого Хөдөлмөр, нийгмийн яамнаас барьж байгаа бодлогын хүрээнд буцаагаад энэ санхүүжилтийн хэмжээ буухаар байгаа.

Тэгэхээр Төвбанкны бие даасан байдал хагас төсвийн үйл ажиллагааг явуулахгүй гэдэг бодлогын хүрээнд Төв банкнаас нэмж ипотек руу эх үүсвэр гаргах боломжгүй.

Ер нь ганцхан эх үүсвэр нь юу вэ гэхээр эргэн төлөлтийн 500 орчим тэрбум төгрөг орж байгаа. Үүнийгээ үргэлжлүүлээд явна гэсэн ийм бодлоготой байгаа.

Нөгөө талдаа Засгийн газартай хамтраад Орон сууцжилтын банкны тухай хуулийн төсөл дээр манайхаас хүмүүс орж ажилласан. Энэ бол энэ зах зээлийг либералчлах, зах зээлийн зарчимд нь шилжүүлэх гэсэн ийм эхний концепц явж байгаа.

Тэгэхээр бид цаашид Төв банкн дээр энэ суурь асуудлуудаа шийдээд, урт хугацаат эх үүсвэрийг бий болгох тэр суурь нөхцөлийг бий болгох, тэрийг урамшуулах чиглэлийн бодлого барихаас биш өөрсдөө эх үүсвэр гаргаж ингэж хийх бололцоо байхгүй. Ийм бодлоготой байгаа.

Алтны хувьд таны хэлсэн бидний боломжтой валютын нөөцөө нэмэгдүүлэх дотоод боломж.

Тийм учраас бид алт дээр онцгой анхаарал тавьж байгаа.

Ашигт малтмалын хуулийн өөрчлөлт дээр таны ярьж байгаа АМНАТ болон бусад саналыг хүргүүлсэн байгаа.

Дээр нь байгальд ээлтэй алт олборлолтыг нэмэгдүүлэх. Үүнийг Төв банканд төвлөрүүлэх чиглэлээр алт олборлох аж ахуйн нэгж болоод хууль бус алт гаргаж байгаа гэсэн зүйлтэй хууль хяналтын байгууллагатай Төв банк хамтарч ажиллаж байгаа.

Энэ жилийн хувьд дунд хугацааны стратеги төлөвлөгөөндөө ч гэсэн алт тушаалтыг нэмэгдүүлэх чиглэл дээр тодорхой бид бодлого, хөтөлбөр гаргаж ажиллаж байгаа.

Ер нь Монгол Улсын хэмжээнд 20 гаруй тонн алт. Дунджаар таны хэлсэн 20 тонн алт олборлогддог. Тэгэхдээ энэ олборлолт бууж байгаа. 2025 онд 16.2 тонн алт Монголбанканд тушаагдсан.

Тэгэхээр энэ алт тушаалтыг бид нэмэгдүүлэх чиглэл дээр онцгой анхаарч ажиллаж байгаа.

Л.Соронзонболд: Б.Пунсалмаа гишүүн тодруулъя.

Б.Пунсалмаа: Тэгэхээр Монголын Ипотекийн Корпорацын гаргасан давуу эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан бонд гээд 2013 онд ийм бонд гаргаж байсан юм байна л даа.

Тэгэхээр энэ хүрээнд л би одоо энэ МИК-ийн энэ гаргасан давуу эрхтэй бонд шиг ийм бонд гаргах бололцоо байна уу? Энэ бондыг би өөрөө эх үүсвэрийг нь эрэлхийлэхдээ богино хугацаат үнэт цаас хэлбэрээсээ гаргах бололцоо байгаа юм уу гэж асуугаад байгаа байхгүй юу.

Яагаад гэхээр тийм их хэмжээний хөрөнгө арилжааны банкуудаас татан төвлөрүүлчхээд. Тэр чинь зүгээр Монголбанкандаа байж байж болохгүй л харагдаад байна л даа.

Эргээд энэ чинь барилгажилт, агаарын бохирдлыг бууруулах, орон сууцжуулах, залуу гэр бүлүүдийг дэмжих маш чухал бодлого харагдаад байгаа юм.

Тэгээд энэ дээр ийм боломж, гарц байгаа юм уу? Өмнө нь бонд гаргаж байсан юм байна гээд ингэж хэлээд байгаа юм.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

С.Наранцогт: Таны хэлж байгаа 3.8 их наядын ипотекеэр баталгаажсан үнэт цаасыг Монголбанк эзэмшиж байгаа. Манай баланс дээр явж байгаа.

Үүнийг гаргана гэхээр зах зээл рүү гаргахаар зах зээлд худалдан авагч хэрэгтэй. Зах зээлийн зарчмаар гарна. 2 хувийн өгөөжтэй энэ бондыг зах зээл дээр хэн ч авах боломжгүй ийм бонд байгаа.

Яагаад гэвэл энэ нь зах зээлийн биш зарчмаар Монголбанк өөрөө мөнгө хэвлэж санхүүжүүлж бий болгосон бонд учраас зах зээл рүү гарах боломжгүй юм.

Л.Соронзонболд: Б.Пунсалмаа гишүүн нэмж тодруулъя.

Б.Пунсалмаа: Харин ч зах зээлийн хувьд эрэлт ихтэй байна гэж харж байгаа байхгүй юу. Залуучууд ипотекийн зээл хүлээж байгаа шүү дээ.

Тэгээд өмнө нь гарч байсан энэ бонд чинь 2.5-аас 4.5 хувийн хүүтэй байсан байна.

Тэгэхээр энэ бонд гаргах тал дээр ажиллавал зүгээр байна л гээд хэлээд байгаа юм. Энэ тал дээр л асуух гэж байгаа юм.

Л.Соронзонболд: Санал хэллээ. С.Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Манай арилжааны банкуудын актив эзэмшиж байгаа гадаадын иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын хувь хэд байдаг юм бэ? Гаднын банк оруулж ирнэ гээд аргаа бараад л ярьж байгаа.

Энэ юутай холбоотой вэ гэхээр хүү өсөхгүй байна. Банкууд олигополь зах зээл гэж хэлж болохоор байна.

Сая Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэл дээр зээлийн хүү дунджаар 17.6 хувь гэж танилцуулагдсан. Үндсэндээ түрүү жилийнхээс өссөн байна гэж зүйл гарч ирээд байгаа.

Тэгэхэд Монгол Улсын зээлжих зэрэглэл сайжирсан. Уг нь үүгээр хүү буурах ёстой. Гадаадын хямд эх үүсвэрүүд орж ирэх бололцоотой гэдэг ийм зүйлийг хүлээж байгаа.

Тэгэхээр ойрд хүү буурах юу байна уу? Мэдээж гадаад, дотоод зах зээлийн эрсдэлүүд өндөр байж байгаа.

Дээрээс нь иргэд 17.6 хувь гэхээр. Ахмадууд чинь 17 хувийн хүүгээр бараг зээл авч байгаа. Үндсэндээ арилжааны банкуудын дундаж хүүгээр нийгмийн хамгийн эмзэг болсон бүлэг чинь хүртэл ингээд зээл авч байгаа.

Зээлийн чанаргүйдэл 5 хувь гэж байх шиг байна. Хөгжлийн банк өчигдөр нэг мэдээлэл гарч байсан. 50 хувь нь чанаргүй гэсэн юм ярьж байна лээ.

Тэгэхээр хамгийн хөнгөлөлттэй бөгөөд хямд эх үүсвэрт бага хүүтэй энэ юунууд чинь чанаргүйдээд байдаг гол шалтгаан нь юу юм бэ? Энэ засаглалтай холбоотой юм уу?

Арилжааны банкууд дээр байж байгаа нийт хадгаламжийн чинь 44 орчим хувь нь нийт хадгаламж эзэмшиж байгаа сая 200 хүнээс 5 мянган хүний л гарт байгаа юм байна лээ шүү дээ.

Тэгэхээр ингээд аваад үзэхээр энэ чинь яг санхүүгийн хувьд эрүүл үзэгдэл мөн үү? Үндсэндээ Монгол Улс чинь мөнгө хүүлэлтийн цөөхөн хүнд байгаа мөнгийг хүүлээд байдаг. Аж ахуйн нэгж, байгууллага нь ажиллаад байдаг. Зөвхөн л хүү төлөх л. Бараг ашиг гэж байхааргүй. Тэгээд энэ жижиг, дунд үйлддвэрлэлүүд нь өөдтэй өсөхгүй байна гэдэг л нэг ийм дүр зураг харагдаад байна л даа.

Тэгэхээр үүнээс гарах арга чарга ер нь юу байна вэ гэдгийг хэлмээр байна.

Тэгээд хууль дээр асуудал байна. Ойрын хугацаанд Монголбанкнаас нөгөө хуульд өөрчлөлт оруулах юмнууд байна уу? Яг ингээд засаглалын ч гэдэг юм уу юмыг нь харахаар ер нь нэг санхүүгийн хэрэглэгч нар буюу зээл авагч нарын эрх ашгийг хамгаалж байгаа тийм субъект энэ Монголбанкны засаглал дотор миний хувьд байдаггүй юм шиг харагдаад байдаг юм. Яах вэ би зүгээр юу харахад. Тэр бодлогын хүүг харахад 12 хувь хэвээрээ л байгаад байна.

Ингээд инфляц тодорхой хэмжээгээр буулгана гэсэн байдаггүй. Хоёр оронтой тоонд байж байхад л 12 хувьтай байсан. Одоо инфляц чинь түрүү жил 6, 7 хувь руу байсан. Дахиад бодлогын хүү буурах юм байх гэсэн чинь хэвээр нь үлдээгээд байдаг.

Тийм учраас би энэ бодлогын хүү буурахгүй байгаа нэг шалтгаан нь цаанаа нь мөнгө хүүлэгчдийн сонирхол байдаг юм уу гэдгийг зүгээр хардаж хэлж байгаа юм. Байлгахгүй байх.

Моргейжийн зээл гээд түрүүн ярилаа. Дараа нь тодруулъя даа. Эхлээд хариултаа авчихъя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

С.Наранцогт: Тийм. Манайх шиг ийм эдийн засгийн бүтэцтэй орны л бидний яг бодит байдал дээр тулгарч байгаа л **dilemma**_[хэцүү сонголт] л даа.

Бодлогын хүү яг зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, эх үүсвэрийн зах зээлийн нөхцөл байдлаасаа болоод инфляцынхаа түвшинтэй уялдаад ингээд өндөр тогтож байгаа.

Энэ авч хэрэгжүүлдэг Төвбанкны цөөхөн бодлогын хэрэгслийн л үндэс хэрэгсэл л дээ.

Тэгэхээр ингээд энэ нөхцөлтэйгөө уялдуулаад бодлогын хүү өндөр явахаар нөгөө талдаа бизнес эрхлэгч нарт хүндрэл үүсэж байгаа. Үүнийг бид харж байгаа.

Гэхдээ буцаагаад энэ бодлогын хүүг сулруулах юм бол инфляц нь нэмэгдээд бүр илүү хүндрэлүүд бий болох юм. Дагалдаад. Долларжилт явагдахаас авхуулаад, хөрөнгийн эх үүсвэр гадагшлах гээд олон төрлийн дагалдах нөхцөл байгаа учраас бодлогын хүү өндөр тогтож байхаас өөр аргагүй.

Дээр нь нэмээд өнөөдрийн геополитикийн нөхцөл байдал нь дэлхий даяар бүх Төв банкуудын хувьд бодлогын хүүг хэвээр нь хадгалах ийм гадаад нөхцөл байдлыг бий болгож байгаа.

Ер нь явж явж энэ юу руу очих вэ гэхээр эцсийн дүндээ бидний яриад байгаа суурь асуудлууд шийдээд бид энэ инфляцын түвшин нам доор Төвбанкны зорилт руу тогтвортой орсон тохиолдолд яг энэ дээр үүнийг үүсгэж байгаа суурь асуудал төсөв, мөнгөний бодлого, эдийн засгийн суурь бүтэц сайжрах, тодорхой зах зээлүүд хөгжих ийм нөхцөлүүд үүсэж байж энэ хүү дагаад буух учиртай. Зах зээлийнхээ зарчмаар.

Гол асуудал юу байна вэ гэхээр бид эх үүсвэрийн тооцоонуудыг анализ шинжилгээ хийж л байгаа юм.

Хүүгийн зардал дээр юу юу хэдэн хувь нөлөөлж байна? Гол зардал эх үүсвэрийн зардал. 66 хувьтай байгаа. Тэгээд манайх бол хуримтлал тийм хангалттай биш. Таны хэлж байгаа хэдийгээр том хадгаламж эзэмшигч байдаг ч гэсэн манай системийн үзүүлэлтийг харах юм бол нийт пассивын 20 хувь гадаад эх үүсвэр.

Өөрөөр хэлбэл бид гадаад эх үүсвэр манай банкууд оруулж ирж байгаа.

Ялангуяа ноднин жилийн хувьд энэ үзүүлэлт нэлээдгүй хэмжээгээр нэмэгдэж байгаа.

Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр манай дотоодын хадгаламжийн эх үүсвэр зээлийн хэрэгцээнд хүрэлцэхгүй байгаа учраас гадаад эх үүсвэр татаж байгаа гэсэн үг. Гадаад эх үүсвэр өөрөө зардалтай байгаа.

Тэгэхээр бидний ер нь зүгээр үндсэн шийдэл бол суурь шийдлүүдээ хийж дунд хугацаандаа энэ жилийн хувьд яг тухайлсан гадаад нөхцөл байдлаас хамаараад бид бодлогын хүү болоод зээлийн хүү буух боломж байхгүй. Харин үүнийг өсгөхгүй, савлахгүй байх энэ бодлогыг барьж ажиллана.

Дунд хугацаандаа бид суурь шийдлүүдээ, төсөв, мөнгөний бодлогоо, бусад хамаарах асуудлуудаа шийдсэний үндсэн дээр дунд хугацаандаа бид энэ Төвбанкны зорилтот түвшинд инфляцыг тогтвортой оруулж байж энэ зээлийн хүү буурна.

Дээр нь нэмээд Та бас гадаад банкны тухай ярьсан. Манай дээр зээлийн бүтэц дээр аваад үзэхээр хугацааны зөрүү үүсэж байгаа.

Өөрөөр хэлбэл богино хугацааны эх үүсвэр татаад, түүнээсээ урт хугацаатай зээл олгох үзэгдэл гарч ирж байгаа.

Үүнийг Төв банк зохицуулалтынхаа хүрээнд тодорхой арга хэмжээнүүдийг авсан. Өнгөрсөн сарын Мөнгөний бодлогын хорооны ээлжит хурал дээр бид энэ бодлогын сигналаа зах зээлд өгсөн байгаа. Банкуудад. Тэгээд ийм байдлаар бид тухай бүрд нь арга хэмжээгээ авч хэрэгжүүлээд явах юм.

Л.Соронзонболд: С.Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Би нөгөө чанаргүй зээлийн юуг асуусан. Иргэдийн зээлийн эргэн төлөлт аягүй өндөр хувьтай байгаад байдаг. Зарим манай төрийн оролцсон гэдэг юм уу энэ банкуудын чинь чанар аягүй муу байгаад байдаг.

Нөгөө талд нь иргэдийн зээлийг нэлээн багасгасан. Гэтэл энэ орон зай хаашаа очсон бэ гэхээр банк бус санхүүгийн байгууллагууд сарын 4 хувийн хүүтэй, жилдээ 50, 60 хувийн хүүтэй юу руу шилжиж байгаа.

Энэ өөрөө иргэдийн санхүүгийн зардлыг өсгөөд, амьжиргаанд нь сөрөг нөлөө үзүүлээд, ядуурал руу оруулаад ингээд байгаа юм.

Одоо миний яриад байдаг түрүү жилжингээ ярьсан ахмадын зээлийн асуудал гээд овоо нэг тийшээ шийдэгдлээ гэсэн. “Батлан даагч” гэдэг нэг юм гаргаж ирээд тэгээд бас нэг асуудал болсон.

Өөрөөр хэлбэл чиний батлан даагч чинь заавал үр хүүхэд, төрөл садан байх ёстой. Тэр нь өмнө нь зээлгүй байх ёстой. Зээл авсан ч гэсэн тэрийгээ хугацаанд нь төлдөг байх ёстой гээд хүндрэлийг иргэд рүү аваачаад байна.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

С.Наранцогт: С.Эрдэнэбат гишүүнд тодруулж нэмж хариулъя.

Тэгэхээр ер нь бидний Төв банкнаас барьж байгаа бодлого импортыг өдөөж байгаа хэрэглээний зээлийг багасгах, аль болох бизнесийн зээлийг дэмжих ийм бодлогын хөшүүргүүд хэрэглэж байгаа.

Нэг сард ээлжит бусаар хуралдуулсан Мөнгөний бодлогын хорооны хурлын шийдвэр энэ рүү чиглэж гарсан. Тодорхой үр дүн гарсан.

Өнөөдрийн байдлаар хэрэглээний зээлийн өсөлт 9 хувь болсон. Энэ нь өнгөрсөн жилтэй харьцуулахад 2-оос 2 гаруй дахин буурсан гэсэн үг.

Тэгэхээр нөгөө талдаа би түрүүн танд хэлсэн. Хэрэглээний зээл, тэр дундаа цалингийн зээлийн чанаргүйдэх түвшин нэмэгдэж байгаа.

Л.Соронзонболд: Хариултыг гүйцээе. 5 ном номерын микрофоныг нээе.

С.Наранцогт: Дээр нь бид иргэдийнхээ санхүүгийн боловсрол, өрхийн өрийн дарамтын талаар тодорхой анхаарах шаардлагатай гэж яриад байгаагийн цаана юу байна вэ гэхээр хэдийгээр Төв банкнаас бодлогын хөшүүргийг хэрэглээд хэрэглээний зээл өнгөрсөн жилүүдтэй харьцуулахад буугаад, бизнесийн зээл өсөж байгаа ийм сайн үзүүлэлт гарч байгаа ч гэсэн яг зээлийн багцад багцаар нь авч үзэх юм бол иргэдийн зээлийн хэмжээ өндөр хэвээрээ байгаа юм. Тийм.

Тэгэхээр зэрэг өөрөөр хэлбэл энэ өндөр хүүтэй байсан ч гэсэн иргэд маань илүү хэмжээний зээлд ороод, өрийн дарамтад ороод эрсдэл давхар бий болоод байна л гэсэн үг.

Л.Соронзонболд: Д.Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Та бүхэнд оройн мэнд хүргэе.

Надад Монголбанкнаас хоёр асуулт, Хяналтын зөвлөлөөс нэг асуулт байна.

Хяналтын зөвлөлөөс эхлээд асуучихъя.

Та бүхний гаргасан санал, зөвлөмж дээр Улсын Их Хурал, Эдийн засгийн байнгын хороонд хандаж гаргасан санал, зөвлөмж дээр 2.1.2 дээр байна л даа.

Монголбанкны тухай хуулийн 38.3 дахь хэсгийн үйлчлэх эсэх нь тодорхой бус байгаад анхаарах гээд. Тэгээд энэ хуулийн заалт яагаад үйлчлэх эсэх нь тодорхой бус байгаа гэж дүгнэж байгаа үндэслэлээ нэг тодорхой болгож өгөөч.

Өөрөө энэ тавиад тодорхой бус байнагээд байгаа нь өөрөө аягүй тийм тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгээд байгаа юм. Яг ямар зүйлийг хүсэж байгаа юм гэдэг.

Монголбанкны хувьд энэ ирүүлж байгаа санал, зөвлөмж, Хяналтын зөвлөлөөс ирүүлж байгаа санал, зөвлөмж 4 асуудал хөндсөн. Энэ 4 асуудлын эхний хоёр асуудал дээр ямар байр суурьтай байгаа юм бэ?

Өөрөөр хэлбэл Төвбанкны тухай хуулийн 38¹ дүгээр зүйлийн хэрэгжилт дээр асуудал хөндсөн байгаа. 2012 оноос хойш энэ болохгүй байна аа л гэж дүгнэх гээд байна гэж ойлгоод байгаа шүү дээ.

Мөн 38.3 дахь үйлчлэх хэсэг нь тодорхойгүй байгааг өөрчил гээд байгаа юм. Яаж өөрчлүүлэх гээд байгаа нь тодорхой бус.

Тэгээд энэ хоёр асуудал дээр Монголбанкны зүгээс ер нь юу гэж харж хандаж байгаа юм? Монголбанкны зүгээс энэ эрх зүйн зохицуулалт дээр ер нь анхаарах шаардлагатай асуудлууд дээр Хяналтын зөвлөлийн байр суурьтай санал нэг байна уу, үгүй юу? Үүнийг тодорхой болгоё.

Монголбанкны тайлан дээр мөнгөн хөрөнгөд гарсан өөрчлөлтийн хувьд дотоодын банкуудад олгосон зээлийн хэмжээ 4 хувь буурсан юм байна.

Яах вэ, мөнгөний бодлогоо жоохон чангаруулсны л нөлөө байх л гэж бодож байна л даа.

Тэгээд энэ бодлогын арга хэмжээ арилжааны банкуудын зээлийн хүүгийн өсөлтөд яаж нөлөөлөв? Үр дүнгийн нөлөөллийг асууж байгаа юм.

- Зээлийн хүүгийн өсөлтөд яаж нөлөөлөв?
- Дотоодын нийт бүтээгдэхүүнд ямар нөлөө гаргасан бэ?

- Банкуудын нөөц резервт яаж нөлөөлсөн бэ?
- Энэ дээр хийсэн судалгаа байгаа юу?

Эдгээр асуултад хариулт авъя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 2 номер.

Н.Ууганбаатар: Хяналтын зөвлөл. Н.Ууганбаатар. Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя.

Төвбанкны тухай хуулийн 38 дугаар зүйл бол Төвбанкны ашиг алдагдалтай холбоотой хэсэг байгаа.

Төв банкны 38 ашгийг хуваарилах тухай асуудал бий. Ашгийг хуваарилахдаа ер нь –

- ♦ тухайн жилийн ашиг гэж юуг хэлэх вэ гэдэг нь –
— **38.1 дээр.**
- ♦ тухайн жилийн ашгаас хуваарилах ашгийг яаж тооцох вэ гэдэг нь –
— **38.2 дээр.**
- **38.3** нь тэр ашгийг цааш нь заалт ёсоор яах ёстой вэ гэхээр улсын төсөвт өгөх ёстой гэдэг ийм заалт байгаа.

Ашигтай ажиллаж байх үедээ өмнө нь улсын төсөвт өгч байсан түүх байдаг юм билээ.

Та бүхэн мэдэж байгаа байх. 10 гаруй жил ийм кэйс байхгүй.

Одоогийн үүсээд байгаа нөхцөл байдал, тухайлбал энэ жилийн хувьд харах юм бол 1 их наяд гаруй төгрөгийн жилийн ашигтай ажилласан. Үйл ажиллагааны ашиг 1 их наяд гаруй төгрөгтэй байгаа.

Гэхдээ өөрийн хөрөнгийн дутагдалтай, хуримтлагдсан алдагдалтай учраас нөгөө хуримтлагдсан алдагдлаасаа хасагдаад бичигдээд явж байгаа.

Гэтэл энэ заалтыг уншихаар Төвбанкны хууль ямар логиктой бичигдсэн байна вэ гэхээр өөрийн алдагдалтай ажигласан үе, өөрийн хөрөнгө дутагдсан үедээ үүнийг нь Улсын Их Хурал, Засгийн газраас бонд гаргах маягаар шийдвэрлэчихнэ.

Тэгээд ашигтай ажилласан үедээ үүнийгээ яах вэ гэхээр улсын төсөв рүү шилжүүлнэ гэсэн ийм логикоор бичигдсэн.

Гэтэл эхний кэйс нь алдагдчихаад байгаа. Алдагдалтай байгаа, энэ нь шийдэгдэхгүй байгаа. Тэгээд ийм тохиолдолд ашигтай ажилласан үед юу болох вэ гэдэг тодорхойгүй болжээ гэдэг зүйлийг хэлж байгаа юм.

Ер нь том дүнгээр нь харахаар бусад Төв банкуудыг, ялангуяа хөгжилтэй орнуудын Төв банкуудыг харахад улсын төсөв болон Төв банк хоёрын хоорондын шилжүүлэг нэг их тийм өргөн явагддаггүй юм билээ.

Тухайлбал, ашигтай ажилласан үед ашгийг нь хуваарилчхаад дараа нь дахиад алдагдалтай ажилласан тохиолдолд буцаагаад нөгөө бондоороо нөхөгдөх үү, бонд гаргалаа гээд тэр бонд маань буцаад эргэн төлөгдөх үү гээд.

Иймэрхүү аягүй олон асуудалтай байдаг учраас ерөнхийдөө хоорондоо нэг их шилжүүлэг хийдэггүй зохицуулалттай юм болов уу гэсэн би урьдчилсан байдлаар ийм судалгаа, дүгнэлт хийсэн байгаа. 38.3 дээр байгаа нөхцөл байдал ийм байна.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

С.Наранцогт: Яах вэ, хуулийн хэрэгжилтийг тодорхой биш байна гэдэг зүйл бичсэнийг Та асуусан гэж ойлголоо.

Тэгэхээр Төв банк алт дээр хөрөнгийн дутагдал үүсвэл Засгийн газрын бонд гаргаж үүнийг нөхнө гэсэн ийм ерөнхий заалтыг Улсын Их Хурал шийднэ гэсэн заалттай. Хэзээ ч хэрэгжүүлээгүй. Тэр нь эрх зүйн зохицуулалт нь яг яаж хэрэгжүүлэх юм гэсэн тодорхойгүй байгаагаас болж байгаа юм.

Тэгээд яах вэ, би төсөв дээр Сангийн яаманд ажилласан хүн туршлага дээр үндэслээд үүнийг ер нь яг яавал бодитой хэрэгжих вэ, ямар аргаар шийдэх вэ, төсөв дээр дарамт өгөхгүйгээр яаж шийдвэрлэж болох вэ гэдэг энэ шийдлийг хуулийн өөрчлөлтөөр маш тодорхой санал болгож байгаа юм.

Тэгэхээр бид Төвбанкны хууль дээр өөрөөр хэлбэл... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер гүйцээж хариулъя.

Ж.Золжаргал гишүүнийг асуулт асуухад нэмье.

С.Наранцогт: 5 жилийн хугацаанд мэдээж нэг доор бид нэг жилийн дотор 4 их наядын Засгийн газрын бондоос гаргаад явах нь хэрэгжүүлэх талаасаа ч тэр, агуулга талаасаа ч зохимжгүй учраас бид ер нь асуудлуудыг дунд хугацаандаа шийдье гээд таван жилийн хугацаанд энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх тооцооллууд бүгдээрээ хийгдсэн.

Хууль, эрх зүйн хувьд яг зохицуулалтын тодорхой хуулийн өөрчлөлтүүдээр тусгаж өгсөн байгаа.

Тэгээд үүнийг Их Хурлын ажлын хэсэгт эхний удаа танилцуулсан.

Тэгээд цаашид энэ хэлэлцүүлгийн хувьд би Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд, ялангуяа нэлээн дэлгэрэнгүй тооцоолол, хуулийнхаа төслийг танилцуулах нь зүйтэй гэж бодож байна.

Тэгэхээр энэ асуудал тодорхой болоод энэ хуулийн өөрчлөлт орох юм шийдэгдээд явчихна.

Мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг Та асуусан. Би яг нөгөө балансын алийг нь асууж байгааг яагаагүй учир... /минут дуусав/

Л.Соронзонболд: Д.Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Мөнгөн хөрөнгөд гарсан өөрчлөлтийг л хэлээд байна л даа.

Тэгээд энэ дээр би танай тайлан дээрээс энэ Хяналтын зөвлөлийн гаргасан дүгнэлт, тайлан дээр, мэдээлэл дотор ч байна л даа.

Дотоодын банкуудад олгосон зээл 2025 онд 4 нэгж хувиар буурчээ.

Тэгээд үүний нөлөөг хийсэн тооцоо байна уу л гээд байгаа юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд зээлийн арилжааны банкны зээлийн хүүд банкуудын резервт нөлөөлсөн үү?

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

С.Наранцогт: Би таны асуултыг ойлголоо.

Энэ манай дотоодын банкуудын зээл гэж юу бүртгэгдэж байгаа вэ гэхээр хөтөлбөр хэрэгжүүлээд урт хугацааны репо зээлийн тодорхой үлдэгдлүүд төлөгдөөд яваад байгаа. Тэр хэмжээгээр буурч байгаа болохоос биш Төвбанкны өөрийнх нь нөөц юм уу, ямар нэгэн манай мөнгөний бодлогын хэрэгслийн өөрчлөлт биш.

Тийм учраас мөнгөний бодлогын өөрчлөлт биш учраас зээлийн хүү болоод эдийн засгийн өсөлт, бусад юманд нөлөөлөх нөлөөллийн тооцоонд энэ орохгүй. Энэ зүгээр л хөтөлбөрийн авсан зээлээ буцааж төлж барагдуулж байгаа л хэлбэр гэсэн үг.

Л.Соронзонболд: Ж.Ганбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Ганбаатар: Монголбанкны Ерөнхийлөгч Байнгын хороонд үндэслэлтэй хандана шүү.

Гишүүнээр дамжуулж тайлан хойшлуулъя гэж ярих тийм юу байхгүй шүү дээ. Зарчим байхгүй.

Та өөрөө тайлангаа хойшлуулах гэж байгаа бол бичгээр Байнгын хороон даргад хандах ёстой. Өчнөөн олон жил төрд ажиллачхаад энэ зэргийн зүйл мэддэггүй юу.

Тэгээд гишүүдээр яриулаад л. Тэгээд зарчим зөрчөөд байж болохгүй шүү. Эрхэм Ерөнхийлөгч өө.

Танай алдагдлын хэмжээг би яг таны амнаас сонсмоор байна.

Үнэт цаасны үлдэгдлийн хэмжээ яг хэд байгаа юм бэ? Тэр заавал байлгах нөөцийн хэмжээ гэдэг нь хуулиараа байгаа юу, хуулиасаа гарсан байгаа юу? Энэ гурван асуулт асууя.

Манайх 2 минут асуугаад 1 минут тодруулдаг учраас би асуултаа өөрөө бараг тодруулах хэмжээнд хүрэх байх.

Тэгэхээр юу байна гэхээр энэ бодлогын хүү чинь 12 болохоор. Яах вэ, таны ажил гоё харагдана. Та валютын нөөц нэмэгдүүлээд гоё харагдана. Нөгөө талдаа иргэд, аж ахуйн нэгжүүд чинь өрсөлдөх чадвар байхгүй, иргэд чинь ядуурал руу орж байна шүү дээ.

Олон жил бодлогын хүү 10-аас дээш хувьтай явлаа. Намайг Эдийн засгийн байнгын хорооны дарга байхад 8 хувьтай. Та санаж байгаа байх.

Түүнээс хойш дан 10. Маш өндөр хувьтай явлаа.

Тэгээд маш том том тоонууд чинь төр дээрээ л яригддаг. Иргэдийн хаалга руу ордоггүй. Та өөрөө яах вэ дээ тэгээд л инфляц, ирээдүйн прогноз, гаднын дотнын олон нөхцөл байдал. 7.4 их тэрбум доллар. Бид 4 тэрбум доллартой 9 хувийн хүүтэй болсон шүү дээ.

Тэгээд энэ бодлого чинь өөрөө эдийн засгийг боомилж байна. Банкуудад л ашигтай байх шиг байна шүү дээ.

Та ер нь банкуудыг төлөөлөөд байна уу, хэнийг төлөөлөөд байна.

Уг нь банк чинь сайн зээлдэгч хайж байх ёстой. Танд хадгалуулах биш. Хэн сайн төсөлтэй байна. Эрсдэл үүрч байх ёстой. Үүнийг надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа байлгүй дээ.

Бусад асуулт нь давхцаж байна. Тэгээд минут бага байна л даа. Хамгийн гол нь. Яах вэ тэгээд тодруулъя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

С.Наранцогт: Монголбанкны хуримтлагдсан алдагдал 6.8 их наяд байна.

Өнөөдөр олон улсын аудитаар батлагдсан. Та хэдэд хэвлэж өгсөн баланс дээр яг ингэж туссан байгаа.

Хоёрдугаарт, тайлан хойшлуулъя гэдэг асуудал би ерөөсөө хэнтэй ч яриагүй. Өнөөдөр би хуваарийн дагуу яг цагтаа ирж хүлээж сууж байгаад оролцож байгаа. Энэ дээр жоохон буруу мэдээлэлтэй байх шиг байна. Тэрийг залруулж хэлье.

Үнэт цаасны үлдэгдэл 12.5 их наяд байна. Энэ бол түүхэн өндөр түвшинд. Банкны нийт активтай харьцуулахад 15 хувьд байна.

Яах вэ, өнгөрсөн жилийн хугацаанууд активтай. Бид анализ дүгнэлт хийгээд тантай адил би бизнесүүдийнхээ төлөө санаа зовж байгаа.

Өнгөрсөн хугацаанд яг энэ сонгодог онолоороо бол зах зээл дээрх илүүдэл мөнгийг инфляцыг хөөргөдөхгүйн тулд Төв банк татдаг. Нөгөө талд нь Засгийн

газрын үнэт цаас руу ордог. Энэ үнэт цаасны зах зээл огт хөгжөөгүй. Хөгжүүлэх талаар ерөөсөө бодоогүй.

Миний яриад байгаа энэ суурь асуудал гэдэг тухайн үедээ аргалж яваад энэ суурь асуудлуудаа шийдэхгүй явсаны гор л өнөөдөр хуримтлагдаж ирж байгаа гэсэн үг.

Бид энэ бодлогын хүүг суллаад Төвбанкны үнэт цаас дээр байгаа мөнгийг зах зээл рүү гаргавал өнөөдөр хоёр оронтой тоо руу дөхөж байгаа инфляц 20 хувьд хүрнэ. 20 хувьд хүрэх юм аж ахуйн нэгж, ард иргэдийн амьдралын чанар, аж ахуйн үйл ажиллагаа түүнээсээ илүү хүндрэл амсана. Товчхондоо ерөөсөө ийм л **dilemma**-д орчихоод байгаа юм.

Тийм учраас яах вэ Төв банкны үнэт цаасыг яаж бизнесийн тодорхой чиглэлд, юу гэдэг юм хэрэглээ, импортыг хөөргөдөггүй, нийлүүлэлтийн сүлжээг арай дэмжих чиглэлээр гаргах вэ гэдэг дээр би өөрийнхөө хүмүүсийг шахаж тодорхой тооцоо хийлгэж байгаа.

Тодорхой бодлогын механизм, тодорхой салбарын зээл. Мэдээж Төв банк дангаараа Засгийн газрын ажил хийхгүй. Засгийн газрын баримталж байгаа бодлоготой уялдуулаад өөрийнхөө зохицуулалтын механизмаар Төвбанкны үнэт цаасанд байгаа мөнгийг банкууд тодорхой бизнесийн зээл рүү гаргах ямар хөшүүрэг байж болох талаар бид богино хугацаанд.

Дунд, урт хугацаанд миний түрүүний хэлээд байгаа Засгийн газрын өөрийн үнэт цаасных нь зах зээл хөгжих ёстой. Энэ зах зээл дээр байгаа илүүдэл мөнгийг ганц Төвбанкны үнэт цаас биш Засгийн газрын үнэт цаас давхар шингээдэг болох ёстой. Энэ хөрөнгийн зах зээл өөрөө хөгжих ёстой.

Ингээд суурь шийдлүүд өөрөө давхар хийгдэх ёстой. Энэ талаар харамсалтай нь ер нь ажил хийгдээгүй явж байна. Би ажил аваад нэг улирлын туршид энэ тал дээр тодорхой санаа зовж тодорхой ажлууд, тооцоолол юмнуудыг хүмүүсээр хийлгэж байна.

Л.Соронзонболд: Ж.Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Үнэхээр 7.4 тэрбум долларын нөөцтэй бодлогын хүү буух өмнөх онуудаа харахад шүү дээ. Тийм ээ. Жишгийг харахад, анализ харахад боломжтой байна шүү дээ.

Үүнийг яагаад хэлж байгаа вэ гэхээр үнэхээр эдийн засгийнхаа цусыг нь хаачхаж байна шүү дээ.

Монголбанкны ажлын үзүүлэлт сайн, эсвэл таны ажлын үзүүлэлт сайн. Та өөрөө үүнийгээ хэлээд байна шүү дээ. Амаараа. Тэгээд хэлж чадахгүй жоохон тойруулаад л. Энэ чинь их олон жил явлаа шүү дээ.

Нэг жил, хоёр жил биш. Нэг жил, хоёр жил явж байгаа таны бодлогыг би зөв гэж үзье. Энэ чинь бараг 10 жил явчхав уу, хэдэн жил явчхав. Энэ чинь өөрөө ямар ч бидын өсөлт байхгүй. Ямар ч өрсөлдөх чадвар байхгүй. Тэгээд хадны мангаагаар айлгаад л. 4 тэрбум доллар байхад 9 хувьтай байгаад байж болсон шүү дээ.

Тэр 7.4 чинь үнэн юм уу?

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер хариулъя.

С.Наранцогт: Тийм тийм. Ж.Ганбаатар гишүүн ээ.

Бид хэд ковидын үед ажиллаж байхад тухайн үед зах зээл рүү 10 их наяд төгрөг шахсан. Зөрүүлээд бодлогын хүүгээ 6 хувь болгосон. Энэ бодлогын том алдаа байсан.

Энэ нь өөрөө инфляц өнөөдрийн удаан үргэлжлэх том инфляцыг хөөргөдсөн зах зээл дээрх мөнгийг илүү хөөсрөл бий болгосон. Үүнийгээ дарахын тулд нэлээн сүүлдэж бодлогын хүүгээ өсгөөд. Энэ бодлогын өсөлтийн хүү нь өөрөө энэ инфляцаа бууруулж чадахгүй дөнгөж сая 2 сард нэг орж ирээд ингээд буцаагаад инфляц нь өсөөд эхэлж байгаа юм.

Тэгэхээр олон жил суурь асуудлууддаа анхаарал тавихгүй.

2022 оноос хойш таныг Байнгын хорооны дарга болсноос хойш тэр юм давхцаад, нэмээд үүнээс хойш экспортын орлого нэлээн нэмэгдсэн.

Тэгэхээр экспортын орлогыг нэмэгдэхээр яаж байна вэ гэхээр... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ж.Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Тэр үед яах вэ, У.Хүрэлсүх Ерөнхийлөгч, Ерөнхий сайд байсан л даа. Тэр 10 их наядыг хэлж байх шиг байна даа. Ковидын үеийн.

Тэрийг их буруу бодлого байсан гээд байх шиг байна. Тийм ээ. Тэр үед тэр бодлогоор л бид ковидыг давсан шүү. Амжилттай давсан. Үнэхээр тэр маш зөв бодлого байсны хүчинд бид тэр үеийн хүндрэлийг давсан шүү.

Тэгээд өөрөөсөө зугтаалгаад, янз янзын юм яриад. Би одоо ингээд бүтэн санаагаа илэрхийлэх боломжгүй байна л даа. Минут хязгаарлагдмал. Танв шиг ингээд сунгуулаад байж болохгүй юм. Намайг сунгаж өгөхгүй байна л даа. Нэг мэг минут гээд.

Тэгэхээр одоо ингээд 7.4 тэрбум долларын нөөцтэй. Тэгээд бодлогын хүү удаан. Маш удаан шүү. Та бусад улсуудтайгаа харьцуулаарай.

Санал хэллээ. Дуусаж байгаа юм чинь.

Л.Соронзонболд: О.Батнайрамдал гишүүн асууя.

О.Батнайрамдал: Оройн мэнд хүргэе.

Маш тодорхой хоёр л асуулт асуумаар байгаа юм. Шууд Оюу Толгойтой холбоотой.

▷ **Нэгдүгээрт**, өнөөдрийн байдлаар Оюу Толгойн 2025 оны борлуулалтын орлого бараг 4.9 тэрбум доллар. Нэг ёсондоо 5 орчим тэрбум доллар.

→ 5 тэрбум долларын орлогын хэдэн хувь нь Монголбанк болон арилжааны банкаар дамжсан бэ?

→ 5 тэрбум доллар өнөөдөр Монголын эдийн засгаар дамжихад Монголын эдийн засаг тийм дийлэхгүй жижигхэн юм уу? Тийм боломж байна уу?

→ Энэ дээр Та ямар байр суурьтай байгаа вэ?

120 дугаар тогтоолоор маш ойлгомжтой зааж өгсөн л дөө. Оюу Толгойн экспортын 100 хувийн орлого Монголбанк болон арилжааны банкаар дамжих ёстой гэж. Одоо энэ маш олон жил ярьсаар байгаад энэ тогтоолд орсон. Тийм ээ.

Энэ хэрэгжвэл Монголын эдийн засагт буцаад валютын нөөц болон макро эдийн засагт яг ямар ач холбогдолтой гэж Та үзэж байна? Энэ боломжтой юу? Монголбанкны Ерөнхийлөгчийн хувьд.

▷ **Хоёрдугаарт**, жилийн тайлангийнхаа 19 дүгээр хуудсыг Та бүхэн нэг хараадхаач. Энэ дээр бүгдээрээ нэг жоохон анализ хийе. Жилийн тайлангийн 19 дүгээр хуудсан дээр Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ байна.

2021-2025 оны хооронд Монгол Улсын нийт гадаад өр 33.8-аас 40 тэрбум доллар болж, 7 тэрбум доллароор нийт гадаад өр өссөн байна.

Энэ хооронд Засгийн газрын өр болон Төвбанкны өр харин эсрэгээрээ нэлээн сайн зохицуулалт хийж, сахилга баттай байснаас буусан. Тийм ээ. Буусан байна. Төвбанкны 2.6 тэрбум долларын өр 1 тэрбум болтлоо буусан байна. Засгийн газрын өр энэ дээр нэг их өсөөгүй байна.

Гэхдээ энэ дээр юу өссөн бэ гэхээрээ энэ өсөлтийн бараг 90 орчим хувь нь хөрөнгө оруулагчаас авсан зээл буюу дийлэнх нь, бараг 95 орчим нь Оюу Толгойн зээл л дээ.

Оюу Толгойн зээл нэг ёсондоо 2021 онд Монгол Улсын нийт гадаад өрийн 36 хувийг эзэлдэг байсан бол 2025 онд энэ 45 хувь болж томорсон байна.

Тэгэхээр энэ Оюу Толгойн өр сүүлийн 4 жил огцом өсөхөөр Монгол Улсын зээлжих зэрэглэлд эерэг нөлөө үзүүлсэн үү, сөрөг нөлөө үзүүлсэн үү?

Нэг компанийн өр Монгол Улсын нийт өрийн бараг 40, 50 хувийг эзлэхээр зээлжих зэрэглэл болон өнөөдрийн бидний төлж байгаа зээлийн хүүд ямар эерэг нөлөө үзүүлдэг үү? Сөрөг нөлөө үзүүлдэг үү? Үүнийг Та тийм, үгүй гэж байхад маш тодорхой надад хариулаад өгөөч.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

С.Наранцогт: Оюу Толгойгоос орж ирж байгаа валютын талаар тодорхой хариулт өгье.

Тэгэхээр Төв банк Монгол Улсын валютын нөөцийг удирддаг мандатынхаа хүрээнд манай гол экспортлогч компаниудын мэдээ, тайланг тогтмол авдаг, хяналт тавьдаг.

Ер нь Оюу Толгой –

- 2023 онд борлуулалтынхаа 60 хувийг,
- 2024 онд борлуулалтынхаа 69 хувийг,
- 2025 онд борлуулалтынхаа 48 хувийг,
- 2026 оны 3 сарын байдлаар 57 хувийг –

-Монгол Улс руу оруулж ирсэн байна.

Оруулж ирсэн доллароо Оюу Толгой ямар зарчмаар явж ирсэн бэ гэхээр талыг нь Монголбанканд тушаадаг. Энэ бол үндсэндээ Монголбанк нөгөө шууд тушаах тийм эрх зүйн юугүй учраас иргэний хэлэлцээрийн журмаар авдаг. Талыг нь арилжааны банкуудад борлуулдаг. Ингэж явж ирсэн.

Ийм тогтоол гарсан, үүнийг хэрэгжүүлж ажиллахыг төлөвлөгөөгөө гаргаж хэрэгжүүлж ажиллана уу гэдэг албан бичгийг хүргүүлсэн байгаа.

Монгол Улсад валют орж ирээд валютын нөөц нэмэх нь Монгол Улсын эдийн засгийн дархлааг сайжруулахад маш чухал ач холбогдолтой.

Тийм учраас Монголбанкнаас барьж байгаа бодлого бол Монгол Улсад олборлосон алтыг Монгол Улсад тушаах, экспортын компаниудынхаа орлогыг аль болох валютын нөөцөө нэмэгдүүлэх чиглэлд. Ганц Оюу Толгой гэлтгүй бусад компаниуд руу ч гэсэн бид албан бичиг хүргүүлж байгаа.

Өөрөөр хэлбэл бид захиргааны аргаар хүчлэх мандат байхгүй.

Гэхдээ Та бүхэн борлуулалтынхаа орлогыг Монгол Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр оруулж ирэх ёстой гээд.

Яах вэ, энэ хоёр талтай. Төв банк **market maker**_[зах зээлийг бүрдүүлэгч]-ийг өөрөө хийгээд байгаа нь манай эдийн засаг онцлогтой.

- Олон импортлогч,
- Цөөхөн экспортлогч–

-байдаг учраас ийм явж ирсэн. Суурь асуудал бол валют, мөнгөний зах зээл хөгжих ёстой. Үүнийг бид дунд хугацаандаа хөгжүүлэх төлөвлөгөө гаргаж байгаа.

Ингэж байж зах зээлийнхээ зарчимд нийцэх ёстой.

Аль болох экспортлогч компаниудын орлогыг Монгол Улсад оруулж ирж валютын нөөцийг нэмэгдүүлэх ёстой гэдэгтэй тантай би 100 хувь санал нэг байна.

Энэ дээр байр суурь гэсэн учраас байр суурийн хувьд би энэ зүйлийг илэрхийлье.

Өмнөх Монгол Улсын өрд бүртгэгдэж байгаа хөрөнгө оруулалтын статистикийг Та асууж байна. Таны ажиглалт зөв. 90 хувь нь Оюу Толгойн хөрөнгө оруулалтын зээл байгаа.

Энэ нь хоёр талтай юм. Нэг эерэг тал нь манай санхүүгийн дансанд төлбөрийн тэнцэл нь бүртгэгддэг.

Тэгэхээр бид чинь жил болгон урсгал дансандаа 2 тэрбум орчим долларын алдагдалтай явдаг. Үүнийг санхүүгийн дансаараа олон жил нөхөж ирсэн. Энэ дээр Оюу Толгойн зээл манай санхүүгийн дансанд төлбөрийн тэнцлийн алдагдлыг нөхөж ирсэн сайн талтай.

Би яг ний нуугүй хэлэхэд зээлжих зэрэглэлийг тогтоож байгаа компаниуд хөрөнгө оруулалт талаас нь харж байгаа болов уу. Яг одоогоор надад үүнээс болж зээлжих зэрэглэл дээр ийм нөлөө үзүүлсэн гэдэг мэдээлэл надад байхгүй байна.

Яах вэ, бүтцээр нь л анализ хийнэ л дээ.

Ер нь хөрөнгө оруулалт гэдэг утгаараа их буруу зүйл. Манайх шиг хөгжиж байгаа оронд биш. Зүгээр бидний... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер. Гүйцээж хариулъя.

С.Наранцогт: Энэ ингээд “хөрөнгө оруулалтын зээл” гэж орж ирээд Монгол Улсад хөрөнгө оруулалт хийгдэх нь буруу зүйл биш.

Харин тухайн хөрөнгө оруулалтаас таны яриад байгаа өнцөг бол Монгол Улсын хүртэх үр өгөөж хэр байна вэ л гэдэг асуудал яригдаад байгаа шүү дээ.

Тэгэхээр хөрөнгө оруулалт их хэмжээгээр ороод, түүнээс Монгол Улсад ногдох үр ашиг, бидний нөгөө Ораногийн гэрээн дээр хийсэн шууд хүртэх үр өгөөж нэмэгдэж байвал энэ сайн үзүүлэлт, сайн өр гэж бид үзэх ёстой.

Хэрэв тэр өр болоод, түүнээс хүртэх үр өгөөж муу байгаа асуудал бол тусдаа асуудал.

Л.Соронзонболд: О.Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: Оюу Толгойн хөрөнгө оруулалтыг буруутгаж байгаа зүйл ерөөсөө биш ээ.

Компанийн зүгээс авч үзье л дээ. Аливаа компанийн хэр эрүүл бүтэцтэй вэ гэдгийг нь **capital structure** гээд компанийн санхүүжилтийн бүтцийг нь хардаг.

Оюу Толгойн өнөөдрийн санхүүжилтийн бүтцийг аваад үзэхээр нийт хөрөнгө санхүүжилтийнх нь 84-өөс 86 хувь нь зээл, зээлийн хүү нь ордог байхгүй юу.

Тэгэхээр ямар ч компанид 86 хувь нь нийт санхүүжилт байна гэдэг бол өөрөө эрүүл биш бүтэц. Энэ нь буцаад Монгол Улсын макро эдийн засгийн нийт зээлийн чинь бүтцэд сөргөөр нөлөөлөөд байна л гэж хэлэх гээд байгаа юм л даа.

Тэгэхээр тэр дээр Та бөөрөнхийлөөд байна. Яг точный хариулмаар байна. Яг Оюу Толгойн энэ зээл.

Яагаад гэх юм бол энэ Оюу Толгой дээр байгаа нийт зээлийн чинь бараг 60 хувь нь зээлийн хүү байхгүй юу. Хүүгийн хүү тооцсоор байгаад зээлийн хүү чинь өөрөө бичигдэж байгаа монголын нийт өрийг чинь Оюу Толгойн өрийн чинь 50, 60 хувь нь болоод байна шүү дээ.

Энэ нь буцаад бидний зээлжих зэрэглэл болон зээлжих зэрэглэлээр дамжуулаад эрсдэлээр бидний өнөөдөр энэ өндөр хүүд шууд холбоотой... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

С.Наранцогт: Би танд шулуухан хариулъя.

Компанийн санхүүжилтийн бүтцээрээ муу бүтэцтэй байгаа гэдэгтэй санал нэг байна. Дээр нь энэ хүү тооцогдож байгаа, тэгээд зээлийн хүү өндөр байгаа талаар Та ярьж байгаа. Энэ дээр бид бүгдээрээ л санал нэг байгаа.

Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын санхүүжилт компанийн санхүү талаасаа муу бүтэцтэй байгаа гэдэгтэй би Тантай санал нэг байна.

Харин би нөгөө том эдийн засгийн төлбөрийн тэнцэл талаасаа эерэг нөлөө байгаа гэдэг зүйлийг түрүүн хэлсэн юм.

Өөрөөр хэлбэл манайх шиг урсгал дансны алдагдалтай явж байгаа улсад хөрөнгө оруулалтаар санхүүгийн дансаар хөрөнгө оруулалт орж ирэх нь энэ алдагдлыг нөхөж байгаа юм.

Тийм учраас бид 2025 онд манай төлбөрийн тэнцэл 1 тэрбум долларын ашигтай гарч байгаа чинь ерөөсөө л үүнээс болсон гэсэн үг. Одоо харин энэ далд уурхайн бүтээн байгуулалт нь зогсоод эргээд буцаад энэ санхүүжилтийн дансны орж ирдэг юм нь байхгүй болохоор манай... /минут дуусав/

Л.Соронзонболд: О.Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: Та маш чухал зүйлийг хамгийн сүүлд хөндчихлөө. Нөгөө **CAPEX** (Capital Expenditure) буюу нийт тэр далд уурхайн том бүтээн байгуулалтаар орж ирдэг хөрөнгө оруулалт 2025 он хүрээд дууссан. Далд уурхайн бүтээн байгуулалт дууссан.

Тэгэхээр энэ орон зайн урсгалыг юугаар нөхөх ёстой вэ гэвэл борлуулалтын орлогоо тэгвэл 100 хувь монголоор дамжуулах. Одоо жишээлбэл 57 орчим хувь л байна шүү дээ.

Үүнийгээ 100 болгох юм бол тэр эерэг нөлөө чинь буцаад тэр капитал хөрөнгө оруулалт байхгүй нөлөөг тэнцвэржүүлж оруулж ирэх боломж гэж хараад байгаа юм.

Тэгэхээр тогтоолоор өгөгдсөн учраас энэ өөрөө хууль шүү дээ.

Тэгэхээр Та ч гэсэн үүнийг хэрэгжүүлэх ёстой гэж үзэж байгаа юм. 100 хувь Монголоор арилжааны банк болон Монголбанкаар гэж бид оруулсан шүү дээ. Тийм ээ.

Та энэ дээр манлайлж ажиллах ёстой шүү. Энэ буцаад магадгүй макро эдийн засгийн тэнцвэртэй байдалд хамгийн өндөр нөлөөтэй байж болох хувилбар гэж хараад байгаа юм л даа.

Тэгэхээр энэ дээр нэмэлт тайлбар авчихъя.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын 120 дугаар тогтоол маань Монгол Улсын Засгийн газарт өгсөн үүрэг даалгавар дотор байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр Монголбанк зүгээр байр сууриа илэрхийлэх үүднээсээ ажлын хэсгийн 5 номер хариулъя.

С.Наранцогт: Валют орж ирэх, Монгол Улсын төлбөрийн тэнцэл сайжрах. Энэ дээр эерэг бүх л зүйлийг Төвбанкны зүгээс дэмжиж ажиллах ёстой. Ялангуяа шууд хөрөнгө оруулалтыг.

Тийм учраас энэ хөрөнгө оруулалтын тасалдлыг бид энэ суурь асуудлуудаа шийдэж, Монгол Улсын макро эдийн засгийн суурь сайжирч байж хөрөнгө оруулалт дахь итгэл бий болж, хөрөнгө оруулалт нэмэгдэх ёстой гэсэн байр суурьтай байна.

Тогтоолын хэрэгжилтийн хувьд Л.Соронзонболд гишүүн хэлж байгаа.

Төв банканд дээр тухайлан нэг компанийн данс нээж юу яадаг тийм юу байхгүй. Түрүүн би нэлээн тайлбарлалаа. Бид борлуулалтынхаа орлогыг Төв банканд валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр тушаах энэ зүйлийг иргэний хуулийн харилцаагаар компаниудад албан бичиг хүргүүлж, тухайлбал, Оюу Толгой компанид тэр тогтоолын хэрэгжилтийг... /минут дуусав/

Л.Соронзонболд: Ж.Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Монголбанканд алт тушаалтын талаар өнгөрсөн 2 жилийг харьцуулаад Та нэг мэдээлэл өгөөч?

Алтны тушаалт сайжирч л байвал мэдээж хэрэгтэй байдаг. Харахаар алтны үнэ өсөөд, олборлолт нь дагаад өсөөд, тушаалт нь байхгүй болдог.

Тэгэхээр нэг талаас яах вэ, үнэ өсөж байгаа учраас өөртөө хадгалдаг нэг тийм илүү их үнэ хүрэх гэсэн юм байгаа байх. Нөгөө талдаа хууль бус наймаа. Тэгээд банканд аваачаад тушаахаар татвар, АМНАТ гээд юм болдог. Түүнээс нь зугтаалгаад нэг дундын зуучлагчаар зарчихдаг. Эсвэл зүгээр хамаагүй юмаа төлье гэсэн хүн байлаа ч гэсэн нөгөө алтаа хармаалаад Улаанбаатар хот руу явж байдаг юм байдаггүй.

Тэгэхээр Монголбанкны нэг ийм салбар алт хураадаг тэр жижиг үйлдвэрлэл, олборлогч дээр нь хүрдэг ийм зүйл бодож байгаа, төлөвлөж байгаа юм байгаа юу.

Гурав дахь нэг юм нь болохоор энэ дундаас авсан тэр татваргүй хямдруулж авсан хар юм нь хилээр гараад байгаа тийм хардалт яваад байдаг.

Тэгээд надад бол нэг албан бус зүгээр аналитик нээлттэй мэдээлэл дээр хийсэн судалгаа ярьсан. Бид 3-аас 4 тонн алт алдаж байгаа юм байна даа гэдэг нэг ийм үнэлгээ.

Тэгэхээр Та бүхэн дээр хэдийгээр Монголбанкны өөрийнх нь хариуцах нөлөөлөх зүйл тэр хилийн хянан шалгах байна уу, хууль бус наймаа биш ч гэсэн ерөнхий нэг судалгаа байгаа байх.

→ Явал алтны тушаалтыг нэмэгдүүлэх вэ?

Эсвэл Монголбанк жижиг олборлогч дээр хүрч очиж алт тушаалтыг нэмэгдүүлэх ямар нэгэн арга зам байна уу? Энэ тал дээр бодож байгаа зүйл байвал мэдээлэл хуваалцана уу.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номер.

С.Наранцогт: Ж.Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Сүүлийн 2 жилийн мэдээлэл –

- 2024 онд 16.4 тонн,
- 2025 онд 16.3 тонн тушаагдсан. Төв банканд.

Тантай энэ алтны тушаалтныг нэмэгдүүлэх ёстой, сайжруулах ёстой гээд энэ дээр анхаарал тавьж ажиллаж байна. Тухайлбал, Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулга Төв банкнаас албан ёсоор алттай холбоотой саналыг хүргүүлсэн. Хуулийнх нь төсөлд яамнаас орж байгаа болов уу гэдэг ийм хүлээлттэй байна.

Өөрөөр хэлбэл бид алт тушаалтыг нэмэгдүүлэх бодлогын хөшүүрэг хэрэгтэй гэж үзэж байгаа.

Хоёрдугаарт, судалгаа тантай адил хийж байгаа.

Би ажил авснаас хойш ганц алт биш хоёр зүйл дээр хууль хяналтын байгууллагатай биечлэн уулзаж, албан хүсэлт тавьж байгаа.

Тэр нь юу вэ гэхээр хилээр гарч байгаа бэлэн болоод хууль бус аргаар гадагшилж байгаа валют, алт. Валют дээр хууль хяналтын байгууллага дээр тодорхой үр дүнгүүд гарсан. Нөгөө тал дээр хуулийн байгууллагад нэг саналыг хүргүүлж байгаа.

Бидний хийсэн судалгаагаар аж ахуйн нэгжийн борлуулалт чинь 25 тэрбумаас шатлал нь татвар нэлээн өндөр болдог учраас алт тушаагчдын хувьд ачаалал яг энэ дээр гарч ирдэг байх магадлал гарч ирж байгаа.

Өмнө нь 20 гаруй тонн алт тушаадаг байх үед жижиг хувиараа алт тушаагчдын 60 гаруй хувийг нь тушаадаг байсан юм билээ. Энэ ерөөсөө багассан. Үүнийг яах вэ, шороон орд, үндсэн орд, шороон орд дууссан гээд тайлбарууд байгаа ч гэсэн энэ алт тушааж байгаа иргэд дээр татварын болоод хэрэг үүсгэсэн тохиолдол маш их байна лээ.

Тэгээд үүнийг Та хэд анхаарч үзээч ээ.

Ингээд улсын валютын нөөц тушаадаг улсууд дээрээ ямар нэгэн байдлаар хэрэг үүсгээд байвал энэ өөр зам руу орно гэдэг ийм дүгнэлт байгаа.

Нөгөө талдаа манай алтыг гол худалдаж авдаг, алт цэвэршүүлдэг компанийнхаа санаачилгаар дэлхийн алт хэрэглэдэг томоохон брэндүүд манай алт олборлогчидтой хамтарч ажиллаж, дэмжлэг үзүүлэх чиглэлээр тодорхой хөтөлбөр Төв банканд дээр гараад хэрэгжиж байгаа.

Үүнийг бид дэмжиж ажиллана. Энэ хавар дэлхийн luxury brand-үүдийн төлөөлөл, алт хэрэглэдэг брэндүүд манай дээр ирж таны хэлсэн хөдөө орон нутагт ажиллах гэж байгаа.

Тэгээд иймэрхүү байдлаар Төв банканд дээр онцгой анхаарал тавьж байгаа.

Өмнө нь ковидын үед хэрэглэж байсан алт худалдан авалт дээр Төв банк тодорхой хөшүүрэг премиум хэрэглэх ийм бодлого байгаа.

Тэгээд хууль эрх зүйн зайлшгүй өөрчлөлт хэрэгтэй юм билээ. Тэгээд энэ нь хууль эрх зүйн өөрчлөлтийг бид хөндөж байгаа.

Л.Соронзонболд: Би хэдэн асуулт асууя.

Энэ арилжааны банкуудын нэгдсэн тайлангаас харахаар дотоодын хадгаламж, харилцаагаар татсан эх үүсвэрээрээ Монголд байгаа зээлийнхээ 60 гаруй хувийг хангаад, үлдсэн хувийг нь бид гадаадын санхүүгийн байгууллагаас зээлж авч байгаа.

Өөрөөр хэлбэл Монголд байхгүй эх үүсвэрийг гаднаас оруулж ирээд, тэгээд түүгээрээ зээл олгохоор манай свопын зардал өндөр байгаад байна.

Дээрээс нь заавал байлгах нөөц тооцуулдаг гээд. Ингээд нөгөө зээлийн хүүг бууруулах гэдэг стратегийнхаа эсрэг ийм бодлогууд. Монголд байхгүй мөнгийг оруулж ирээд байхад тэрнийхээ зардлыг нэмээд ингээд зээлийн хүүгээ өсгөөд байгаа юм биш үү гэдэг нэг ийм асуулт байгаа юм.

Энэ дээр ер нь ямар байр суурьтай байгаа юм бэ гээд нэгдүгээр асуулт.

Дараагийн асуулт юу байна вэ гэхээр Та хөрөнгийн зах зээл Монголд хөгжөөгүй байна. Үүнийг хөгжүүлэх хэрэгтэй гээд байдаг. Гэтэл Банкны тухай хуулиараа болохоор нөгөө арилжааны банк чинь өөрийн хөрөнгийнхөө 20 хувьтай тэнцэх хэмжээгээр л зөвхөн хөрөнгийн зах зээл рүү байршуулах ийм боломжтой байгаад байгаа.

Тэгэхээр нөгөө оруулж ирж байгаа Банкны тухай хуулийн өөрчлөлтүүдээр Төвбанкны тухай хуулиас гадна Банкны тухай хууль дээр орж байгаа өөрчлөлтүүдээр энэ талын асуудал тусгагдаж байгаа юу? Нөгөө өөрийн

хөрөнгийн 20 хувийн нэг хувьцаа эзэмшигчийн хязгаараас гадна өөр ямар саналууд орж байгаа вэ гэдэг ийм хоёрдугаар асуулт байна.

Гуравт болохоор саяхан Эдийн засгийн байнгын хороогоор Зоос банкны жижиг хувьцаа эзэмшигч гээд хүн орж ирж гомдол танилцуулж байсан.

Ер нь Зоос банктай холбоотой энэ өр барагдуулалтын асуудал маш удаан хугацаанд явж байгаа.

Гэтэл Зоос банкны одоо байгаа өр, авлага дотор нь нэлээн боломжийн өндөр үнэлгээтэй тийм орд байгаа юм байна гэж ойлгосон. Тэр ордыг хэрвээ жишээлбэл одоогийн зах зээлийн үнэлгээний тодорхой хэмжээнд зарж чадах юм бол одоо байгаа өрөө бүгдийг нь төлөөд, тэгээд цаана нь байгаа жижиг хувьцаа эзэмшигчдэд хүртэл мөнгө өгөх боломж байна гэсэн ийм асуудал ярьсан. Энэ тал дээр мэдээлэл авъя гэж бодож байна.

Эхний ээлжид энэ гурван асуулт дээрээ хариулт авъя.

С.Наранцогт: Таны хэлж байгаа ажигласан ажиглалт үнэн.

Манай банкуудын гадаад пассив өнгөрсөн жил ялангуяа нэлээдгүй хэмжээгээр нэмэгдсэн. Гадаад эх үүсвэрээр зээл олж байгаа. Энэ дээр урт хугацааны своп хэлцэл Төв банк хийж байгаа. Энэ хэлцлийн өртөг нэмэгдэж байгаа. Энэ нь хүү тогтоход нөлөөлж байгаа нь үнэн.

Тэгэхдээ бидний дотоод эх үүсвэр, гадаад эх үүсвэр, зээлийн хэрэгцээ шаардлага хоёр зах зээлийн зарчим дээр тогтоод байгаа учраас энэ харилцаа явж байна гэсэн үг.

Бидний хувьд юу гэж үзэж байгаа вэ гэхээр тогтвортой, урт хугацааны гадаад эх үүсвэр банкуудын маань энэ оруулж ирж байгаа хөрөнгө бол Монгол Улсын валютын нөөц, гадаад төлбөр гүйцэтгэх чадварт чухал нөлөөтэй учраас ялангуяа урт хугацаат эх үүсвэр татахыг урамшуулах ийм бодлого барьж байгаа.

Ялангуяа энэ жилийн хувьд гадаад нөхцөл байдал, гадаад санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал тийм сайнгүй. Ийм дүр зураг цаашдаа ч тийм сайнгүй байх. Энэ жилийн хувьд ийм дүр зураг харагдаж байгаа учраас бид банкуудыгаа 3-аас дээш жилийн хугацаатай эх үүсвэр татахдаа тодорхой дэмжлэг үзүүлэх бодлого барьж байна.

Яах вэ, үүнийг урт хугацаат свопын зардлыг хүчээр буулгана гэвэл бид Төвбанкны алдагдал буцаагаад нэмэгдэх ийм зүйл байгаа.

Тэгэхээр гадаад банк, гаднын урт хугацаатай хямд эх үүсвэр оруулах бодлогын дэмжлэгийг бид Төв банкнаас тууштай баримталж байгаа.

Та бид хаврын уулзалтад явах үеэр ч гэсэн гаднын олон улсын байгууллагуудтай энэ талаар нэлээдгүй эерэг яриа хэлэлцээрүүд хийгдсэн. Яриа хэлэлцээр үргэлжлээд хамтын ажиллагаа явагдаж байгаа. Энэ дээр бид ийм байгаа. Заавал байлгах нөөц дээр урт хугацаат энэ своп орохгүй байгаа.

Тэгээд яах вэ, богино хугацаатайг нь бид 10 сараас эхлээд 0.25 хувиар эхлээд ингээд цаашаа үргэлжлүүлж байгаа нь нөгөө бодлогын хөшүүрэг л хэрэглэж байгаа учиртай. Бид гадаад өрийн **refinance** хийх энэ орон зай муудах вий гэдэг ийм болгоомжлол байгаа учраас санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх үүднээсээ л ийм бодлогын хөшүүрэг хэрэглэж байгаа.

Эрх хүлээн авагч дээр удаж байгаа үйл ажиллагаа нь тааруухан байгааг Та ярилаа. Энэ дээр бид санал нэг байна.

Манай Хяналт шалгалтын хороогоор энэ эрх хүлээн авагчийн үйл ажиллагаа дүгнэлт хийгээд тодорхой өөрчлөлт орж байгаа. Томилгоо зүйл хийгдэж байгаа. Тэр яригдаж байгаа лицензийн хувьд ч гэсэн үнэхээр тэр өр ширээ дарах ийм лицензийг нь худалдаж авах хөрөнгө оруулагч байх юм бол үүнийг Төвбанкны зүгээс шууд дэмжих ёстой.

Ингээд энэ өр шир нь барагдаад, тэгээд тухайн үнэхээр боломжтой лиценз байгаа бол тэр нь эдийн засгийн эргэлтэд ороод явах юм бол тал талдаа энэ бол зөв гэж үзэж байгаа. Тэр жижиг хувьцаа эзэмшихийн гомдлын асуудал бол яг нөгөө хуулийнхаа л журмаар явж байгаа юм байна лээ. Дараалал тогтсон тэр дарааллаараа.

Л.Соронзонболд: Хуулийн өөрчлөлтийн асуудал дээр.

С.Наранцогт: Тийм. Хуулийн өөрчлөлтийн асуудал дээр яг үнэндээ би сая Та бүхэнд ярьсан. Хоёр үе шаттай бид хуулийн өөрчлөлтийг хийж байгаа.

Банкны хуулийн өөрчлөлт дээр энэ нэг хувьцаа эзэмшигчийн эзэмшлийг арай бодитой... /минут дуусав/

Л.Соронзонболд: 5 номер гүйцээж хариулъя.

С.Наранцогт: Үндсэндээ Төвбанкны хуулийн өөрчлөлт ч тэр, Банкны тухай хуулийн өөрчлөлт дээр яг тодорхой бодлого чиглэлийн хувьд эхний тулгамдаж байгаа өөрчлөлтөө хийе гэж үзэж байгаа.

Өөрөөр хэлбэл, гадаадын банк, гадаадын хөрөнгө оруулалт манай банкуудад орж ирэх энэ боломж руу түлхүү чиглэж байгаа.

Тухайлбал, Банкны толгой компани байгуулах боломж гадаадын банкууд дээр нөгөө компани хэлбэрээр буюу салбар хэлбэрээр орж ирэхэд тэрний зохицуулалтуудыг нэлээн тодорхой болгож өгч байгаа.

Нэмээд нэг хувьцаа эзэмшигчийн дээд хязгаарыг Компанийн тухай хуультай нийцүүлж тодорхой бодитой болгож оруулж ирэхээр ингэж өөрчлөлтийг оруулж ирсэн байгаа.

Яг таны асуулттай асуусан зохицуулалт яг энэ удаагийн өөрчлөлтөөр ороогүй. Би түрүүн хэлсэн. Дараагийн шинэчилсэн найруулга... /минут дуусав/

Л.Соронзонболд: Тэгэхээр яах вэ, бид гадаадын банк, гадаадын хөрөнгө оруулалт орж ирэхийг хүлээсээр байгаад нэлээн олон жил боллоо.

Тэгэхээр гаднаас эх үүсвэр татаж чадаж байгаа эсэхийгээ дэмжих тал дээр нэлээн бодлогоо чиглүүлэх ёстой юм биш үү гэж зарим Их Хурлын гишүүд яриад байгаа юм. Тэр их зөв санал юм болов уу гэж бодоод байгаа байхгүй юу. Заавал гадаадын банк оруулж ирж байхаар өнөөдөр гадаадаас эх үүсвэр татаж оруулж ирж чадаж байгаа компаниуд, банк, санхүүгийн байгууллагуудаа дэмжих энэ тал руу бодлогоо чиглүүлэх тэгээд явсаар байгаад нөгөө татаж ирсэн мөнгө нь свопын зардал дээр оччихоод тодорхой хэмжээний асуудалд ороод байгаа байхгүй юу.

Тэгээд миний ойлгосноор арилжааны банкуудын свопын зардал 8 хувь болсон юм байна гэж ойлгосон.

Тэгэхээр чинь 8 хувь дээр гаднаас эх үүсвэр татаад, дээр нь дахиад 8 хувь нэмчихээр чинь төгрөгийн 16 хувь болчихож байгаа юм. Ашиг хийнэ гэхээр чинь дахиад 20 хувиар зээл өгөхөөс аргагүй болоод ийм байдалд байна.

Тийм учраас энэ тал дээр нэлээн анхаарах ёстой. Тэртээ тэргүй Монгол Улсад байхгүй мөнгийг гаднаас оруулж ирж байгаа асуудал дээр жоохон анхаарах ёстой юм болов уу гэж хэлмээр санагдаад байгаа юм.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Монголбанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа. /алх цохив/

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд ажлын хэсгүүдэд баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 4 цаг 17 минут үргэлжилж, 18 цаг 43 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД